

“БОЛОВСРОЛ” БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ



Хамт олонд түшиглэн сэргээн засах хандлагын

УДИРДАМЖ



ДЭМБ-ын Номын сангийн каталоги

Хамт Олонд Түшиглэн Сэргээн Засах Хандлага: ХОТСЗ хандлагын Удирдамж

1.Сэргээн засалт. 2.Хөгжлийн бэрхшээлтэй иргэн. 3.Хамт олонд түшиглэсэн эрүүл мэндийн үйлчилгээ. 4.Эрүүл мэндийн бодлого. 5.Хүний эрх. 6.Нийгмийн шударга ёс. 7.Хэрэглэгчийн оролцоо. 8.Удирдамж. I.Дэлхийн эрүүл мэндийн байгууллага. II.НҮБ-ын Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Байгууллага. III.Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага. IV. Хөгжлийн бэрхшээл, Хөгжлийн олон улсын консорциум

ISBN 978 92 4154805 2

(NLM ангилал: WB 320)

© Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага 2010

Бүх эрх хадгалагдсан. Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын хэвлэлийг WHO Press, World Health Organization, 20 Avenue, 1211 Geneva 27, Switzerland (tel: +41 22 791 3264; fax: +41 22 791 4857; e-mail: bookorder@who.int) -аас авч болно. ДЭМБ-ын хэвлэлийг орчуулах эсвэл дахин боловсруулж зарах эсвэл арилжааны бус байдлаар хэрэглэх алинд нь ч зөвшөөрөл авах ба ДЭМБ-ын Хэвлэлийн газарт дээр дурдсан хаягаар (fax: +41 22 791 4806; e-mail: permission@who.int) хандана.

Энэхүү хэвлэлийн дотоод агуулга нь Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын үзэл бодлыг илэрхийлэхгүй. Газрын зурган дээрх цэгэн зураас хилийг ойролцоогоор төлөөлсөн.


Үүнд дурдагдсан тухайн онцгойлсон компани эсвэл үйлдвэрлэгчийн бүтээгдэхүүн нь Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас зөвлөсөн эсвэл зөвшөөрсөн гэсэн үг биш.

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага энэхүү хэвлэлд орж буй мэдээллийг баталгаажуулж бүх боломжит урьдчилан сэргийлэх аргуудыг авсан хэдий ч уг хэвлэлийг ямар нэгэн илэрхийлэл, зөвшөөрлийн баталгаагүйгээр тараасан болно. Орчуулгын хариуцлага болон уг материалыг ашиглах эрх нь уншигч танд буй. Үүнийг ашиглахад гарах ямар нэгэн хохирлыг Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага хариуцахгүй.

Хэвлэлийн дизайн, загварыг Inis Communication

www.iniscommunication.com

Мальтад хэвлэв.



Энэхүү товхимлыг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвшөөрөлтэйгөөр Дэлхийн Зөн Монгол Олон Улсын Байгууллагын “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн гэрэлт ирээдүй” төслийн санхүүжилтээр 600 хувь хэвлэв.

СЗСҮТ

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 7-р хороо, Эрхүүгийн гудамж, Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв
20-р салбар, Ш,х: №364
Утас:352423
Цахим шуудан: info@nrc.gov.mn
Цахим хуудас: www.nrc.gov.mn

АИФО

Холбоо барих хаяг:
АИФО байгууллагын Монгол дахь суурин төлөөлөгчийн газар
Улаанбаатар 210648, Ш,х:75
Утас: 70153058

Дэлхийн зөн

Холбоо барих хаяг:
Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 13-р хороолол, 15-р хороо, (133-70), Энхтайвны өргөн чөлөө, 49-р барилга, Соманг плаза, 4-р давхар, Улаанбаатар 15160,
Шуудангийн хайрцаг 705
Вэб: <http://www.wvi.org/mongolia>

Орчуулсан: П.Чимэддулам, СЗСҮТ-ийн МБУЧОС-ийн сургалтын менежер

Хянасан: Г.Түвшинжаргал, СЗСҮТ-ийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Б.Жавхлан, СЗСҮТ-ийн Мэдээлэл технологийн мэргэжилтэн

ХАМТ ОЛОНД ТҮШИГЛЭН СЭРГЭЭН ЗАСАХ ХАНДЛАГЫН УДИРДАМЖ

“Боловсрол” бүрэлдэхүүн хэсэг

Агуулга:

Өмнөх үг.....	04
Бага насны хүүхдэд үзүүлэх анхаарал халамж ба боловсрол.....	14
Бага боловсрол.....	30
Дунд болон дээд боловсрол.....	48
Албан бус боловсрол.....	58
Насан туршид суралцах.....	68

ӨМНӨХ ҮГ

Боловсрол гэдэг нь хүмүүс насан туршдаа өөрсдийн боломж, чадлынхаа хирээр хүссэн, хэрэгцээт зүйлээ суралцах явдал юм. Энэ нь “мэдэх, хийж бүтээх, хамтдаа амьдрах ба оршин байхын тулд суралцаж байгаа хэрэг” болно. Боловсролыг гэр бүлд, олон нийтэд, сургуулиудад, хүрээлэнгүүдэд болон нийгмийн бүхий л хүрээнд олгож байдаг. Боловсрол эзэмших эрхийг бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн олон улсын баримт бичгүүдэд баталгаажуулсан. Үүнд: Олон Улсын Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал, 26–р зүйл (2), Хүүхдийн Эрхийн Конвенц, 28-р зүйл (3). Олон улсын баримт бичгүүдэд хүүхдүүдэд ялгаварлан гадуурхахгүйгээр анхан шатны боловсролыг үнэ төлбөргүйгээр заавал олгох ёстой гэж заасан байдаг ч энэ нь амьдрал дээр хэрэгжихгүй байх нь элбэг тохиолддог. Иймээс саяхны гэрээ хэлэлцээрээс хойш дараах зүйлүүдийг хийх хэрэгтэй байгааг онцлон тодотгож өгсөн.

Үүнд:

- Бага насны хүүхдэд тавих халамж, тэдэнд олгох боловсролыг сайжруулах, өргөжүүлэх
- Бүх нийтэд анхан шатны боловсролыг чанартай, үнэ төлбөргүйгээр заавал хүргэх
- Бүх насанд хүрэгчдэд амьдралын чадвар олгох хөтөлбөр ба үргэлжлүүлэн боловсрол олгох, зөв зохистой эрдэм мэдлэгийг тэгш хүргэх
- Хүйсийн тэгш байдлыг дэмжих
- Нийгмээс тусгаарлагдсан, гадуурхагдсан болон эмзэг бүлгийн хүмүүсийг бүх шатны боловсролд тэгш хамруулахыг дэмжих

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц (4) нь дээр дурдсан эрхүүдийг дахин баталж, тэгш хамран сургах боловсролыг анх удаа онцлон хуульчилж өгсөн нь: “Оролцогч улсууд нь бүх түвшинд тэгш хамруулсан сургалтын тогтолцоог баталгаажуулна” (24-р зүйл, 1-р заалт), “Оролцогч улсууд мэдлэг олгох болон нийгмийн хөгжилд аль болох дэмжлэг үзүүлснээр хувь хүнд зориулж авах арга хэмжээг үр дүнтэй байлгаж, бүрэн дүүрэн оролцуулах зорилтыг хангана. (24-р зүйл, 2-р заалт) Үүнд Брайль үсэг болон дохионы хэл, харилцааны төрөл бүрийн арга, хэлбэр, орон зайн чиг баримжаа олгох болон хөдөлгөөн дэмжих ур чадвар эзэмшүүлэх зэрэг багтдаг. Ядуурал, дарангуйлал, ялгаварлан гадуурхах зэрэг нь тэгш хамрах боловсрол олгоход гол саад бэрхшээл болдог(5). Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, Шинжлэх Ухаан, Соёлын Байгууллагын (UNESCO) тогтоосноор бага орлоготой орнуудын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн 90-ээс илүү хувь нь сургуульд хамрагддаггүй, гудамжны хүүхдүүдийн 30% нь хөгжлийн бэрхшээлтэй байна. Хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрсэн хүмүүсийн хувьд бичиг үсэг тайлагдсан байдал маш бага буюу 3%, зарим оронд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн хувьд маш бага буюу 1% байна.(6) Үүнээс үзэхэд, хөгжлийн бэрхшээлтэй бүх хүүхдүүдэд боловсрол олгох алхам хийх ёстой гэдэг нь илэрхий байна. Мянган Хөгжлийн Зорилт (7)-ын Хоёрдугаар зорилгод бүх хүнд бага боловсрол олгоно гэж заагаад 2015 гэхэд хүүхдүүд хаа ч байсан, охидууд, хөвгүүд ялгаагүй бүх хүүхдэд бага боловсролыг эзэмшүүлэх зорилго тавьжээ. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд ч тэгш хамрагдан боловсрол эзэмших ёстой бөгөөд Хамт олонд түшиглэсэн сэргээн засах (ХОТСЗ) хөтөлбөр энэ зорилгод хүрэхэд хувь нэмэр оруулна.

Жишээ 1 Монгол

Хүүхдийн тэгш хамран сургах сургалтыг эн тэргүүнд авч үзэх нь

Монголд Тэгш хамруулан сургах үндэсний хөтөлбөрийг Засгийн Газар, эцэг эхчүүдийн холбоо, Олон улсын төрийн бус байгууллагууд, Европын Холбооны Хандивлагч орнууд хамтран боловсруулж байна. 1989 оноос өмнө Монголд хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрэгчид болон хүүхдүүдэд зориулсан тусгай сургууль, асрамжийн газар байдаг байсан. Энэ тогтолцоо нь хэрэгцээнд тулгуурласан хэдий ч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгэмдээ тэгш хамрагдах гэх мэт бусад эрх нь байхгүй байсан. Улс төр, эдийн засгийн өөрчлөлтийн дараа эдгээр тусгай сургууль, институтуудыг хаахад хүргэсэн бөгөөд энэ нь шинэ хандлагын суурийг тавьсан. 1998 онд Олон улсын төрийн бус байгууллагын дэмжлэгтэйгээр Хөгжлийн Бэрхшээлтэй Хүүхдүүдийн Эцэг Эхийн Холбоо (ХБХЭЭХ) хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эрх ашгийг хамгаалахаар байгуулагдсан. ХБХЭЭХ нь дараах үйл ажиллагааг явуулдаг. Үүнд: бодлогод үнэлгээ өгөх, бусад орноос суралцахын тулд тэгш хамрах боловсролын талаар сургалт, Боловсролын яамтай хамтран бодлогын шинэчлэл хийхээр ажиллах, боловсролын үйлчилгээг оролцуулаад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх төрөл бүрийн үйлчилгээг тодорхойлох зэрэг орно. Хамт олонд түшиглэн сэргээн засалтыг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эрхийг хамгаалах, дэмжих ерөнхий стратегитай нэгтгэж ойлгоно. 2003 онд Боловсролын Яаманд Тэгш хамруулан сургах боловсролын хэлтэс гэж байгуулагдсан ба Эрүүл мэнд, Хөдөлмөр, Нийгмийн халамжийн Яамд хамтран хөтөлбөр хэрэгжүүлэгч хороог үүсгэн байгуулжээ. Орон нутгийн хамт олонд тулгуурласан төвүүдэд эрт үед оношлох, эмийн эмчилгээ хийх, сэргээн засах үйлчилгээнүүдийг үзүүлж эхэлсэн. Эхэн үедээ тэгш хамрах сургалтыг сургуулийн өмнөх насны түвшинд өгч байсан ба одоо бага сургуулийн тшвшинд болгон өргөжүүлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй 1000 гаруй хүүхдийг цэцэрлэгт хамруулж, багш нарт тэгш хамран сургах сургалтын ажлын дадлага олгосон. ХБХЭЭХ хүүхдийн эрхийн чиглэлээр үндэсний болон олон улсын бусад байгууллагатай хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэн өргөжүүлж байна.



Зорилго

Хөгжийн бэрхшээлтэй хүмүүс боловсролыг насан туршдаа сурах, тухайн боломж бололцоогоор хангах, нэр төр, нандин чанараа эрхэмлэх, өөрийгөө үнэлэх, нийгмийн амьдралд идэвхитэй оролцоно.

ХОТСЗ-ын үүрэг

Хамт олонд түшиглэн сэргээн засах үүрэг нь боловсролын салбарт бүх түвшинд тэгш хамран сургах боловсрол олгоход туслах, мөн насан туршд боловсрол эзэмшихэд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст дэмжлэг үзүүлэх явдал юм.

Хүсч буй үр дүн

- Хөгжлийн бэрхшээлтэй бүх хүмүүс өөрсдийн эрхийг хүндэтгэх, хэрэгцээндээ тохирсон сургалт, мэдээллийг авна.
- Орон нутгийн сургуулиуд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хамруулан сургах ба ингэснээр тэд үе тэнгийнхэнтэйгээ хамт сурч боловсрох, тоглох бололцоотой болно.
- Орон нутгийн сургуулиуд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд ээлтэй, хүртээмжтэй байна: уян хатан сургалтын хөтөлбөртэй, дадлагажсан багш нартай, гэр бүл, олон нийттэй сайн харилцаа холбоотой, шаардлага хангасан ус болон ариун цэврийн өрөөтэй байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг голлох үүрэгтэй, шийдвэр гаргагч, хувь нэмрээ оруулагчийнх нь хувьд боловсролд татан оролцуулна.
- Гэр, орон байрны орчин нь сургалтыг дэмжин, урамшуулна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг сурч чадна гэсэн мэдлэг ойлголттой болж зоригжуулж, дэмждэг болно.
- Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн болон бусад салбаруудын хоорондын хамтын ажиллагаа сайжирна.
- Тэгш хамран сургах боловсролыг дэмжих үндэсний хэмжээний бодлогыг боловсруулахад бүх шатанд зохион байгуулалттай хандана.

Жишээ 2

Тэгш хамран сургах боловсролыг хүртээмжтэй болгохыг дэмжих нь

Сургууль хүртээмжтэй барилга байгууламжтай, янз бүрийн хүүхдүүдтэй ажиллах чадвартай багштай байлаа ч хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд боловсролын гадна байсаар байна. Тэд магадгүй гэрийнхээ нэг өрөөнд нуугдах, гэр бүлийн дэмжлэггүй байдал байсаар байгаа ба тэдэнд туслах хэрэгсэл болон эрүүл мэндийн сэргээн засалт хэрэгцээтэй байж болох юм. ХОТСЗ нь боловсрол, эрүүл мэнд, нийгмийн салбарууд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудтай харилцан уялдаатай ажиллаж тулгамдаж байгаа асуудлуудад анхаарлаа хандуулдаг. Хэрэв хүүхэд нь эмгэгтэй эсвэл эцэг эхчүүд нь өөрсдөө боловсролгүй бол хөгжлийн



бэрхшээлтэй хүүхдүүдэд боловсрол олгохын ач тус, хэрэгцээ шаардлага байгаа талаар эцэг эхчүүдэд ХОТСЗ баг сурталчилан таниулах хэлэлцүүлгийг нилээд хэдэн үе шаттайгаар явуулах хэрэгтэй байна.

Тулгуур ойлголтууд

Боловсрол

Боловсрол нь сургуульд сурах гэдгээс маш өргөн хүрээтэй ойлголт юм. Сургуульд сурах нь чухал боловч, насан туршид олж авах мэдлэгийн нэг хэсэг л юм. Боловсрол нь төрсөн цагаас л эхэлж насанд хүрсэн хүний бүх л амьдралын туршдээ үргэлжилж, албан болон албан бус, гэрийн боловсрол болон хамт олон, төрийн санаачилгатай байдаг. Ерөнхийдөө “албан боловсрол”-ыг эрх бүхий байгууллага буюу сургууль, коллеж, дээд сургуулиуд боловсролын үнэмлэх өгч олгодог бол “албан бус боловсрол”-ыг албан боловсролоос гадуур зохион байгуулдаг боловсролын үйл ажиллагааны, “энгийн боловсрол”-ыг найз нөхөд, хамт олон, гэр бүлээсээ бүхий л амьдралынхаа турш суралцаж байдаг бөгөөд энэ нь албан ба албан бус боловсролоос хоёулангаас нь зохион байгуулалтанд ордоггүйгээрээ ялгаатай байдаг.

Хүний эрх

Хэдийгээр хүн бүр сурч боловсрох эрхтэй ч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд боловсролын гадна байдаг. Гэр бүлийн гишүүд, хамт олон, бүр хөгжлийн бэрхшээлтэй иргэд өөрсдөө ч сурч боловсрох тэгш эрхтэй гэдгээ мэдэхгүй байх нь олонтаа тохиолддог. ХОТСЗ хөтөлбөр, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд боловсролтой холбоотой янз бүрийн эрхүүдийн талаарх мэдээллийг хүртээмжтэй хүргэхийн тулд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрх мэдэлжүүлэхийг дэмжиж болох юм. Энэ нь бүх нийтэд боловсрол олгох хууль ёсны үүрэгтэй эрх бүхий байгууллагад нөлөөлөхөд тус болж болох юм. Сурч боловсрох эрхийг эрхэд суурилсан хөгжилд хүрэх арга замтай хамааруулан ойлгох хэрэгтэй. Эрх нь хязгаарлагдахгүйгээр бүх нийтэд чиглэсэн байх ёстой. (танилцуулгыг үз: Хүний эрх)

Ядуурал ба боловсрол

Ядуурал, хөгжлийн бэрхшээл, боловсрол гурвын хоорондын холбоо нь олон нийтийн хөгжилд хүрэхэд маш чухал. “Боловсролгүй байх нь хөгжлийн бэрхшээлтэй, бэрхшээлгүй бүх хүүхдүүдийн хувьд гадуурхагдах, ядууралд өртөх гол хүчин зүйл болдог. Хөгжлийн бэрхшээлгүй хүүхдүүдээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд боловсролын гадна байх, ядууралд өртөх магадлал өндөр байдаг байна. Сургууль завсардсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд үнэндээ удаан хугацаагаар бараг насан туршдаа ядуу байдаг(8). Ядуу хүмүүс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдээ төлбөр төлж сургах тал дээр маш хэцүү зүйлүүдтэй тулгардаг байна. Сургалт нь төлбөргүй байсан ч гэсэн тоног төхөөрөмж, тээвэр, дүрэмт хувцас, хичээлийн ном дэвтэр зэрэгт нэмэлт төлбөр хэрэг болж учраас ядуу гэр бүлээс гаралт ай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд сурч чадахгүй ядуурлын тойрогтоо байсаар л байна.

Тэгш хамран сургах боловсрол

Хөгжлийн бэрхшээлийн талаархи нийгмийн загвар нь хүний биед гарсан гэмтэл согогийг хөгжлийн бэрхшээл гэж үзэх үзлээс өөрчлөгдөж, бусдын нэгэн адил эрхээ эдлэх тэгш боломжийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст олгохын тулд нийгмийн саад бэрхшээлийг арилгахад анхаарлаа хандуулж байна. Энгийнээр хэлбэл, тэгш хамран сургах боловсрол нь оюутан нь тогтолцоондоо тохирч байна уу гэдгээс илүү тогтолцоо нь оюутандаа тохирч байна уу гэдэгт төвлөрч байна. Тэгш хамран сургах боловсролын тухай ойлгох энэ өөрчлөлт нь өнгөрсөн үед хувь хүний түвшинд ажиллаж байснаас илүү ихийг ХОТСЗ хөтөлбөрөөс шаардаж байна.(танилцуулга: төсөөллийн хувьсал)

Жишээ 3

Охидуудын оролцоонд учрах саад бэрхшээлийг арилгах

ХОТСЗ хөтөлбөр охидыг сургуульд оруулахад бэлтгэх тал дээр шаргуу ажиллаж байна. Охид сургуульд хүртээмжгүй орчинд бэрхшээлтэй тулгарч, бусад хүүхдүүдэд дооглуулдаг. Эцэстээ охин учрыг нь олохгүй болохоор багш нар нь түүний гэр бүлийнхэнд сургуульд явуулахаа боль гэж ятгана. Тэгш хамрах арга зам нь сургууль болон энэ жаахан охины оролцоонд саад болж байгаа зүйлийг арилгах тал дээр анхаарал хандуулах, өөрөөр хэлбэл, багш нарыг бэлдэх, илүү боломжийн таатай орчин бүрдүүлэх, бүх хүүхдүүдэд сурахад нь дэмжлэг үзүүлэх, сургуулийг илүү хүртээмжтэй болгох талаа дээр туслах явдал юм. Хэрвээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сургууль дээр ямар нэг бэрхшээлтэй асуудал тохиолдсон бол сургууль, гэр бүлийнхэн болон ХОТСЗ хөтөлбөрийнхэн ямар саад учирсныг олж мэдэхээс эхлэх хэрэгтэй.

Тэгш хамрах сургалт нь сургалтаас гадуур үлдэхийг багасгах болон соёл, олон нийт, сургалтын оролцоог нэмэгдүүлэх, суралцагчдыг олон талын хэрэгцээт мэдлэгээр хангахад чиглэгдсэн үйл явц” юм. (9). Тэгш хамрах сургалт нь:

- Энгийн сургуулиас илүү өргөн хүрээтэй – Боловсролд гэрийн, хамт олны, албан бус болон албан боловсролын тогтолцоог багтааж байдаг.
- Бүх хүүхдүүд сурч чадна гэсэн баталгаан дээр суурилсан.
- Боловсролын бүтэц, тогтолцоо, заах арга зүй зэрэг нь бүх хүүхдүүдийн хэрэгцээтэй таарч байх
- Хүүхдүүдийн нас, хүйс, гарал угсаа, шашин шүтлэг, хэл, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн байдал зэрэг ялгаатай байдлыг хүндэтгэн үзэх үзэл дээр суурилсан байдаг.
- Оролцоог хангасан, хүртээмжтэй, тэгш хамарсан хяналт, шинжилгээ ба үнэлгээний журмыг дэмжинэ.
- Орчин ба соёлын дагуу тасралтгүй хөгжиж байгаа үйл явц.
- Тэгш хамруулсан нийгмийг дэмжих томоохон стратегийн нэг хэсэг.

ХОТСЗ хөтөлбөр дараах зүйлсийг анхаарч үзэх ёстой.

- Тэгш хамрах боловсрол ердийн сургуулиас илүү өргөн хүрээтэй тул сонсголгүй хүүхдүүд болон насанд хүрэгчдэд зориулсан дохионы хэлний бүлэглэлүүд болон гэрт суурилсан боловсролыг багтаадаг.
- Тэгш хамрах боловсрол нь зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг биш бүх хүнийг хамруулна. Энэ нь сургуулиас гадуур орхигдсон болон хасагдсан хүмүүсээс зохих хүчин чармайлт шаардана.

Интеграцчилсан /нэгтгэсэн/ сургалт

Хэдийгээр “интеграцчилсан сургалт” нь “тэгш хамрах сургалт”-тай адилхан арга замаар явагддаг боловч энэ нэр томъёо өөр утгатай. Интеграцчилсан сургалт нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг ерөнхий боловсролын /зонхилох/ сургуульд авчирч сургахыг голчилдог ба сургуулийн системээс илүү хувь хүнд анхаарал тавьдаг. Энэ арга замын сул тал нь, хэрвээ ямар нэг асуудал үүсвэл энэ нь хүүхдийн буруу мэт болж харагддаг. Энэ арга барилын тогтвортой байдал, нөлөөлөл нь хязгаарлагдмал, хамт олны дэмжлэг сургуулийн бодлогоос илүүтэйгээр ХОТСЗ хөтөлбөрийн ажиллагсдын хүчин чармайлтаас эсвэл багш нарын хүсэл зоригоос амжилт нь хамаардаг

Тусгай боловсрол

“Тусгай боловсрол” нь хүүхдүүдэд боловсрол эзэмшүүлэхийн тулд илүү их тусламж, тусгай боловсруулсан хөтөлбөр, тусгай тоног төхөөрөмж, материал, арга барил (Брайль, дууны тоног төхөөрөмж, туслах багаж хэрэгсэл, дохионы хэл) зэргээр хангахыг чухалчилж өргөн хүрээг хамардаг. “Тусгай хэрэгцээт боловсрол” гэдэг нь сурахад бэрхшээлтэй ямар ч хүүхдийн сурах хэрэгцээг хангахыг голлодог. Иймээс тусгай боловсрол гэдэг нь зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулагдсан сургалт биш юм. Тусгай хэрэгцээт боловсролыг хүргэх олон төрлийн арга зам байдаг. Ихэнхдээ, маш их дэмжлэг шаардлагатай хүүхдүүд ердийн сургуулиас тусгай сургуульд суралцдаг. Хэдийгээр ХОТСЗ гарын авлага хамрах сургалтыг онцгойлон үздэг боловч “тусгай сургуулиуд” нь зөвхөн сонсголгүй, харааны бэрхшээлтэй эсвэл оюун ухааны хомсдолтой хүүхдүүдэд зориулсан тусгай хөтөлбөртэй, онцгой нөхцөл байдалтай олон гэр бүл хүүхдүүдэд бодитой зүйл юм. Буурай хөгжилтэй орнуудад эдгээр сургуулиуд нь дотуур байртай, хүүхдүүд нь ихэнхдээ гэр бүл, олон нийтээс хол амьдардаг. Харамсалтай нь, цаг хугацаа өнгөрөх тусам “тусгай” гэдэг нэр томъёо тэгш хамрах боловсролыг дэмжихэд үр дүнтэй бус арга зам байсаар байна. Жишээлбэл: “Тусгай хэрэгцээтэй хүүхэд” гэдэг нэр томъёо бол суралцахад бэрхшээлтэй байх эсэхээс үл хамаараад ихэвчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хэлдэг тодорхойгүй нэр томъёо юм. “Тусгай” гэсэн нэр томъёог ашиглах үед хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг заавал бусдаас нь салган авч асаргаа, халамж үзүүлэх хэрэгтэй болдог. Бүх хүүхдүүд янз бүрийн арга замаар сурдаг гэдгийг санаж байх нь маш чухал бөгөөд тэд амьдралынхаа турш амархан сурах, сурахад хэцүү байх гэхчилэн өөр өөрөөр сурцгаадаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд “тусгайлан” суралцах хэрэгцээ, шаардлага байдаг гэж хэлэх нь тустай зүйл биш бөгөөд учир нь тэдэнд нэр хаяг, шошго өгч байгаа хэрэг. Хөгжлийн бэрхшээлгүй хүүхдүүд ч суралцах явцдаа саад бэрхшээлтэй тулгардаг ба суралцах орчноос тусгаарлагдах, хасагдах явдал гардаг. Сургалтын сайн арга барилтай, шаардагдах нөөц бололцоотой тэгш хамрах орчинд бүх хүүхдүүд сурч чадна.

Хүйс ба боловсрол

ХОТСЗ хөтөлбөрийнхэн боловсролтой холбоотой хүйсийн асуудлын талаар мэдлэг, ойлголттой байх хэрэгтэй. Доор зарим жишээг авч үзье.

- Охидууд гэр бүлийнхээ хөгжлийн бэрхшээлтэй хэн нэгнийг асран халамжлахын тулд сурах таатай боломжуудаа алдаж байдаг.
- Зарим тохиолдолд, хөвгүүд мөнгө олж гэр бүлээ тэжээхийн тулд сургууль завсардах нь ч байдаг.

Жишээ 4 Энэтхэг

Боловсролд Рупагийн шийдвэр

Хойд Энэтхэгийн Хазарибагхт Рупа Кумари охины ээж нь сэтгэцийн өвчтэй, эцэг нь нас барсан, эрэгтэй, эмэгтэй дүү нараа харж хандаж бүхэл гэр орноо асран халамжилдаг. Сургууль завсардахгүйн тулд тэрээр эмэгтэй дүүгээ сургууль руугаа хамт авч явдаг, хэдийгээр тэр ахлах ангид сурдаг ч багш нар нь байнга гомдол гаргадаг байв. Рупа ч сургуульдаа суралцахын тулд дүү охиноо заавал дагуулж явах ёстой гэж тэдэнд ятгадаг байлаа.

- Дайны байдалд, хөвгүүд хүүхэд насандаа цэрэгт татагдаж сурч боловсрох таатай боломжуудаа алддаг. Эдгээр хөвгүүдийн дор хаяж 5% нь хөгжлийн бэрхшээлтэй болдог (10), цэргээс буцаж ирэхдээ ерөнхий боловсролын сургуульд сурахад нас нь ахдахаар болсон байдаг байна.
- ХОТСЗ хөтөлбөрийнхэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ээж нь эсвэл эмэгтэй төрөл садангуудаар заалгахыг хүсдэгч энэ нь эмэгтэйчүүдэд дарамттай ажилд тооцогддог.
- Гэр бүлийнхэн болон олон нийт ихэнхидээ хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд эсвэл охидод боловсрол олгохыг нэн тэргүүнд авч үздэггүйгээс давхар ялгаварлан гадуурхагдаж байдаг.
- Охидууд, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй охидууд хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал, тохилог бие засах газар байхгүйгээс болж сургуулиа орхидог байна.
- Эцгүүдийн үүрэг мөн чухал ч тэд үүргээ биелүүлдэггүй: хэрвээ ХОТСЗ хөтөлбөрт хамрагдаж боловсрол олж авснаар аавууд сайн үлгэр дуурайлал үзүүлж чадна.

Жишээ 5 Лесото

Хүйсийн ялгаа

Лесотод цөөн тооны хөвгүүд бага сургуульд явдаг ба мал маллах, уламжлалт зан үйлд хөвгүүд шаардлагатай байдгаас охидоосоо илүүтэйгээр хөвгүүд сургуулиас гардаг байна.

Бүрэлдэхүүн хэсгийн элементүүд


Доор дурьдах элемент бүрт боловсролын бүхий л талд түгээмэл байдаг үйл ажиллагааны хамрах хүрээ, үзэл баримтлал багтдаг. Ялгаатай талуудыг онцлон авч үзсэн бөгөөд элемент тус бүрт өөр өөр жишээнүүд авсан. хэдийгээр та нэг элементийг чухалчлан авч үзэх хэдий ч бүх бүрэлдэхүүн хэсгүүдийг уншихад тань хэрэг болно.

Бага насны хүүхдэд үзүүлэх анхаарал халамж ба боловсрол

Энэ нэр томъёо нь төрснөөс эхлээд бага сургуульд орох хүртэлх хугацааны боловсролд чиглэгддэг. Энэ нь албан, албан бус, энгийн орчинд хүүхдийн хөгжил, сургалт, дасан зохицож амьдарч сурахад анхаарал тавьдаг. Үүнд эрүүл ахуй, эрүүл мэнд, хооллолт зэрэг багтана. Энэ мөчлөг нь цаашдаа насны ангиллаар дараахи байдлаар ангилагддаг: 0-с 3 нас, 3-6 нас, албан боловсрол эхлэх долоо эсвэл найман нас. Энэ хэсэгт гурав болон түүнээс дээш насны хүүхдүүдийг голлон авч үзнэ.

Бага боловсрол

Энэ нь сургуулийн эхний үе бөгөөд бүх хүүхдүүд заавал үзэх ёстой, үнэгүй байхаар төлөвлөгдсөн байдаг. Энэ нь UNESCO (11)-с санаачилан гаргасан Бүх нийтийн боловсрол ба боловсролын сангуудын тавьсан зорилгод тулгуурладаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд бусад хүүхдүүдийн адил ерөнхий боловсролын сургуульд явж үе тэнгийнхэнтэйгээ тоглож, сурах хэрэгтэй.



Дунд болон дээд боловсрол

Энэ нь албан боловсрол бөгөөд “үнэ төлбөргүй” байх албагүй боловсрол юм. Хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын хувьд цаашдын боловсрол нь амьдралдаа сэтгэл хангалуун байх үүд хаалга нь болж өгдөг.

Албан бус боловсрол

Энэ нь гэр бүлээс олж авах боловсрол, төрийн тогтолцоо, олон нийтийн хандлага зэрэг өргөн хүрээний боловсролыг багтаадаг. Энэ нь тодорхой зорилготой бөгөөд тодорхой гадуурхагдсан бүлгүүд рүү хараагаа чиглүүлдэг. Ү. Заримдаа албан бус боловсролыг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд “хоёр дахь хамгийн сайн” сонголт гэж зохимжгүйгээр санал болгож тэднийг албан боловсрол эзэмших хууль ёсны эрхийг нь үгүйсгэдэг. Энэ хэсэгт хүүхдүүдийн албан бус боловсролыг насанд хүрэгчдийнхээс илүү голлон авч үзэх болно.

Насан туршдаа суралцах

Энэ нь амьдралынхаа туршид сурч болох бүх мэдлэг, ялангуяа насанд хүрэгчдийн хувьд өөр зүйлээр орлуулж болохгүй суралцах таатай боломжуудыг багтаадаг. Үүнд ажил олгогчдод хэрэгтэй мэдлэг, ур чадвар, насанд хүрэгчдийн бичиг үсэг тайлагдсан байдал, нийгмийн оролцоо, өөрийгөө хөгжүүлэх бүх төрлийн сургалтуудыг онцлон авч үзнэ. Энэ хэсэгт насанд хүрэгчдийг хүүхдүүдээс илүүтэйгээр анхааралдаа авдаг.

Жишээ 6

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурч боловсрох эрх

“Улс орнууд бага болон дунд боловсрол, техник мэргэжлийн сургалтын дадлага, насанд хүрэгчдийн боловсрол, насан туршид суралцах зэрэгт тэгш хүртээмжтэй байх ёстой. Боловсрол олгохдоо тохирох сургалтын хэрэглэгдэхүүн, арга барил, харилцаа холбооны хэлбэрүүдийг хэрэглэдэг. Дэмжлэг хэрэгтэй сурагчид бүрэн хэмжээгээр дэмжлэг авах, хараагүй, сонсголгүй сурагчид Брайль болон дохионы хэл төгс эзэмшсэн багш нараас боловсрол олж авах хэрэгтэй байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсрол нь тэдэнд бүтээлч сэтгэлгээ, авьяас чадвар өөрийгөө хөгжүүлэх, өөрийгөө үнэлэх бие даан ажиллах нийгмийн оролцох идэвхийг нэмэгдүүлэх ёстой. (12)

Бага насны хүүхдэд үзүүлэх анхаарал халамж ба боловсрол

Танилцуулга

Төрсөн цагаас эхлээд найман нас хүртэл хугацаа нь хүүхдийн бага насанд хамаарагдана. Бага насны хүүхдийг хүмүүжүүлж хөгжүүлэх нь зургаан шатны боловсролын нэг юм. Бага насны хүүхдэд хүмүүжил боловсрол олгоход материаллаг болон өргөн хүрээний үйл ажиллагаа шаардагддаг. Яагаад гэвэл бага насны хүүхдэд анхаарал халамж үзүүлэхэд эрүүл мэндийн олон бүрэлдэхүүн хэсгийг багтаасан байдаг бөгөөд цэцэрлэгээс эхлэн бага насны хүүхдэд боловсрол эзэмшүүлнэ гэж тусгагдсан байдаг.

Бага насны хүүхдийн хүмүүжил нь хүүхдийн цаашдын хөгжилд нөлөөлдөг учраас уг боловсрол нь чухал зүйл юм. Хүний тархи амьдралын эхний гурван жилд эрчимтэй хөгждөг(13), энэ хугацаанд хэрэгцээтэй мэдээллээр хөгжүүлэхгүй бол хүүхдийн хөгжил саатах буюу зарим тохиолдолд энэ чигээрээ тогтдог. Хүүхдэд эхний жилүүдэд хэлний суурь тавигдахаас гадна нийгэмтэй харилцах, бодох чадвартай болох нь анхны суурь үндэс тавигддаг.

Сургуулийн өмнөх боловсрол-СӨБ нь нийгмийн анхны боловсролын суурь нь болж өгдөг. Яагаад гэвэл эрүүл эсвэл хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд хамтдаа өсч торнин тоглодог нь нийгэмшихэд анхны алхам болж өгдөг. Мөн цэцэрлэгийн хүмүүжил хүүхдэд анхны суурь боловсролыг дүүргэх боломж өгснөөр ядуу амьдрал, таагүй нөхцлөөс гарах гарц болж өгдөг.

СӨБ- нь боловсрол бага боловсролуус илүү уян хатан байж засгийн газар төрийн ба төрийн бус, хувийн, шашны байгууллагуудтай хамтран ажилладаг.

Жишээ 7 Непал

Бага боловсролыг амжилттай явуулах

Непалын буурай дүүрэгт хүүхдүүдийн 95 хувиас илүү нь бага насны хүүхдэд үзүүлэх анхаарал халамж, боловсролын хөтөлбөрт хамрагддаг.

Хөтөлбөрт хамрагдаагүй үлдсэн 75%-тай харьцуулахад: 1-р ангид оролцогчдын давталтын хэмжээ оролцоогүй хүүхдүүдийн долооны нэгтэй тэнцэж байсан ба тэд түвшин 1-р ангийн шалгалтандаа гайхалтай өндөр дүнг авсан(14).



Жишээ 8 ЭНЭТХЭГ

Четнагийн шинэ амьдрал

Энэтхэг улсын Гужарат мужид 1980–аад онд бага насны хүүхдүүдэд зориулсан ХОТСЗ хөтөлбөрийг анхны удаа хэрэгжүүлжээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд амьдралынхаа эхний жилүүдэд боловсрол болон амьдралын туршлага хуримтлуулах боломжоор хомс байдаг, гэсэн хэдий ч хүүхдэд ертөнцийг үзэх үзэл төлөвшүүлэх суурь мэдлэг олгох, нийгмийн харилцаанд оролцоход хүний амьдралын эхний жилүүдэд анхаарах нь чухал юм. Өнөөдөр Гужарат мужид бага насны хүүхдийн боловсрол, халамж нь ХОТСЗ хөтөлбөрийн салшгүй нэгэн хэсэг болсон байна.

ХОТСЗ хөтөлбөрийн ажилтан Гужарат мужийн нэгэн тосгоны гурван настай Четна охиныг хөгжлөөрөө хоцрогдолтой болохыг илрүүлжээ. Тэрээр толгойгоо бүрэн удирдаж чаддаггүй байж. ХОТСЗ хөтөлбөр Четна охины хөгжилд үнэлгээ хийхээр түүний амьдардаг тосгноос хол өөр хотод үнэлгээ хийжээ. Түүний сонсгол алдагдсан, харааны эмгэгтэй, дээрээс нь юмыг ойлгохдоо тааруу байсан зэргээс нь хамаараад түүнийг хөгжлийн бэрхшээлтэй гэж тодорхойлсон. Четна дөрвөн хананы дунд гэртээ, үргэлж ээжийнхээ өвөр дээр байдаг байсан учраас ХОТСЗ хөтөлбөр болон гэр бүлийнхэн нь дараах бэрхшээлүүдтэй тулгарсан. Четнад юу хэрэгтэй вэ? Энэ хэрэгцээтэй зүйлүүдийг хаанаас олж болох вэ? Хэн түүнтэй ажиллах вэ? Яаж түүнтэй ажиллах вэ?

ХОТСЗ хөтөлбөр нутгийн мужаанаар тусгай сандал хийлгэж Четна байшингийнхаа тагтан дээр энэ сандал дээр сууж эхэлсэн ба тэр олон нийтэд харагдаж эхэлсэн, түүний гэр бүл болон хөршүүдтэйгээ харилцах харилцаанд ахиц гарсан. Түүнийг өдөр тутмын амьдралын чадварт сургаж, сонсголын төхөөрөмж, тусгай харааны шил өгсөн. Түүнийг харилцаанд бас сургасан. Одоо Четна ээждээ хоол хийх, сав суулга угааж цэвэрлэх, дэлгүүр явахад нь тусалдаг болсон. Түүний эцэг эх нь түүнтэй харилцаж чаддаг болж тэд нар хайр дүүрэн, эерэг харьцаатай болсон. Четна одоо нутгийнхаа цэцэрлэгт явж, цэцэрлэгийн нэг гишүүн болсон. Хүүхдүүд түүнтэй бусад хүүхдүүд шиг үзэж, өөр өөрийнхөөрөө харьцдаг. Тэр бусад хүүхдүүдийн адил зүйлсийг хэрэглэж бас түүнчлэн ХОТСЗ хөтөлбөрөөс бусад хүүхдүүдтэй адил улсын боловсролын системд хамрагдаж, нийгмийн хамгааллын тэтгэмж авах зэрэг зарим дэмжлэг үйлчилгээг авдаг.



Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй бүх хүүхдүүдийг тэгш хамрах сургалтын орчинд дэмжин, амьдралынх нь хамгийн сайн, боломжит эхлэлийг тавина.

ХОТСЗ-ын үүрэг

ХОТСЗ-ын хүлээх үүрэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй гэр бүлийг таньж мэдэх, тэдэнтэй ойрхон ажиллаж харилцаж байх, хүүхдийн амьдралын бүх үйл ажиллагаанд туслах суурийг тавьж өгөх явдал юм.

Хүсч буй үр дүн

- Бүх хүүхдүүдэд эсэн мэнд амьдрах, эрүүл мэндээ сайжруулах боломж олгоно.
- Бүх хүүхдүүдийн биеийн, нийгмийн, хэл ярианы болон танин мэдэхүйн ур чадварыг тэдний чадах дээд хэмжээнд хүртэл нь хөгжүүлнэ.
- Бүх хүүхдийг албан болон албан бус бага боловсролд тэгш хамруулна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, тэдэнд тусалж буй хүмүүс бол гэр бүл, хамт олны нэгэн хэсэг бөгөөд тэдэнд тохирох дэмжлэгийг үзүүлнэ.
- Хүүхдүүд хамтдаа тоглож, өөр хоорондын ялгаатай байдлаа хүлээн зөвшөөрч, бие биедээ туслахад суралцана.
- Эмгэг, согогийн нөлөөг бууруулна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд бага сургуульд үе тэнгийнхэнтэйгээ суралцана.

Жишээ 9 Эл Сальвадор

Эрт анхаарах

Эл Сальвадорын Санто Томасд орон нутгийн ХОТСЗ хөтөлбөрт оролцдог тэгш хамрах дунд сургуулийн захирал хүчилтөрөгчийн дутагдалтай 3 сар дутуу төрсөн хүүхэдтэй болжээ. Эмч тэр хүүхдийг оюун ухааны хомсдолтой эсвэл өөр ямар нэгэн хөгжлийн бэрхшээлтэй болно гэж ээжид нь хэлсэн байна. ХОТСЗ хөтөлбөртэй ажилласан туршлагаараа тэр ээж эрт хөгжүүлэхийн ач холбогдлыг мэдэж байв. Тэгээд ээж хүүхдийнхээ хөгжлийн үнэлгээ хийлгэхээр 2 настайд илрүүлэлт хийдэг сэргээн засах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллага руу авч очжээ. Ээж хүү 2 их юм сурч, хүү 4 настай байхдаа хөршүүдийнхээ бусад хүүхдүүдтэй хамт сургуулийн өмнөх насны бэлтгэл ангид орсон.

Гол ойлголтууд

Бага нас

Бага нас нь хүний амьдралын үндэс суурийг тавьж өгдөг нас(5). ХОТСЗ-ынхан орон нутгийн уламжлалт зан үйл, шашин шүтлэг, соёл, гэр бүлийн бүтэц, дунд сургуулийн зохион байгуулагдсан арга зэргээс хамааран хүүхдийн бага насны талаар ялгаатай ойлголтууд байдгийг мэдэж байх хэрэгтэй. Ийм олон талт байдлыг хүндэтгэн, хүлээн зөвшөөрөх нь чухал юм.

Хүүхдийн хөгжил

Хүүхдийн хөгжил гэдэг нь хүүхэд бүр хэрэгцээт ур чадваруудыг (хөгжлийн ай) олж авахаар суралцах үйл явц юм. Хүүхдийн хөгжилд:

- Нийгэмшихүй болон сэтгэл хөдлөл, тухайлбал инээмсэглэх эсвэл нүдээр харилцах зэрэг
- Танин мэдэхүйн (сурах) хөгжил, тухайлбал хүрээлэн байгаа орчноо танин мэдэхийн тулд гар болон нүдээ ашиглах, энгийн даалгавруудыг биелүүлэх гэх мэт
- Хэл ярианы хөгжил, тухайлбал үг эсвэл дохиогоор харилцах гэх мэт
- Бие бялдрын хөгжил, тухайлбал суух, босох, алхах, гүйх, гар, хуруугаа оролцуулан юм авах, зурах гэх мэт

Хөгжлийн ай гэдэг нь хүүхэд тодорхой дарааллаар, цаг хугацааны явцад эзэмшдэг ур чадварууд юм. Тухайлбал, алхаж сурах үе нь ихэнх хүүхдүүдэд 9–15 сартайдаа байдаг гэх мэт. Хөгжлийн хоцрогдол гэдэг нь тухайн хүүхэд өөрийн насандаа тохирсон хөгжилд хүрээгүй байгааг илэрхийлдэг нэр томъёо юм. Энэ нь дээр жагсаасан хөгжлийн нэг болон түүнээс дээш айд тохиолдож болно. Хэрвээ хөгжлийн хоцрогдлыг хүүхэд ахуйд эрт илрүүлвэл хоцрогдлыг арилгахад туслах орчин, суралцах боломжоор хангах арга хэмжээнүүдийг авч болдог.

ХОТСЗ-ынхан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг чадавхижуулахад голлон анхаарч ажиллах хэрэгтэй. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хувьд хэрвээ эдгээр санаа зовоох зүйлүүд үүсвэл асуудлыг гүнзгийрүүлж хөгжлийн үе шатуудад нь хэтэрхий газар авхуулахгүйгээр онцгойлон авч үзэх хэрэгтэй.

- Хөгжлийн хоцрогдлын үндсэн зарчим нь хэвийн хөгжил дээр үндэслэгддэг.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд “хэвийн” хөгжлийг заавал дагах шаардлагагүй. Хэдийгээр, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд бүрэн дүүрэн, аз жаргалтай байдаггүй ч гэсэн тэднийг байнга хамруулан хөгжүүлж, дэмжиж байх ёстой.
- Хөгжлийн ай нь ерөнхий зарчим бөгөөд бодит амьдрал дээр соёл, хүйс, үндэс угсаа, нийгэм эдийн засгийн нөхцөл байдлаас хамааран маш олон хувилбартай байдаг.

Хүүхдийн хөгжилд эрүүл мэнд, хоол тэжээл, асаргаа сувилгаа, боловсрол зэрэг олон хүчин зүйл нөлөөлж байдаг. Тиймээс хүүхдийн хөгжилд олон салбар ойртож ажиллах хэрэгтэй. Жишээлбэл, хооллолт ба боловсрол хосолсон хөтөлбөр нь өөр нэг эсвэл бусад зүйлд анхаарал хандуулж байгаа хөтөлбөрөөс илүү үр дүнтэй байна. (15)

Тоглох, үйл ажиллагаанд суурилсан сургалт ба сэдэлжүүлэх

Бага насны хүүхдүүд өдөр тутмын амьдралд оролцох болон тоглох явцдаа зөнгөөрөө, үр дүнтэйгээр сурч байдаг. Нэн ядуу болон амьд үлдэхийн төлөө тэмцэж байгаа бүхий л соёлд тоглох гэдгийг агуулгаар нь ойлгодоггүй. Ийм нөхцөл байдалд тоглох гэдэг бол утга учиргүй хэрэггүй зүйл шиг л харагддаг. Үйл ажиллагаанд суурилсан сургалт нөөц бололцоо, цаг хугацаа хязгаарлагдмал нөхцөл байдалд үр дүнтэй хандлага байж болох юм. Хүүхдүүд хэрэгцээтэй эсвэл бүтээмжтэй үйл ажиллагаанд биеэрээ оролцох үед хэрхэн сурч байгааг үйл ажиллагаанд суурилсан сургалт харуулна. Үүнд юм угаах, хувцсаа өмсөх, гэр орны болон өөр ажилд туслах зэрэг өөрөө өөртөө үйлчлэх үйл ажиллагаа орно. Хүүхдийн хөгжлийг дэмждэг үйл ажиллагаа болон орчноор нь хангаж өгөх нь сэдэл өгч байгаа хэрэг болно.

ХОТСЗ-ынхан дараах зүйлийг ойлгох нь маш чухал.

- Тоглоом эсвэл үйл ажиллагаанд суурилсан сургалт нь бага насны хүүхдүүдэд, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд маш чухал. Энэ нь тэдэнд өдөр тутмын амьдралын чадварыг хөгжүүлэхэд тусалж, тэдний эмгэгийн нөлөөг багасгаж болно.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг тоглож чаддаггүй гэж, ялангуяа хэрвээ тэд өөрсдөө тоглохгүй л бол тоглож чадахгүй гэж олон хүмүүс боддог. Эцэг эхчүүд тоглохын ашиг тусыг төдийлөн ойлгодоггүй эсвэл хэтэрхий их бөөцийлж эсвэл хүүхдүүдээ ил гаргахаас ичдэг байж магадгүй.
- Тоглоомууд зохион байгуулалттай эсвэл зохион байгуулалтгүй(чөлөөт тоглолт) байж болох бөгөөд хүүхэд өөрөө санаачлан эсвэл насанд хүрэгчдийн дэмжлэгтэйгээр явагдаж болно.
- Хүнд хэлбэрийн эсвэл хавсарсан эмгэгтэй хүүхдүүдийн хувьд тоглох болон сэдэлжүүлэх үйл ажиллагаа нэн чухал. Сурч байгаа гэсэн шинж тэмдгийг харах хэцүү, харагдах шинж тэмдэг байхгүй байлаа ч энэ нь хүүхдэд үр дүнгээ өгөхгүй байгаа гэсэн үг биш юм.
- Ялангуяа амжилттай суралцах, “хэвийн хөгжил”-д хүргэх гэсэн нийгмийн дарамт шахалт ирсэн үед эцэг эхчүүд дэндүү олон сэдэлжүүлэх үйл ажиллагааг хүүхэдтэйгээ хийж гүйцэтгэдэг. Энэ нь хүүхдийн тоглох боломжуудыг хязгаарлаж, тэдний нийгэм, сэтгэл хөдлөлийн хөгжилд муугаар нөлөөлж болзошгүй.

Насанд нь тохирсон үйл ажиллагаанууд

Бага насны хүүхдэд олгох боловсролд хамрагдаж байгаа том болсон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг олох нь ховор байна. Үүнд олон шалтгаан байж болзошгүй. магадгүй тэд оюун ухааны хомсдолтой юм уу хөгжлийн хоцрогдолтой байгаа нь хөгжих чадвар нь удаан, гэр бүлийнхэн нь тэднийг нуу юм уу хэт бөөцийлдөг, үүнээс болоод эрт хөгжих боломжоо алддаг, эсвэл бага сургуулиуд таатайгаар хүлээн авдаггүй, эсвэл хүртээмжгүй байдагтай холбоотой. Ерөнхийдөө тухайн хүүхдийн насыг бодолцож, үе тэнгийнх нь дунд насанд нь тохирсон сургалтыг явуулахыг зөвлөмөөр байна. Гэхдээ заримдаа зөвшилцөл хийдэг. Үндсэн гол зарчим болон хүүхдийн сонирхол нийцэж байх ёстой.

Сонголт ба уян хатан байдал

Хүүхэд, гэр бүл, хамт олон, соёл бүгд ялгаатай өөр өөр. Сургуулийн өмнөх боловсрол зарим хүүхдэд тохирч байхад заримд нь тохирдоггүй. ХОТСЗ хөтөлбөр гэр бүлүүдэд хүрээлэн байгаа орчин болон дэмжлэгүүдийн талаар сонголт хийх, уян хатан байдлаар хандахад тусалж чадна. Бага насны хүүхдийн боловсрол олгоход тэгш хамруулах болон хүртээмжтэй болгох ажлыг урьдаар хийх нь зүйтэй.

ХОТСЗ хөтөлбөр гэр бүлүүдтэй ичих болон хэтэрхий хамгаалалт дээр суурилсан биш, хүүхдийн сонирхолыг тусгасан байхаар сонголт хийхэд нь туслана. Эдгээр сонголтууд нь хүүхэд өөрийн гэр бүл, хамт олонтойгоо байх зэрэг хүүхдийн төрөл бүрийн эрхийг хүндэтгэсэн байх хэрэгтэй.

Жишээ 10 Мексик

Эрт хөгжүүлэх төвүүд

Кулиаканы ойролцоох Мексикийн нэгэн мужид нутгийн уугуул гэр бүлүүд уулын гацаанаасаа ирж хөдөө аж ахуйн үйлдвэрээс өгсөн тагзанд жилийн 4 сарын турш амьдардаг байжээ. ХОТСЗ хөтөлбөр үйлдвэрийн эзэдтэй тохиролцож байшин болгонд эрт хөгжүүлэх төвийг байгуулах, эхчүүдээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг нь сард 2 удаа хөгжүүлэх төвд хамруулах зөвшөөрөл авчээ. Бусад хүүхдүүд (4 болон түүнээс дээш настай)-ийг үйлдвэрийн ХОТСЗ-ын дэмжлэгтэй өдөр өнжүүлэх бүлэгт хамруулжээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн гэр бүлүүд хүүхдүүддээ сайн асаргаа сувилгаа авахын тулд тэднийг бага насанд нь яаж хөгжүүлэхийг сурахын тулд жил бүр энэ газартаа эргэн ирцгээдэг. Тэд тосгондоо очоод бусад гэр бүлүүдэд мэдлэгээ зааж өгдөг.

Санал болгож буй үйл ажиллагаанууд

Бага насны хүүхдийн хэрэгцээг тодорхойлох

Хос-замнал хандлага нь ерөнхийдөө тэгш хамрах сургалтыг дэмждэг хамгийн сайн арга зам бөгөөд энэ нь бага насны хүүхдийн асаргаа сувилгаа ба боловсрол уруу чиглэгдэнэ. “Хос замнал” доорх маягтай байна.

1.Тогтолцоонд анхаарах: хамт олон дунд байгаа бага насны хүүхдүүдэд тавих асаргаа, сувилгаа ба боловсролын талаарх өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлж, хэн нь хамрагдаж эсвэл хамрагдахгүй байгаа, хэн нь ямар чадавхтай болон сул дорой байна гэдгийг олж мэдэх. Үүнд гэр бүл, хамт олны удирдагчид, эрүүл мэндийн ажилтнууд, багш нар мөн оролцох хүсэлтэй хэн ч байсан хамтран ажилласнаар хийгдэнэ.

2.Хүүхдэд анхаарлаа хандуулах: Нэмэлт дэмжлэг шаардлагатай эсвэл орхигдох эрсдэлтэй хүүхдүүдийг дэмжиж, тодорхойлдог тогтолцоог хөгжүүлнэ. Энэ нь эрт илрүүлэхэд ихэвчлэн чиглэгдэнэ.

“Нэг замнал” нь зөвхөн хувь хүнд голчлон анхаардаг. Үр ашгийг нь зөвхөн цөөн тооны хүүхдүүд л хүртдэг, тогтолцооны хувьд ихэнх нь гадна үлддэг. ХОТСЗ хөтөлбөр тогтолцоонд ч, хүүхдэд ч аль алинд нь анхаарч дараах байдлаар ажиллаж байна.

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд өөрт тохирсон эрүүл мэндийн үйлчилгээг авч чадаж байгааг бататгахаар эрүүл мэндийн ажилтнуудтай ажиллаж байна. (“Эрүүл мэнд” бүрэлдэхүүн хэсгийг үз)
- Эрт илрүүлэлтийн хөтөлбөрүүд нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, тэдний гэр бүлийг дэмждэгийг баталж байна.
- Төрөлхийн эмгэг, бэрхшээлтэй хүүхэд эсвэл хөгжлийн хоцрогдолтыг аль болох эрт илрүүлэхийн тулд гэр бүлүүдтэй ойр ажиллаж байна.
- Хүүхдийн эмгэг, бэрхшээлийг тодорхойлоод тусламж, үйлчилгээг аль болох хурдан үзүүлж, эцэг эхэд нь дэмжлэг үзүүлж байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн суралцах чадамж, чаддаг зүйлд нь анхаарсан эерэг хандлагыг бий болгохыг дэмждэг. Эерэг хандлагад хүүхдийн суралцах болон хөгжихөд нь тулгарч байгаа саад бэрхшээлийг тодорхойлох, түүнийг даван туулахад хамт олон, янз бүрийн салбарууд, гэр бүлүүдтэй ажиллана.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг тэгш хамруулан, сургуулиудыг хүртээмжтэй болгох талаар орон нутгийн бодлогод нөлөөлнө.

Хөгжил нь янз бүр явагдаж байгаа бага насны хүүхдүүдийн хувьд “хэвийн хөгжил” гэж юу болох талаар хатуу стандарт тавилгүйгээр тусламж, үйлчилгээ үзүүлэх ёстой. Хүүхэд үе тэнгийнхнээсээ хөгжлөөр хоцрогдож байгаа тохиолдолд эцэг эхчүүдийг сэтгэлийн түгшүүртэй байдалд оруулахаас ХОТСЗ-ынхан зайлсхийх ёстой. Заримдаа, эрүүл мэндийн үзлэг нь хүүхдийг яаж дэмжих вэ гэдгийг олж мэдэхээсээ илүү гадна үлдэх, хамрагдахгүй байх явдлыг өсгөдөг. ХОТСЗ сургалтанд хамрагдсан эрүүл мэндийн ажилтнууд хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, гарч болох гадуурхлаас зайлсхийхэд туслах болно.

Жишээ 11 Зүүн Өмнөд Ази

Сургуулийн өмнөх боловсролд тулгарах саад бэрхшээлүүд

Зүүн өмнөд азийн нэг оронд таваас доош насны хүүхдүүдэд эрүүл мэндийн үзлэгийг тогтмол хийдэг боловч хөгжлийн бэрхшээлтэй гэж тодорхойлогдсон хүүхдүүд нэмэлт дэмжлэг авдаггүй байлаа. Сургуулийн өмнөх боловсролын багш нар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг 3 шалтгааны улмаас ангидаа авах дургүй байдаг: Тэдний сургалтын хөтөлбөр нь уян хатан бус, ийм хүүхдүүдтэй ажиллахад илүү цаг шаардагддаг, хүүхдүүдэд ахиц гаргахгүй бол эсвэл жингээ алдах бол тэд нар цалингийн нэмэгдлээ алдах, эцэст нь зөвхөн “эрүүл” хүүхэд элсэх ёстой ба хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд өвчтэй юм шиг харагддаг.

Гэрийн боловсролыг дэмжих

Гэр бүлүүдийг хамруулах

Бага насны хүүхдэд үзүүлэх асаргаа, сувилгаа, боловсрол олгох явдал гэрээс эхэлдэг. Иймээс гэр бүл чухал. Бага насанд эцэг эхчүүд, ялангуяа ээжүүд хүүхдээ хөхөөр хооллох хүүхдүүдтэйгээ тоглох, урамшуулах, цагийг хамт өнгөрөөх зэргээр хүүхдийнхээ хөгжилд зан авир, хандлагаар дамжуулан нөлөөлж шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг. Эцгүүдийн оролцоо чухал бөгөөд хайхрахгүй өнгөрөөж болохгүй дэмжиж тусалж байх ёстой. Дараах үйл ажиллагааг санал болгож байна.

- Өвөө, эмээ, эцэг эх, ах дүү нараас багш, эрүүл мэндийн ажилтнуудтай хүүхдийнхээ талаар харилцаж байгаа харилцаан дээр гэр бүлийг дэмжинэ. Гэр бүлүүд нь ХОТСЗ-ынхныг мэдээллээр хангана.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сурах эерэг боломжоор хангах, асаргаа сувилгаа үзүүлэх тал дээр гэр бүлийг дэмжиж, боловсрол олгоно.
- Шаардлагатай тохиолдолд тусгай сургалтанд хамрагдахад нь гэр бүлүүдэд туслана (тухайлбал, сонсголгүй хүүхэдтэй харилцахын тулд дохионы хэл зааж өгөх) эсвэл тусгай үйлчилгээгээр (тухайлбал, ахуй засал, хэл засал, сэтгэл заслын үйлчилгээ) гэр бүлийн ур чадварыг хөгжүүлэхэд тусална.
- ХОТСЗ-ынхан хүүхдийн хөгжил хийгээд үнэлгээгээ ашиглан гэр бүлтэй хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг боловсруулдаг. Ийм ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг тохирох газарт нь багш нартай хуваалцаж болно.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн өөрөө өөртөө туслах бүлгүүдийг байгуулна. Эсвэл иймэрхүү бүлэг, холбоодод эцэг эхчүүдийг зуучилна. Зарим тохиолдолд эцэг эхчүүд хөгжлийн бэрхшээлтэй холбоотой байгууллага, холбоодын гишүүн байх нь бий.
- Гэр бүлийн гишүүд, хамт олон, орон нутгийн нөөцөд байгаа хүмүүсийн хоорондын холбоо, сүлжээг дэмжинэ.
- Гэр бүлд байгаа одоогийн хүйсийн асуудлыг авч үзэж, хөгжлийн бэрхшээлтэй охидуудаа сургахыг зөвшөөрч байгаа гэр бүлүүдийг дэмжинэ.



Жишээ 12 Болив

Хүүгээ сургахад аавын оролцоо

Боливийн Ел Алто–д ХОТСЗ хөтөлбөр орон нутгийн сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хамруулахыг дэмжсэн. Дауны синдромтой 6 настай нэг хүү орон нутгийн цэцэрлэгт явж эхэлжээ. Хүүгийн аав нь эхэндээ хүүдээ маш их сэтгэл зовниж байв. Тэрээр өдөр бүр хүүгээ сургууль руу хүргэж өгч, авч, ангийн багштай, сургуулийн захиралтай нь уулздаг байсан. Сургуулийн захирал хүүгээ сургахад аавын оролцоо сайн байгаад сэтгэл нь хөдөлж, бусад эцэг эхчүүдийг хүүхдийнхээ боловсролд оролцохыг уриалж, хүүхдүүдийг тэгш хамруулах талаар мэдлэг, ойлголтыг дээшлүүлэхийн тулд эцэг эхчүүдийн холбоондоо тэр аавыг урьсан байна.

Гэрт суурилсан үйл ажиллагааг дэмжих

ХОТСЗ хөтөлбөрийн гол үйл ажиллагаа нь гэртээ хүүхдийнхээ сурах орчныг бүрдүүлэх явдал юм. Хүүхдэд урам зориг өгч, чадавхижуулснаар гэр бүлд нь тэгш хамруулах явдлыг дэмжинэ. ХОТСЗ ажилтнууд дараах үйл ажиллагааг санал болгож байна.

- Үйл ажиллагаанд суурилсан сургалтанд шууд, бүтээлч байдлаар хүүхдүүдийг оролцуулахад нь эцэг эхчүүдийг урамшуулах
- Хэдий “тусгай хэрэгсэл” шаардлагагүй, хүнд хэлбэрийн эмгэгтэй хүүхэд байлаа ч тоглоом, хэрэгслийг гэртээ хэрхэн хийх вэ, гэрт болон орон нутагт өдөр тутамдаа тааралддаг зүйлсийг тоглоход хэрхэн ашиглах вэ гэдгийг үзүүлэх
- Суух болон хөдөлгөөн хийхэд туслах тусгай хэрэгслүүдийг гарын доорх материал ашиглан гэр бүлийн гишүүд хэрхэн хийж болохыг үзүүлэх
- Зөвхөн хүүхдийн эмгэг, бие бялдрын хэрэгцээ, шаардлагад голлон анхаарахгүйгээр тусламж үйлчилгээ үзүүлэх, тухайлбал, хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдэд хөдөлгөөнтэй холбоотой сургалт, боловсрол олгодог ч нийгмийн ур чадвар(үе тэнгийнхээ хөгжлийн бэрхшээлгүй хүүхдүүдтэй тоглох, сурах чадвар гэх мэт) мөн тэднийг хөгжүүлэх хэрэгтэй байж болох юм.

Сурах таатай орчныг бий болгоход гэр бүлийн гишүүдэд туслах, тэдний хэрэглэдэг олон практик эх сурвалжууд байж болох юм. Эдгээрийг багтаасан зарим жишээнүүдээс доор дурдвал:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд (16)
- ДМБ-ын гарын авлага: Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамт олон дунд нь сургах (17)
- Харилцаагаа: Харилцааны бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажилладаг хүмүүст зориулсан гарын авлага (18)
- Хувцаслах, хооллох, бие засах, юм угаах зэрэг жижиг энгийн үйлдлүүдийг хийж сургахад нь гэр бүлийнхнийг дэмждэг Портэйж систем. Энэ нь хавсарсан эмгэгтэй хүүхдүүдэд ч хөгжил дэмшил, амжилтанд хүрэхэд тусална(19).

Жишээ 13

Гэрээр боловсрол олох

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хамруулдаг сургуулийн өмнөх боловсролд хавсарсан бэрхшээлтэй 3 хүүхэд хамрагддаггүй болохыг нэгэн багш олж мэджээ. Багш тэдний гэр бүлийнхэнтэй нь ажиллахаар гэрт нь очсон байна. Тэр багш эмэгтэй гэрийн нөхцөлд зайнаас сургах багцыг боловсруулж, эцэг эхчүүд сургалтанд нь сууж, одоо эцэг эхчүүд гэртээ хүүхдүүддээ зааж сургаж байна. Хүүхдүүд төв рүү шаардлагатай тохиолдолд очдог болжээ.

Хамт олны дунд сурахыг дэмжих

Бага насны хүүхдүүдэд янз бүрийн хэлбэрээр хамт олны дунд нь боловсрол олгох боломжууд байдаг бөгөөд тухайлбал тоглоомын бүлгүүд, өдөр өнжүүлэх бүлэг, эх, хүүхдийн бүлэг, эмэгтэйчүүдийн өөртөө туслах бүлэг гэх мэт. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хамт олны дунд тэгш хамруулах явдлыг дараах энгийн үйл ажиллагаагаар дэмжин хийж болно.

- Хүүхдээ гадуур хамт авч яваа гэр бүлүүдийг дэмжих, тухайлбал, шашин, шүтлэгтэй холбоотой болон нийгмийн үйл ажиллагаа, дэлгүүрээр явах зэрэг
- Шаардлагатай тохиолдолд олон нийт хүүхдийг хөгжихэд тусалж тусгай зориулалтын суудал эсвэл туслах хэрэгслээр дэмжин хүүхдээ гадаа тоглохыг хүлээн зөвшөөрч байгаа гэр бүлүүдийг дэмжих
- Хөгжлийн бэрхшээлтэй болон бэрхшээлгүй хүүхдүүдийг хамтад нь тоглуулахыг дэмжих—ах дүү нартай нь хамт болон хөршийн хүүхдүүдтэй хамт тоглуулах нь хүүхдүүдэд маш чухал, тустай байдаг
- Сургуулийн өмнөх боловсролын байгууллага болон орон нутгийн тоглоомын талбайн орчныг илүү таатай, хүртээмжтэй болгоход нутгийн хүмүүсийг (дамнуурган зам, бие засах газрууд, гэрэл чийдэнг нэмэгдүүлэх, аюулгүй байдлыг сайжруулах, цэвэрхэн байх) татан оруулах

Сургуулийн өмнөх тэгш хамрах сургалтыг хөгжүүлэхэд туслах

ХОТСЗ хөтөлбөр боловсролын салбарт хамтрагч нарыг бий болгож хүүхэд төвтэй, уян хатан сургалт руу чиглүүлэхийг дэмжих хэрэгтэй. Үүний зорилго нь бүх хүүхдүүдийг үр бүтээлтэй сургахад чиглэнэ. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын ажилтан, албан хаагчдыг хүүхдүүдийн суралцах янз бүрийн арга зам, хурдад тохирсон сургалтын орчныг бий болгоход сургахад ХОТСЗ хөтөлбөрүүд тусалдаг. Урамшуулах үйл ажиллагаанд:

- Тоглох явцад сурах, албан ба албан бус аль аль байдлаар
- Жижиг бүлгүүдийн ажил
- Гарын доорх материал ашиглаж тоглоом болон сургалтын хэрэглэгдэхүүн хийх
- Орчныг бүх нийтэд ээлтэй болгох, тухайлбал дамнуурган зам, бие засах газруудыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулан тохижуулах, харааны бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулан зарим газрыг тод өнгөөр будах зэрэг хүртээмжийн талаар засгийн газрын удирдамжид нийцүүлнэ.
- Гэр бүлийн гишүүдийг болон сайн дурынхны тусламж дэмжлэгийг анги танхимыг тохижуулахад ашиглах, тэдний тусламж нь зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд биш ангийн бүх хүүхдүүдэд хүрч байхад анхаарах
- Хүүхдүүдийг хэрхэн оролцож, сурч байгааг харж ажиглаад, дараа нь хүүхдийн ахуй амьдралтай холбоотой, хүрч болох сургалтын зорилтыг тодорхойлж, хүүхдүүдийн чадавхи зэргийг хамтад нь хэлэлцэнэ.

Жишээ 14 Занзибар

Хөвгүүний итгэл найдварын дуу

Занзибарын сургуулийн өмнөх боловсролын байгууллагад сонсголын бэрхшээлтэй нэгэн хүүтэй багш нь дохионы хэлээр харилцдаг. Тэр хүү хуруугаа ашиглан араб тоо тоолж, зураг зааж харилцдаг. Багш нь дууг хөдөлгөөнөөр зохиомжилж, дохионы хэл ашиглан ангийнхантайгаа хамт дуулах боломжийг түүнд өгсөн. Тэр одоохондоо сонсголын бэрхшээлтэй том хүнтэй харилцдаггүй ба Занзибарт дохионы хэл сайн хөгжөөгүй, гэвч энэ бол эхлэл билээ. Хүүгийн дохионы хэл сайжирч байгаа гэдэгт ахлах багш итгэж байгаа бөгөөд тэр хүү хүмүүстэй харьцах олон чадвартай болж байгаа.

Зарим соёлын хамрах хүрээнд, одоогийн байгаа сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилга байгууламж нь бага насны хүүхдүүдийн бодит хэрэгцээнээс илүү дунд сургуультай ижил төстэй албан боловсролд тохирох, мөн загварчлагдсан байдаг. Тэд багш төвтэй арга зүйтэй, тоглох боломж хомс, албан боловсрол олгох анги танхимтай, тангад ном үзэж байгаа юм шиг сурч (хичээлийн агуулгыг ойлгохгүй давтах замаар цээжлэх) урт цагаар хичээллэн академик ур чадвар олгож байна. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд төдийгүй ер нь ихэнх хүүхдэд тохиромжгүй юм.

Боловсролын тогтолцооны өөрчлөлтийг мэдээж хэрэг төр захиргааны боловсролын хэлтсүүд хариуцна. Гэсэн хэдий ч ХОТСЗ-ынхан бүх хүүхдүүд үр дүнтэй сурч болох сургалтын хөтөлбөр, заах арга зүй, сургалтын орчныг өөрчилж ажиллах боломжтой. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг сургуулийн өмнөх боловсролд тэгш хамруулахад ХОТСЗ зайлшгүй хэрэгтэй—энэ нь хүүхдэд шаардлагатай туслах хэрэгсэл, тохирох сэргээн засах тусламж, үйлчилгээ авахад нь тусална. ХОТСЗ мөн сургуулийн өмнөх боловсролд мэргэжлийн туслалцаа үзүүлэх, тулгамдсан асуудалд чиглүүлэх, орон нутгийнхны хэрэглэдэг энгийн стратеги нь бүх нийтэд үр ашгаа өгнө гэж үздэг. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш нар хүүхэд төвтэй, тэгш хамруулах хандлагыг бий болгоход өөрсдийгөө чадавхижуулна.



Жишээ 15 Хятад

Амжилтанд хүрсэн нь

Анхуй бол Хятадын ядуу аймаг бөгөөд 56 сая хүн амтай. Хэдхэн жилийн өмнө, цэцэрлэгт явдаг хүүхдүүд эгнээ болон сууж, багш нар нь хүүхдүүдээ хичээлийн явцад сууж байхыг шаарддаг байсан. Амжилттай байх уу, үгүй юу гэдэг нь хүүхдийн хариуцлагаас хамаардаг. Бага насны маш олон хүүхдүүд боловсролд хамрагдаж байгаа тогтолцоо нь сэтгэл хөдөлгөм, олон цэцэрлэгүүд мянга гаран хүүхдүүдтэй, багш нар нь туйлын хөдөлмөрч.

Хүүхдүүд идэвхитэй сурч болохыг харуулдаг дараах өөрчлөлтүүдийг туршилтын хөтөлбөр дэмжиж гүйцэтгэсэн нь: тогтмол жижиг бүлгээр ажиллах, тоглоомоор дамжуулан суралцах, гарын доорх материалыг ашиглан сургалтын хэрэглэгдэхүүн хийх, багшийг тогтмол сургах, орон нутгийн хороодуудыг байгуулж хамт олон, удирдлага, багш, гэр бүлүүд хоорондоо сургууль даяараа ойр дотно хамтарч ажиллах хандлага төлөвшүүлэх, анги бүрт суралцах бэрхшээлтэй 2 хүүхдийг хамруулах зэрэг болно.

Үр дүн нь сэтгэгдэл төрүүлмээр: боловсролын чиглэлийн төрийн байгууллагууд бүх хүүхдүүдийн сургалт сайжирсанд талархал илэрхийлж, боловсролын хариуцлагатай албан тушаалтнуудын байгаа байдалд өөрчлөлт гарсан—энэ нь “амар зүйл” биш, харин энэ нь тусгаарлахаас илүү “сайн зүйл” болсон. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд бага сургуульд орж амжилттай сурч байна.

Мэргэжилтнүүдийн үйлчилгээ нь хүртээмжтэй бөгөөд бололцоотой байх

Хөгжлийн бэрхшээлтэй олон хүүхдүүдийг бага насны хүүхдийн уян хатан, хүүхэд төвтэй боловсролын орчинд хамруулах боломжтой байдаг. Зарим тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг тэгш хамруулан сургахад бэлтгэх явдал мэргэжилтний ажлын байрны шаардлагад байдаг. Жишээлбэл: сонсголын бэрхшээлтэй хүүхдүүд дохионы хэл сурах, хараагүй хүүхдүүд брайль болон орон зайг баримжаалах чадварт сурах, хараагүй, дүлий хүүхэд орон зайг баримжаалах чадвар, хөдөлгөөний чадвар, брайль үсэг сурах гэх мэт. ХОТСЗ ажилтнууд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд мэргэжилтнүүдэд хандах, мэргэжилтнээр хангагч болон боловсролын байгууллага хоорондын холбоог ойртуулах бололцоотой.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд ба насанд хүрэгчдийг татан оруулах

Үлгэр дуурайл болох хүн, зөвлөгч, сургагч, менежер, шийдвэр гаргагч гэх мэтээр бага насны хүүхдэд тавих асаргаа, сувилгаа, боловсролын үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг шууд оролцуулах нь чухал. “Бидэнгүйгээр бидний тухай юу ч байхгүй” гэсэн зарчмыг бага насны хүүхдүүдтэй ажиллахдаа тэгш мөрдөж ажиллахыг санаж байх хэрэгтэй. Санал болгож байгаа бүх үйл ажиллагаанд хэрвээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс оролцвол илүү хамааралтай, үр дүнтэй. Хөгжлийн бэрхшээлтэй том хүүхдүүд хөгжлийн бэрхшээлтэй бага насны хүүхдүүдийн хэрэгцээ, шаардлагыг хангах бүтээлч санал, дэмжлэг, туслалцааг санал болгох бололцоотой байдаг.

Жишээ 16 ЭНЭТХЭГ

Сонсголын бэрхшээлтэй хүмүүсийн бүлэг

Энэтхэгийн Коимбатored эрт үед нь хүүхдийг хөгжүүлэх төв, цэцэрлэгийг сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулан нээсэн. Төвд ажилладаг мэргэжилтнүүд санал асуулгаар тухайн орон нутагт маш цөөн тооны сонсголын бэрхшээлтэй хүүхдүүд байгааг тогтоожээ. Төвийг нээснээс 2 сарын дараа ХОТСЗ-ын сонсголгүй 2 гишүүн өөрсдийн сүлжээ, найз нөхдийн хүрээнээс таваас доош насны хүнд хэлбэрийн болон бүрэн сонсголгүй 6 сурагчийг олж энэ бүлэгт нэгтгэсэн. Сонсголын бэрхшээлтэй хүмүүс сонсголын бэрхшээлтэй өөр хүмүүс хаана байгааг мэдэж байснаас зургаан сарын дараа хөтөлбөр 13 сурагчтай болж нэмэгдэн, дараагийн жилд олон сурагчид элсэхээр болсон. Эдгээр хүүхдүүдийн ихэнхийг цэцэрлэг, сургууль ба сайн дураараа оролцож байгаа сонсголгүй томчууд чиглүүлж байна.



Сургалт зохион байгуулах, мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх

Сургалт, хүмүүсийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх нь янз бүрийн олон бүлгүүдэд хэрэгтэй байдаг. Сургалтын агуулга, хэлбэр нь уян хатан байж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоодуудыг хөтөлбөрийн хэрэгжилт, боловсруулалтанд татан оруулдаг байх хэрэгтэй. Олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхдээ хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загварт анхаарах нь чухал. ХОТСЗ мэргэжилтнүүдэд бага насны хүүхдийн оролцоо, үйл ажиллагааны талаар сургалт хэрэгтэй байдаг. Бага насны хүүхэдтэй ажилладаг хүмүүс (багш нар, туслах ажилтнууд болон өдөр өнжүүлэх төвийн, цэцэрлэгийн, тоглох бүлгийн удирдан зохион байгуулагчид гэх мэт) хөгжлийн бэрхшээл болон тэгш хамруулах талаар суралцах хэрэгтэй. Санхүүгийн болон техникийн дэмжлэг үзүүлж чадах хүмүүстэй холбоо тогтоох хэрэгтэй. Орон нутгийн ба олон улсын төрийн бус байгууллагууд нь ихэнхидээ дэмжлэг, хандив үзүүлэх гол эх үүсвэр байдаг.

Жишээ 17 Шри Ланк

Тэгш хамрах боловсролд суралцахад багш нарыг дэмжих

Шри Ланкийн Хамбантота мужид цэцэрлэгийн олон тооны сурах бэрхшээлтэй хүүхдүүдийг илрүүлжээ. Дүүргийн хэмжээнд боломжтой үйлчилгээнүүдийг үзүүлж байгаад бага насны хүүхдийн хөтөлбөрийг хэрэгжүүлдэг олон улсын төрийн бус байгууллага тус бэрхшээлийг илрүлсэн. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд сургуулийн өмнөх боловсролд хамрагдах сонирхолтой байдгийг тэр төрийн бус байгууллага харуулсан, гэвч багш нар нь энэ тал дээр ур чадваргүй байгааг дурджээ. ХОТСЗ хөтөлбөр Шри Ланкад байгаа тэгш хамрах боловсролын талаар сургалт явуулах нөөц боломжийг судалж, оролцох цэцэрлэгийн багш нарыг төрийн бус байгууллагаас дэмжсэн байна. Сургалтын дараа багш нар болон ХОТСЗ-ын ажилтнууд хүүхдүүд, эцэг эхчүүдтэй уулзаж, хамтдаа тэгш хамран сургах төлөвлөгөөг боловсруулсан. Тэгш хамрах сургалтын хэсэгт эцэг эхчүүдийг оролцуулахад илүү их үр дүнгээ өгч амжилт олохын тулд тэд хариуцлагатай болжээ. Цэцэрлэгт явдаг хүүхдүүд болон тэдний эцэг эх тэгш хамруулах үйл явцад хамрагдаж, хөгжлийн бэрхшээлийн асуудлуудын талаар мэдлэг, ойлголттой болсон байна.

Ядуурлыг шийдэхэд анхаарах

Ядуурлын нөхцөл байдалд, гэр бүлүүд болон олон нийт тэдний үндсэн хэрэгцээгээ хангахад хэцүү байх, хүүхдүүдэд амьд үлдэхэд эсвэл тарчиг нөөц бололцооноос болсон дарамтанд нь туслалцаа зайлшгүй шаардлагатай болдог. Ядуурлын үед өлссөн болон өвдсөн хүүхдүүд сурах, тоглоход хэцүү байдаг. ХОТСЗ ажилтнууд бага насны хүүхдийн боловсролд анхаарахын зэрэгцээ ядуурлыг шийдвэрлэхэд анхаарах хэрэгтэй. (Амьжиргааны бүрэлдэхүүн хэсгийг үз) Зарим санал болгох үйл ажиллагаанууд:

- Гэр бүлүүдэд хөгжлийн бэрхшээлтэй балчир хүүхдүүдийг өөрийгөө халамжлах үндсэн чадвартай болгох нь тэд ямар нэгэн дарамтанд бага өртөх, илүү биеэ даасан болгодогийг ойлгуулж, туслах
- Гэр бүлийн өдөр тутмын хэвшсэн ажилд тохирсон үйл ажиллагаануудад анхаарал хандуулж, хүүхдүүд эдгээр үйл ажиллагаанаас хэрхэн суралцаж байгааг нотлон харуулах, тэд гэр бүлийн амьдралын нэгдсэн хэсэг болно. Нэн ядуу нөхцөл байдалд, гэр бүлүүд ялангуяа, эхчүүдэд нэмэлт хариуцлага биш нэмэлт дэмжлэг хэрэгтэй, тиймээс ХОТСЗ-н ажилтнуудын хандалт маш чухал юм.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхчүүд ба эмэгтэйчүүдэд зориулсан өөртөө туслах бүлгүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооны хөгжилд дэм болох (Эрх мэдэл олгох бүрэлдэхүүн хэсгийг үзэх)
- Гэр бүлүүдийг төрийн тэтгэлэг хүртэх, төрийн бус байгууллагуудаас хандив дэмжлэг авах, хандив өгөгчид болон орон нутгийн бизнесүүд, бусад төрлийн эх сурвалжуудаас хандив хөрөнгө мөнгө авах зэрэгт туслах
- Бага насны хүүхдүүдийн боловсролын хөтөлбөр нь уян хатан бөгөөд ядуу гэр бүлийн болон ноцтой болон олон төрлийн гэмтэл согогтой гэр бүлүүдийн янз бүрийн нөхцөл байдалд хариу өгөх



Жишээ 18 Монгол

Боловсрол олгодог хөдөлгөөнт сургууль

Монголд нүүдэлчин, малчдын бага насны хүүхдийн боловсролыг “Гэр” цэцэрлэгээр олгодог. Тэр нь нүүдэлчин хүмүүсийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн жилийн 4 улиралд нүүдэллэн үйл ажиллагаагаа явуулдаг. Эдгээр цэцэрлэгүүд нь хүүхдүүдтэйгээ байнга хамт байж тэдний хувцаслах, хооллох зэрэг үйл ажиллагаанд оролцож чаддаггүй гэр бүлүүдэд хүрч үйлчилдэг. Сургалтын хөтөлбөр, хандлага нь уян хатан, хагас өдрөөр хичээллэдэг. Эцэг эхчүүд болон олон нийт энэ гэр цэцэрлэгийг барих, нүүхэд тусалдаг, яагаад гэвэл энэ нь тэдэнд үнэ цэнэтэй зүйл юм. Энэ цэцэрлэгийн элсэлт нь нэмэгдэж байгаа бөгөөд орон нутгийн бага сургуулиас гадуур орхигдсон хүүхдүүд тустай юм.

Тэгш хамрагдахыг уриалах ба хамгаалах

Хамрах сургалтыг нэмэгдүүлэх, систем өөрчлөлт шаардлагатай болоход ХОТСЗ хөтөлбөр дангаараа боловсролын системийг өөрчилж чадахгүй. ХОТСЗ-ынхан эвсэл холбоо болон хамтрагч нарыг таньж олох хэрэгтэй. Бусад гол хүмүүстэй (үндэсний болон нутгийн) хамтран ажиллахад, ХОТСЗ хөтөлбөр сургуулийн тоног төхөөрөмжийг хангахад өмгөөлөл болж чадна. Олон тохиолдолд үйлчилгээ эрхлэгчид хамруулах бодлого болон одоогийн хуулиудыг дээдлэдэг боловч үүнийг хэрэгжүүлэхэд төсөвт дэмжлэг үзүүлж, туслаж чаддаггүй. ХОТСЗ хөтөлбөр боломжтой газар бүрд барилга, тоног төхөөрөмж шинээр бий болгосноос одоо байгаа барилга, тоног төхөөрөмжөө хамруулахад нөлөөлөх хэрэгтэй.

Яаралтай тусламж, мөргөлдөөн болон цагаачлалын нөхцөл байдалд бэлтгэх

Бага насны хүүхдүүд эрүүл байх нь ямарваа нэг яаралтай тусламж, мөргөлдөөн эсвэл байгалийн аюултай үзэгдлийн үед чухал ач холбогдолтой. Яагаад гэвэл энэ нь маш уян хатан, бага насны хүүхдийн боловсрол нь иймэрхүү нөхцөл байдлыг даван туулахыг заадаг цөөхөн боловсролын нэг юм. Тоглох нь тамир тэнхээ өгөх ба эрүүл байхыг дэмждэг. ХОТСЗ хөтөлбөр нь тоглох үйл ажиллагаанд таатай боломж болон хүүхдэд ээлтэй орчинд хамруулахад туслаж чадна; энэ нь ихэнхидээ НҮБ-тай харьцахтай адил төрийн бус байгуулагууд болон төрийн байгууллагын үйлчилгээтэй харьцах гэсэн утгатай байдаг (Нэмэлт товхимол: ХОТСЗ ба хүмүүнлэг үзлийн хямрал)

Бага боловсрол

Танилцуулга

Бага боловсрол нь ихэнхдээ зургаа юм уу долоон настайгаас эхэлж өсвөр нас хүртэл үргэлжилдэг. Бага боловсрол нь өндөр түвшний боловсрол эзэмших үүд болж өгдөг бөгөөд хөгжлийн нэн чухал зүйл юм.

Бүх нийтээрээ бага боловсролтой болох нь Мянганы Хөгжлийн Зорилтын хоёр дахь зорилт юм. 2015 он гэхэд хүүхдүүд ха, охид хөвгүүд адилхан бага боловсрол эзэмших боломжтой болохоор зорьж байна (7). Энэ зорилгод хүрэхийн тулд сургуулийн систем нь багш нарыг сургах, анги танхимыг байгуулах, сургалтын чанарыг дээшлүүлэх, ирцэд саад болох төлбөр ба тээвэрлэлт гэх мэт зүйлсийг арилгах, хүүхдийн аюулгүй байдалд эцэг эхчүүдийн санаа зовоож байгаа зүйлд анхаарах хэрэгтэй (20).

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг тэгш хамруулахгүй бол энэ зорилгод хүрэх боломжгүй юм. UNESCO одоогийн байдлаар буурай хөгжилтэй орны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн 90-с илүү хувь нь сургуульд сурдаггүй гэж тооцоолсон байна (6). Тэдгээрийн ихэнхи нь дунд сургуулиа дүүргэхээс өмнө сургуулиа хаядаг ба нөгөө хэсэг нь ихэнхидээ сургуульд огт сураагүй байдаг байна.

Бага боловсрол нь бүгдэд ерөнхий бөгөөд ойлгоход хялбар байх ёстой. Бүх нийтэд боловсрол олгох ямар ч байгууллага хүйс, яс үндэс, хэл, шашин, үзэл бодол, хөгжлийн бэрхшээл, нийгмийн болон эдийн засгийн байдлаар нь ялгаварлан гадуурхаж болохгүй(5). Бага боловсрол нь тун чухал эрх ба Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тунхаг бичиг, 24 –р зүйлд дурьдсанчлан “ . . . хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд үнэ төлбөргүй бөгөөд заавал



эзэмших боловсролын гадуур үлдэх ёсгүй (4) Бага боловсрол нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хамарсан, чанартай сургалтаар хангадаг, тэгш хүртээмжтэй бөгөөд орон нутгийн хамтын нийгэмлэгт байх ёстой.

Жишээ 19 Мали

Бага боловсрол бүх хүүхдүүдэд

Дэлхийн хамгийн ядуу хэсэг болох Малигийн Доуентза дүүрэгт орон нутгийн хамтын нийгэмлэг нь хүүхдүүддээ боловсрол олгохыг чухалчилж үздэг. Тэд өөрсдийн гацаандаа нутгийн амьдралтай холбоотой, хүүхдүүдийг олон нийтийн ажил амьдралд бэлтгэх сургалтын хөтөлбөртэй сургуультай болохыг хүсдэг.

Хандивлагч байгууллагууд дадлага, дэмжлэг санал болгохдоо Сургуулийн Хороонд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд болон охидыг элсүүлэхийг хариуцдаг эмэгтэй хүн байх ёстой гэсэн болзол тавьдаг. Хамтын нийгэмлэг эцэг эхчүүдийн эдийн засгийн хандив оролцоотойгоор өөрсдөө сургуулиа барьж хариуцлага болон өмчлөх эрхийг зохион байгуулдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн төрийн бус байгууллагын мэргэжилтнүүд хөгжлийн бэрхшээлийн асуудлын талаарх ухамсарыг нэмэгдүүлэх ажлыг гүйцэтгэж сургуулийн хамт олонд элсүүлэх хүүхдүүдийг сонгож авахад тусладаг. Төрийн бус байгууллагаас өгсөн гурван дугуйт зарим хүүхдүүдэд хэрэгтэй байдаг. Орон нутгийн театр болон хөгжимчдийн групп бас охидууд болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурах эрхийн талаарх ухамсарыг нэмэгдүүлэхэд тусладаг.

Нийгэмлэгийн удирдагчид өөрийн тосгонд байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн тоог хараад алмайрцгаасан бөгөөд нийгэмлэг өөрөө эдгээр хүүхдүүдийг хөгжүүлэхэд гэр бүлийн гишүүдтэй нь хамтран ажиллах замаар туслаж чадна гэдэгт гайхжээ. Үүнээс өмнө хөгжлийн бэрхшээл гэдэг нь бодож эргэцүүлээд байхаар асуудал болж байгаагүй, учир нь үүнийг шийдвэрлэх арга зам байгаа гэдгийг олон нийт мэдээгүй байжээ.

Эхэндээ нийгэмлэгийн гишүүд болон багш нар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хамруулах тал дээр эргэлзэж байсан. “Эхлэхийн тулд бид хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хамруулна гэсэн үүрэг амлалт авсан ч тэднийг сургуульд байж чадна гэдэгт үнэндээ итгээгүй. Одоо бид өөрсдийгөө амлалтаас итгэл үнэмшил рүү шилжиж байгааг харж байна”. Гэр бүлүүд, нийгэмлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн алба, олон улсын хөгжлийн төлөөлөгчийн газар зэргийн хамтын ажиллагаагаар нөхцөл байдал хэдий муу ядуу байсан ч цаг хугацаа өнгөрөх тусам оролцоог дэмжиж тогтвортой барих болно гэжээ.



Зорилго

Боловсролын үйл ажиллагааны цөм нь болсон орон нутгийн сургуулиудад тэгш хамрах бага боловсролын тогтолцоог бий болгох

ХОТСЗ-ЫН ҮҮРЭГ

ХОТСЗ-ын үүрэг нь бага боловсролын тогтолцоотой хамтран ажиллаж, орон нутагт хамрах сургуулийг бий болгож, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, гэр бүлийг нутгийн хамт олны дунд дунд боловсролтой болохыг дэмжиж, сургууль, хамт олон, гэрийн хоорондох уялдааг бататгах, хөгжүүлэх юм.

Хүсч буй үр дүн

- Хамт олон бүхэлдээ хамрах дунд боловсролыг хөгжүүлэхийг хүлээх
- Гэр бүлүүд хамрах дунд боловсролд нааштайгаар туслаж дэмжин оролцож
- Хөгжлийн бэрхшээлтэй бүх хүүхдүүд чанартай дунд боловсролыг эзэмших
- Зөв зохистой тоног төхөөрөмж, эмчилгээ болон бусад хэрэгцээтэй тусламж дэмжлэгүүд нь хамрах сургалтыг явуулахад дөхөм болно.
- Сургуулийн хүрээлэн байгаа орчинд нэвтрэх асуудал танигдсан хаягтай байх
- Багш нарыг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг сургахад өөрсдийн ур чадвар, болоцоондоо итгэлтэй байхаар дэмжих
- Сургалтын хөтөлбөр, шалгалт үнэлгээ өгөх систем, багшлах арга зам, нэмэлт сургалтын хөтөлбөр (спорт, хөгжим, клуб гэх мэт) нь хүүхдэд чиглэсэн, хамааруулсан
- Боловсролын орон нутгийн болон мэргэжлийн нөөц бололцоог зөв зохистой бүрэн дүүрэн ашиглах
- Ядуу гэр бүлийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд дунд сургуульд хамрагдах
- Түншлэл нь дунд боловсролын үндэсний бодлогыг хөхүүлэн дэмжиж, өмгөөллийг бүх шатанд бий болгох, холбогдох гол хүнийг бий болгох

Гол ойлголтууд

Олон нийтийн хандлага

Бүхэл хамт олны үүрэг хариуцлага нь хамрах сургалтыг дэмжих, сурталчлах орон нутгийн сургуулиудыг харуулахын тулд таатай нөхцөл, орчноор хангах явдал юм. ХОТСЗ хөтөлбөрийнхөн олон үүрэг хариуцлагатай бөгөөд боловсролын талаар мэргэшээгүйн улмаас тэд хамт олонтой (сургуулиуд, гэр бүлүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, нийгэмлэгийн удирдагчид) хамтран ажиллаж, эрхийн талаарх ухамсрыг нэмэгдүүлэх, хамруулах, бие хүн тэдгээртэй хамаатай дэмжлэг үзүүлэхэд анхаарлаа хандуулах хэрэгтэй. Эцэг эхчүүд өөрсдийн хүүхдээ мэддэг бөгөөд багш нарт маш чухал тус болох мэдээллийг өгч чадна. Багш нар эцэг эхчүүдэд гэртээ зааж сургах талаар дэмжлэг өгч туслаж чадна. Мужийн боловсролын албан газар нь хэрвээ тогтвортой оршиж чадвал хамруулах сургалтыг дэмжиж хангаж байх болно. Эрүүл мэнд нийгмийн салбар нь өөр хоорондоо уялдаа холбоо хамааралтай байх. Хэрмэл (аялж яваа) багш

нар бүгд өөр үүрэгтэй байж холбоо тогтоон төрөл бүрийн дэмжлэг хандивыг санал болгоно. Эдгээр багш нар нарийн тодорхой Брайл заах, дохионы хэл заах, хөгжлийн бэрхшээлтэй сурагчдад, тэдний багш нарт, эцэг эхчүүдэд сургууль хүрэх замдаа зөвлөгөө өгөх, нөөц бололцоо, хандив, дэмжлэг үзүүлэх гэх мэт ур чадвартай байдаг.

Жишээ 20 Перу

Юригийн сурах шинэ зам

Юри хүү Перугийн Андын нуруунд ээж, эгч нартайгаа хамт амьдардаг. Юри тархины төрөлхийн саажилттай учир алхаж чаддаггүй. Тэр эгч нар шигээ дунд сургуульд явахыг хүсдэг ч, тэр янз бүрийн саадтай учирдаг. Түүний гэрээс гол зам хүрдэг боломжийн зам, тээвэр байдаггүй, орон нутгийн дунд сургуулийн багш нар хөгжлийн бэрхшээлийн талаар ямар ч дадлага, ухамсар байдаггүй. ХОТСЗийнхан Юригийн ээжид эрх олгуулахад анхаарлаа төвлөрүүлж, дараа нь олон нийт түүний гэрээс гол зам хүрэх замыг тавьж өгсөн байна. ХОТСЗхөтөлбөр тэргэнцэр болон багш нараар хангаж өгсөн. Юри дунд сургуульд элсэн орж бусад сурагчидтайгаа танилцах үдэшлэг хийжээ.

Сургуулийн хандлага

Сургуулийн хандлага нь менежерүүд, ахлах багш нар, ангийн багш гар, удирдан зохион байгуулагч, халамжлагчид, эцэг эхчүүд, хөгжлийн бэрхшээлтэй болон бэрхшээлгүй хүүхдүүд болон сургуультай холбоотой бусад хүмүүс хамтран орон нутгийн сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хамруулах, тоног төхөөрөмжийн саад бэрхшээлийг арилгах, хөгжлийн бэрхшээлийг тогтоох, ухамсрыг нэмэгдүүлэхийн тулд хамтран ажиллана.

Жишээ 21 Сири

Тэгш хамрах боловсролыг дэмжиж өөрчлөлт хийх

ХОТСЗ-ийнхан JICA(Японы Олон Улсын Хамтын Нийгэмлэг)-ээс Сирийн Дамаскасын зах хэсэгт сургуулиудын эрх мэдэлтнүүд, орон нутгийн удирдагчид, зохион байгуулах эрх мэдэлтнүүд, багш нар болон сургуулийн хүүхдүүдтэй дунд сургуулийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг элсүүлэх, хамруулан сургахад хялбар дөхөм болгох талаар хамтран ажилласан. Тэд самбарууд, суудлын зохион байгуулалт, ангийн орох хаалга, бие засах газар болон тоглоомын талбай зэргийг өөрчилж шинэчлэн засварласан. Орон нутгийн сайн дурынхан болон багш нар Дамаскаст дохионы хэл заах талаар дадлагажсан. Хүүхдүүд, эцэг эхчүүд, багш нар болон орон нутгийн төр захиргааны байгууллагууд нутгийн сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг сургахын ач холбогдлыг ойлгоцгоосон.

Нийгэмд хамруулах

Бусадтай хамт сурч, амьдрах нь, өөр өөр хүмүүстэй холбоотой байх нь, нээлттэй байх, бусдад туслаж, хүндэтгэж байх нь хичээлээр мэдлэг чадвар олж авахтай адил чухал зүйл юм. Орон нутгийн сургуулийн орчинд олон хүнтэй хамт байх нь хичээлээр мэдлэг олж авахад хүндрэлтэй хүүхдүүдэд илүү үр ашигтай байж болно. Энэ нь мөн бүх хүүхдүүдийг нийгэмд хамруулан гишүүн болоход нь бэлддэг.

Олон янз байдалд хариу үзүүлэх нь

Хүүхдүүд бүгд бие биеэсээ ялгаатай бөгөөд өөр өөр арга замаар суралцдаг. Сургуулиуд энэ төрөл бүрийн асуудалд сургалтын хөтөлбөр, заах арга барил, хүрээлэн байгаа орчин зэрэг нь уян хатан бөгөөд бүгдийг байршуулах зэргээр хариу болгож юм хийх хэрэгтэй. Уян хатан систем нь зөвхөн хэсэг бүлэг хүмүүст биш хүн болгонд тохирсон зохицуулалт хийхийг шаарддаг. Хамруулах сургалтын хамгаалал нь хэрвээ бусад орхигдсон хүмүүстэй хамтран холбоо эвслүүдийг байгуулбал илүү хүчтэй болно. Сургууль нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд таатай, сайн болвол тэр нь бүх хүүхдүүдэд ч мөн таатай сайн сургууль болох бөгөөд бусад орхигдсон хаягдсан бүлгүүдийн хүүхдүүдийг хамруулж болно.

Мөн олон төрлийн зүйлд хариу үзүүлэх гэдэг хэдийгээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд ижил төрлийн гэмтэл, согогтой байсан ч хоорондоо огт харилцан адилгүй гэдгийг танин мэдэх явдал юм. Жишээлбэл, харааны доголдолтой хүмүүс сургалтын хөтөлбөрийг өөр өөр замаар хүлээн авдаг: хэн нэгэнд хуурцагны бичлэг сонсох нь хэрэг болдог байхад, нөгөөд нь Брайл илүү тус болдог байх жишээтэй. Сонсголын бэрхшээлтэй зарим хүүхдүүд уруулын хөдөлгөөнөөр уншихдаа сайн байхад, нөгөөдүүлд нь дохионы хэл хэрэгтэй байх зэрэг.

Таатай, хүртээмжтэй орчин

Судлаачид хүртээмжтэй байх явдал нь тэгш хамрах сургалтын өртгийг багасгадаг гэж зөвлөдөг (21). Сургуулийн хүрээлэн байгаа орчин нь бүх хүүхдүүдэд хялбар дөхөмтэй, бие засах газрууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд хэрэглэхэд хялбар байх тал дээр онцгой анхаарах хэрэгтэй. Сургуулийн хүрээлэн байгаа орчин, уур амьсгал, зэрэг нь бүгдийг найрсгаар угтан авахаар харагдахуулахад анхаарах хэрэгтэй. Цэвэрхэн сургууль (ариун цэврийг зохистойгоор сахисан, цэвэр усны хангамжтай гэх мэт) өнгийн хананууд, хүүхдүүд, багш нар, бусад ажиллагсадын зөв харьцааны соёл зэрэг нь таатай угтан авах орчинг бүрдүүлдэг.

Суралцагч төвтэй хандлага

Сургууль дээр юу болж байна вэ гэдэг нь хандалттай адил чухал зүйл юм. Суралцагч төвтэй эсвэл хүүхэд төвтэй чиг хандлагын утга нь сургуулийн үйл ажиллагаа болон бүтэц зохион байгуулалт нь хүүхэд бүрийг сурах, оролцохыг дэмжих гэдэгт төвлөрсөн байна. Багш нар хөдлөшгүй тогтсон сургалтын хөтөлбөр эсвэл цагийн хуваарь зохиох, засварлах нь анхаарлын төвд нь байж хүүхэд сурч байна уу гэдгийг үл хайхрах нь олонтаа. Суралцагч төвтэй гэдэг мөн “тохиромжтой нас” гэсэн утгыг давхар агуулдаг. Заримдаа хөгжлийн

бэрхшээлтэй хүүхэд нь үеийнхэнтэйгээ адил цаг хугацаанд суурь боловсрол эзэмших насандаа хангалттай эрт танигдаж чадахгүй байх магадлалтай. Оюун ухааны хомсдолтой хүүхэд насаараа том ч сэтгэхүй нь наснаасаа залуу байдаг. Хүүхдийн жинхэнэ насыг авч үзэх нь чухал.

Уян хатан бага боловсрол

Дунд боловсрол нь ихэнхидээ барилга дотор явагддаг боловч энэ нь зайлшгүй чухал зүйл биш юм. Сургуулийн үүргийн талаарх санааг өөрчлөхгүй байх нь чухал юм. Нилээд хэдэн гэмтэл, бэрхшээлтэй зарим хүүхдүүд хэдийгээр тэд гэрээрээ боловсрол олдог ч гэсэн дунд сургуульд явж байна. (албан бус боловсрол сэдвийг үз) Хамрах сургалт гэдэг шууд утгаараа хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бүрийг сургуулийн байранд авчрах ёстой гэсэн үг биш юм. Гэхдээ энэ нь сургуулиуд өөрчлөгдөхгүй байх шалтгаан биш бөгөөд сургуулийн ажил нь хамруулах тал руу байх нь чухал юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хасах эрх сургуульд байхгүй(4).

Жишээ 22 ЭНЭТХЭГ

Тэгш хамрах боловсролыг дэмжихэд хамт олныг

Сарва Шикша Абхиян бол Энэтхэгийн засгийн газрын бүх төрлийн холимог тэргүүлэх хөтөлбөрийн бүх нийтийн анхан шатны боловсрол түгээх ажлыг хариуцдаг. Хэдэн хэдэн бүлгүүд дэд дүүргүүдийн түвшинд эцэг эхчүүд, багш нар, олон нийтийг хамруулах сургалтын талаар ухуулан таниулахаар зохион байгуулагдсан. Системтэй хүчин чармайлтын дүнд орон нутгийн төрийн бус байгуулагууд, сэргээн засах болон тоног төхөөрөмжөөр туслах эмнэлэгүүдтэй сүлжээг бий болгосон. Хөтөлбөрийн хүрээнд бүх сургуулиудад нэгдсэн дамнуурган налуу замыг барьж босгосон. Хичээлийн анги танхимын сахилга батын менежмент дээр ажиллах байгууллага, хамруулах сургалтыг хөгжүүлэхэд хэрэгцээтэй гарын авлага, заах, сурах тусгай материал хэрэглэх зэрэг бусад үйл ажиллагааг явуулсан.

Төр засгийн байгууллагууд хөтөлбөрийн хүрээнд нарийн ээдрээтэй эсвэл ноцтой гэмтэлтэй хүүхдийг өөрсдийн гэртээ гэрийн багшаар заалгах тусгай хангамжийг олгосон. Ноцтой хөгжлийн бэрхшээлтэй, сургуульд явах боломжгүй гурваас таван хүүхэд тутамд нэг гэрийн багш зааж, хүүхэд болон эцэг эхчүүдийг өдөр тутмын амьдралд хэрэгтэй чадвар, үндсэн эмчилгээнд дадлагажуулдаг.

Нөөц бололцоо ба мэргэжилтний дэмжлэг

Тэгш хамрах үзэлд эргэлзээ төрүүлж байсан 2 алдаатай ойлголт байсан нь 1) Энэ нь өтрөг зардал өндөртэй мэргэжлийн боловсон хүчний нөөцтэй үед л хэрэгждэг гэх үзэл 2) Нэмэлт нөөцийг шаарддаггүй гэх үзэл. Хоёулаа худлаа юм. Тэгш хамрах бага боловсрол нь өртөг зардал хэмнэх бололцоотой. Гэсэн хэдий ч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэдний гэр бүл төр засгаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг тусгай сургуульд чанар муутай хамруулах, ердийн сургуульд ямар нэгэн дэмжлэг тусалцаагүйгээр сургах байх гэж адилхан санаа зовдог. Нөөц бололцоо, дэмжлэг тусалцаатай холбоотой 2 чухал ойлголтыг доор өгүүлье.

- Орон нутгийн нөөц бололцоог ашиглах: Хүүхдүүдийг сурахад хэрэгцээтэй ихэнх нөөц бололцоо, дэмжлэг нь “онцгой” зүйл биш. Орон нутгийн нөөц бололцоог (материалын, санхүүгийн, эсвэл хүний нөөцийн) ашиглах хэрэгтэй.
- Мэргэжилтнүүдийн туслалцаа дэмжлэгийг авах: хөгжлийн бэрхшээлтэй зарим хүүхдүүдэд хамруулах сургалтыг явуулахад нэмэлт тоног төхөөрөмж, мэргэжилтнүүд хэрэгтэй байж болно. Мэргэжилтнүүдийн ур чадвар, дэмжлэг болон Брайлыг сурахад хэрэгцээтэй багаж хэрэгсэл, эсвэл харилцаа холбооны үг ярианд нэмэлт болон уламжлалт хэлбэрийг ашиглан сурах, тэмдэглээтэй пайз, график, хүснэгтүүд, дохио зангаа, электрон тоног төхөөрөмжүүд, зурагнууд (Эрүүл мэндийн бүрэлдэхүүн хэсэг: Тоног төхөөрөмжүүдийг ашиглах) ашиглах

Жишээ 23

Уян хатан хандлагыг дэмжих

“... хамрах сургалтын талаар та тогтсон санал бодолтой байвал энэ нь танд нөөц бололцооны талаар тогтсон санааг өгнө. Хэрэв та хамрах сургалтын талаар уян хатан санал бодолтой байдаг бол та нөөц бололцооны талаар илүү уян хатан хандлагатай болно”. Оролцогч: Нөөц бололцоонд тулгарах саадыг давж гарах, Боловсролын сүлжээний боломж, семпозиум, 2000 (22)

Санал болгож буй үйл ажиллагаанууд

Хамт олныг дайчлах

Хамт олон бүрд дунд боловсрол нь өөр өөр нөхцөл байдлаар үнэлэгддэг. Магадгүй зарим орон нутгийн дунд сургуулиуд хамруулах сургалтын дэмжлэгтэй байхад нөгөө хэсэгт байхгүй байж магадгүй. Заримдаа дунд сургууль ерөөсөө байхгүй байж ч магадгүй. Зарим хамт олон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдээ тусгай сургууль эсвэл тусгай хэсэгт явуулах уламжлалтай байж ч болно. Ямар ч нөхцөл байдалд эхлэх цэг нь хамт олны хамрах сургалтыг дэмжих, энэ талаар ухамсрыг дээшлүүлэх нь чухал юм. Санал болгож буй үйл ажиллагаануудыг доор дурдая.

- Радио, олон нийтийн цуглаан, сурталчилгааны самбар, гудамжны театр, телевиз, интернет болон Олон Улсын Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Өдөр зэрэг тусгай үйл явдлуудыг ашиглан хамрах сургалт ба бүх нийтийн боловсрох эрхийн талаарх ухамсарыг дээшлүүлэх нь маш чухал.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллага болон эцэг эхчүүдийн холбоо хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг сургуульд элсэхэд саад болох зүйлүүдээс урьдчилан сэргийлэх талаар хэлэлцүүлэг явуулахад оролцох
- Хүүхэд хүүхэддээ гэсэн үйл ажиллагааг сургууль дээр хэрэглэж хүүхдийн ухамсрыг дээшлүүлэх
- Одоо байгаа бодлого, нөөц бололцоог хамрах дунд боловсролын дэмжих хүчин зүйл болгох



Жишээ 24 Монгол

Анд нөхдийн бүлэг байгуулж ойлголт нэмэгдүүлсэн нь

Улаанбаатар хотын ерөнхий боловсролын 24, 15, 16-р дунд сургууль дээр “Анд нөхдийн бүлэг” байгуулагдав. Анд нөхдийн бүлгийн гол зорилго нь өөрийн сургуульд сурч буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн талаар зөв ойлголтыг бусад анги хамт олон, эцэг эх, багш нарт зориулж хүүхдүүд өөрсдөө зохион байгуулав. Үүний үр дүнд хөгжлийн бэрхшээлийн талаар сурагч, багш нар, ялангуяа бусад хүүхдүүдийн эцэг эхчүүд ойлголттой болж, эерэг хандлага бий болоход онцгой ач холбогдолтой болсон.

Энэ үйл ажиллагааг Хүүхдийн Төлөө Үндэсний Газрын “Хүүхэд-хүүхэддээ хандлага” төслийн хүрээнд зохион байгуулсан юм.

Гэр бүлийг татан оролцуулах, дэмжих

Орон нутгийн сургууль хамруулан сургадаг болоход гэр бүлийг хамруулах, дэмжихэд ХОТСЗ-ынхан гол үүрэг гүйцэтгэнэ. Багш нар боловсрол олгоход эцэг эхчүүд байнга хамтрагч болдог гэдгийг сурах хэрэгтэй.

Жишээ 25 Морокко

Хүүхдийн төлөө хамтран ажиллах

“Үүнээс өмнө бид эцэг эхчүүд бол дайснууд гэж боддог байлаа. Одоо бид тэд нар бидэнтэй нэг тал бөгөөд бид хүүхдүүдийнхээ төлөө хамгийн сайн сайхныг хийхийг хүсч байна”. Багш, Морокко, хамрах төсөл (23)

Санал болгож буй үйл ажиллагааны жишээг доор жагсаав.

- Гэр бүлийн гишүүдтэй ярилцаж тэднийг сонсох. Тэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийнхээ талаар хүүхдийн чадавхи болон хүчээ сорих эрмэлзэл нь юу болон юу мэддэгийг олж тогтоож гэр бүлд хэрэгтэй дэмжлэгийг өгөх
- Гэр орон болон сургуулийн хооронд холбоо тогтоож, гэр бүлийн гишүүд болон багш нарыг нэг нэгийгээ сонсдог болгох
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг гэртээ сайн ажиглаж сургуульд сурч болох зүйлсийг гэртээ үргэлжлүүлэх арга замыг нээж олох, дэмжих
- Хүүхдийн ашиг сонирхолын төлөө, түүний эрхийг хамгаалсан шийдвэр гаргахад туслах, заримдаа эцэг эхчүүд хэтэрхий их хамгаалдаг эсвэл хүүхдийнхээ боломж чадварт бүрэн итгэдэггүй, эсвэл өөрийн бусад хүүхдээ нэн тэргүүнд тавьдаг.
- Эцэг эхчүүдийн дэмжлэгтэйгээр хамрах сургалтыг нэмэгдүүлэх. Эцэг эхчүүд гол дүрд тоглож чадна – эцэг эхчүүд нэгдэж хүүхдүүдийнхээ сурдаг орон нутгийн сургуулийн хандлагыг өөрчилсөн жишээ олон байдаг.

- Хөгжлийн бэрхшээлгүй хүүхдийн эцэг эхчүүдтэй хамтран ажиллаж хамрах сургалтыг тэдний дэмжлэгтэйгээр хөхүүлэн дэмжих. Эдгээр эцэг эхчүүд хамрах сургалтын талаар өөр өөр ойлголттой байдаг ба зарим нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй нэг ангид сурах нь тэдний хүүхдүүдийн нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлнэ гэж үзэж дэмжих шийдвэр гаргадаг бол нөгөө хэсэг нь тэдний хүүхдүүд шоовдорлогдон гадуурхагдана гэж үздэг.

Жишээ 26 Лесото

Боловсролын тэгш хамтрагч

Лесотод эцэг эхчүүд хамрах сургалтыг дэмжиж хамтран ажиллаж ойрхон байдаг. Тэд өөрсдийгөө багш нартай “ тэгш хамтрагчид” гэж үздэг. Оролцоо нь хүүхдүүдээ яаж удирдаж чиглүүлэхийг багш нарт зөвлөж, туслах, багш нарын дадлагын үйл ажиллагаанд туршлагаасаа хуваалцаж, ярилцацгаахгэх мэтийг багтаадаг. Дадлагажуулагч эцэг эхчүүд болон эцэг эхчүүдийн нөөцийн хүн нь сургууль болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үндэсний холбоо зэрэг гол бүлгүүдтэй хамтран ажилладаг. Түүнчлэн эцэг эхчүүд хөтөлбөрөөс ололт ахицыг олж мэдэрч, хүүхдүүдийнх нь өөртөө итгэх итгэл нэмэгдсэн зэрэг тэдний хэрэгцээг олж мэдэж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дэмжих

Хөгжлийн бэрхшээлтэй олон хүүхэд дунд сургуульд ороход эрүүл мэндийн байдал муу, хүрээлэн байгаа орчны саад бэрхшээл, гэр сургууль 2-н хоорондох зай хол, нийтийн тээврээр үйлчлүүлэхэд хүндрэлтэй зэрэг олон саад бэрхшээл гардаг. Зохистой эмчилгээ, асаргаа, сэргээн засалтанд тохиромжтой тоног төхөөрөмж зэрэг нь эрүүл мэндийн болон биеийн байдлыг дээшлүүлэхэд тусламж болно. (Эрүүл мэндийн бүрэлдэхүүн хэсгийг үз). ХОТСЗ-ынхан хүүхдүүдэд эдгээр үйлчилгээг авахад дэмжлэг болох хэрэгтэй ба эхний алхам бол гэрээс гарахад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй зүгээр хүүхдүүд байнга хамт гарах, дунд боловсролыг эзэмших сургуульд хамт хүрэх зэрэг юм.



Жишээ 27 Кени

Блэйс өөрт хэрэгтэй дэмжлэгүүдээ авсан нь

Блэйс хүү Кенийн Найробид ядуусын хороололд амьдардаг. Тэр төрөхдөө нуруу нугасны ивэрхий өвчтэй төрсөн бөгөөд үүнээс болж хоёр хөл нь саажиж мэдээгүй болж, давсгаа барьж чадахаа больсон. Блэйс Кенийн Хөгжлийн бэрхшээлтэй Хүмүүсийн Холбооны ХОТСЗХ-хэн түүнтэй холбоо барьтал гэртээ байдаг байсан. Тэд түүнд маш хэрэгтэй мэс засалд ороход тусалсан бөгөөд сэргээн засал хийж ба 1000 гаруй сурагчтай орон нутгийн дунд сургуульд элсүүлсэн.

Сургуульд явсан эхний өдрүүддээ Блэйсийн найзууд нь өглөө, орой болгон Блэйсийг нуруун дээрээ үүрч, сургууль дээр байхдаа живхийг нь сольж өгч байлаа. Орчны нөхцөл байдал нь Блэйсийг сургуульд явахыг нь болиулж чадаагүй. Хичээлийн дараа түүний хөршүүд нь түүний өвчин нь халдваргүй, тэдэнд хохирол учруулахгүй байсан тул түүнд тусалж дэмжиж байсан. Одоо Блэйс 7-р ангид сурдаг бөгөөд ХОТСЗ-ын өгсөн тэргэнцрээр сургуульдаа явдаг. Түүнийг бас өөрөө гуурсаар бие засахад сургасан. Түүнд тусламж хэрэг болсон үед түүний найз нар нь эргэн тойронд нь байж, тусалж байдаг. Тэр маш сайн сурч байгаа бөгөөд том болоод эмч болохыг хүсдэг.

Сургуулийг таатай, хүртээмжтэй болгоход туслах

ХОТСЗ-ынхан сургуулийн орчныг хүртээмжтэй болгоход багш, сурагчид болон гэр бүлийнхнийг татан оролцуулж чадна. Хүртээмжтэй орчин гэдэг нь хүүхдүүд тэргэнцрээр явах дамнуурган замаар хязгаарлагдахгүй илүү ихийг таньж олох нь чухал. Дараах асуултуудыг авч үзэх хэрэгтэй.

- Орчин нь хир таатай, хүртээмжтэй байх вэ? Энэ нь хөдөлгөөний бэрхшээлтэй бүх хүүхдүүдэд хүртээмжтэй байх уу? Харааны бэрхшээлтэй сурагчид хялбар хөдөлж явж чадаж байна уу?
- Эцэг эхчүүд болон зочдод таатай орчин болж байна уу?
- Барилга болон тоног төхөөрөмжийн ерөнхий нөхцөл байдал ямар байх вэ? Сургууль цэвэрхэн санаа зовох зүйлгүй юу? Засвар шаардлагатай юу?
- Бохирын ус зайлуулах систем нь ямаршуухан юм бэ? Бие засах газрууд нь тусдаа, цэвэрхэн, охид, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын хэрэгцээнд тохирсон хүртээмжтэй байна уу?
- Гар, нүүр угаах болон уух боломжтой цэвэр ус байгаа юу?
- Өрөөнүүдэд хангалттай гэрэл байгаа юу? Сургуулийн эргэн тойронд тэмдэг тэмдэглэгээ байна уу?

Сургууль өөр өөр угсаа гаралтай, ялгаатай давхаргын, хөгжлийн бэрхшээлтэй, хөгжлийн бэрхшээлгүй сурагчдын эерэг дүр төрхийг харуулсан сурталчилгааны самбарыг угтуулан өлгөсөн байж болно. Бодлого нь хүлцэнгүй тэвчээртэй байхыг дэмжсэн, дээрэлхэхийг буруушаасан, хэрвээ нэр хоч өгч дооглох асуудал байгаа бол ХОТСЗ хөтөлбөр хэлэлцүүлэг зохион байгуулж асуудлыг шийдвэрлэх арга замыг олоход нь туслах болно.

Суралцах орчныг бий болгоход туслах

Энэ нь бүх хүүхдүүдийг нөхцөл бололцоогоо дээд зэргээр ашиглахад нь тусалж дэмжиж, таатай боломжуудыг бүрдүүлэх, зохистой бүх ажиллагаануудыг явуулах явдал юм. Энэ бүрэлдэхүүн хэсгийн төгсгөлд дадлагын гарын авлага болон нарийвчилсан гарын авлага, санал болгож байгаа унших сургалтын материалын жагсаалтыг олж үзэж болно.

Сургуулиас эхлэх

Одоогийн нөхцөл байдалд орон нутгийн дунд сургуульд багш нар, сургуулийн ажилчид, эцэг эхчүүд, хамт олны удирдагчид болон сурагчдад зориулсан зохион байгуулалттай ажлуудын талаар авч үзэцгээе. Доорхи асуултуудыг жишээ болгон хэлэлцье. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд рүү чиглэсэн ахлах багш, ангийн багш болон бусад хүүхдүүдийн хандлага ямар байна вэ?
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд сургуульд сурч байна уу?
- Сургуульд сурч байгаа охидуудын эзлэх хувь ямар байна вэ?
- Сургуулиас гарах, давтан суралцах, төгсөлтийн түвшин ямар байна вэ?
- Заах болон суралцах чанар ямар байна вэ?
- Хөгжлийн бэрхшээлтэй ямар нэгэн багш байдаг уу?

Жишээ 28 Монгол

Сүхбаатар аймагт ХОТСЗ хөтөлбөр 2008 оноос хэрэгжиж эхэлсэн билээ. Хөтөлбөрийн хүрээнд сургуулийн багш нарт хамран сургалтаар сургалт семинар зохион байгуулсан бөгөөд үүний үр дүнд ерөнхий боловсролын “Тэмүүлэл” цогцолбор сургуулийн бага сургууль дээр “Хөгжих өргөө” танхим тохижуулж, хичээлээс гадуур чөлөөт цагаараа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд багш нар нэмэлт хичээл заадаг болсон. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хичээлээс хоцруулахгүй сайн талтай ажил болсон.

Чанарт анхаарах

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй тэгш хандаж ажиллах нь хамрах сургалтын зөвхөн нэг хэсэг юм. Анги танхим дотор (сургалтын чанар) юу болж байна вэ гэдэг маш чухал. Заах арга чанаргүй байх нь нийтлэг ажиглагддаг бөгөөд олон тооны хүүхдүүд оролцож эсвэл сурч чадахгүй байж магадгүй. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг суралцахад нь туслах, заах аргыг дээшлүүлэх, түүнчлэн бүх хүүхдүүдэд суралцах орчинг сайжруулахын тулд хамтран ажиллах хэрэгтэй. ХОТСЗ хөтөлбөр багш нарыг бүтээлч болгох, асуудлыг хамтдаа шийдвэрлэх, байгаа нөөц бололцоогоо тохируулан ашиглах, юу болж байгааг судлах, хүүхдүүдийг сонсох болон сурагчдын чадавхийг бий болгохыг хөхүүлэн дэмждэг (24). Бүх сургуулийн хандлага нь нэг хичээлийн багшид анхаарахаас илүү үр бүтээлтэй байх ёстой. Ахлах багшийн дэмжлэг бол шийдвэрлэх ач холбогдолтой.

Багш нарыг сургах ба дэмжих

Багш нар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн талаар хязгаарлагдмал мэдлэгтэй байх

нь олонтаа. Сургуулийн орчинд явагдаж байгаа дадлагажуулах сургалт нь тэднийг бодит нөхцөл байдлаас хол сургалтын төв, коллеж руу явуулахаас илүү багш нарыг дадлагажуулах хамгийн үр дүнтэй арга зам юм. ХОТСЗ хөтөлбөр дараах тохиолдолуудад дадлага, нөөц бололцоогоор хангах, хөгжүүлж чадна.

- Өөр өөр гэмтэл, согогууд ба суралцахад гарах үр дагавар;
- Харилцааны ялгаатай арга зам, утга, хэлбэр;
- Өдөр тутмын амьдралын чадвар, чиг баримжаа ба хөдөлгөөний чадвар;
- Хялбар дөхөмтэй тоног төхөөрөмжүүд, анхан шатны заах арга зүй ба багаж хэрэгсэл;
- Хүүхдүүдийн идэвхитэй оролцоотой хамрах дунд болосвролын хяналт ажиглалт ба үнэлэлт;

Жишээ 29

Жишээн дээр заах

Ел Салвадорт ХОТСЗ хөтөлбөр сургуулиас завсардах, давтан суралцах болон “муу сурдаг” гэж дуудагддаг хүүхдүүдийн асуудлыг нэн тэргүүнд авч үздэг. ХОТСЗ-ынхан ба дунд сургуулийн сайн дурын сурагчидэдгээр хүүхдүүдтэй үдээс хойш ажиллаж эхэлсэн бөгөөд тоглоом тоглож, суралцагч төвтэй арга замыг ашигладаг. Жилийн дараа багш нар эерэг үр дүн гарч байна гэж үнэлцгээсэн ба хамрах ажиллагаа нь заах аргад илүү зохистой гэдэгт үнэмшгээсэн. ХОТСЗ хөтөлбөр багш нарыг дадлагажуулахдаа аяллын хөтөлбөртэй багш нарт төлбөр төлөхийг санал болгож дэмжлэг авдаг болсон. Улс оронд анхны хамрах системтэй сургууль үүсгэн байгуулагдаж Болоовсролын Яамны анхаарлыг татаж, хэвлэл мэдээллээр энэ тухай мэдээлжээ. Яам эцэстээ хамрах сургалтыг дэмжиж дүүрэг даяар байгаа дунд сургуулийн аяллын хөтөлбөртэй гурван багшид цалин олгожээ.

Заах арга болон сургалтын хөтөлбөрийн өөрчлөлтийг дэмжих

ХОТСЗ хөтөлбөр орон нутгийн дунд сургууль, хамт олон, төрийн бус байгууллагуулын хооронд холбоо тогтоож, суралцагч төвтэй заах арга ба уян хатан хичээлийн хөтөлбөрийг зохиоход нь багш нарт дүүргийн боловсролын хэлтэс тусласан. Энэ нь бүх хүүхдүүдэд ашиг тустай юм.

Жишээ 30 Лесото

Номнуудын цаадах хариултыг харах

Лесотод багш нар хамрах сургалтыг сурталчлахыг оролдож тэд нар яг “сургалтын төлөвлөгөөний боолууд” болсон юм шиг санагдаж байсан. Сургалтын төлөвлөгөө нь хатуу хөдлөшгүй, яг сайн хамааралгүй бөгөөд суралцагч төвгүй байсан. Тэд үүнээс хэн ч үр дүнд хүрэхгүй гэдгийг хүлээн зөвшөөрсөн. “Сургалтын хөтөлбөр хэнд зориулагдсан бэ? Бид нар сургалтын төлөвлөгөө гэж нэрлэгдсэн энэ номыгдуусга гэж хүүхдүүддээ зарж, тушааж чадахгүй”. Багшийн ярилцлага (25)

Ихэнхидээ, орон нутгийн дунд сургуулиуд болон ХОТСЗ хөтөлбөрүүд олон оронд төрийн шууд хяналтанд байдаг сургалтын хөтөлбөр, заах аргыг шинэчлэнөөрчлөх эрх чөлөө хязгаарлагдмал байдаг. Гэвч нутгийн түвшинд жижиг, энгийн өөрчлөлтийг хийх боломжтой бөгөөд дүүргийн болон үндэсний хэмжээнд өөрчлөлт хийхийн тулд магадгүй \лоббидвол\ дэмжүүлэхээр нөлөө үзүүлбэл боломжтой юм. Сургалтын хөтөлбөр болон заах арга хэрхэн уян хатан болж болохыг багтаасан жишээнүүдийг харъя:

- Жижиг бүлгүүдэд хүүхдүүд ажиллах
- “Анд найз” системийг эхлэх – хүүхдүүдийг хос болгож нэг нэгэндээ туслах, хосын нэг хүүхэд нь сурахад хэцүү байдаг бол амархан сурдаг хүүхэдтэй хос болгох гэх мэтчилэн
- Багаар заах – чөлөөтэй нэг насанд хүрсэн хүн ангиар явж сурахад хэцүү бэрхшээлтэй байгаа хүүхдүүдэд туслах
- Нутгийн материалуудаар сурахад туслах багаж хэрэгсэл бүтээх, саваанууд, чулуунууд, лонхны таглаа, үр тариа гэх мэтчилэн – энэ сурах бэрхшээлтэй сурагчдад туслана
- Сурагчдын идэвхитэй оролцоог эрж хайх, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, охидууд болон бага оролцдог хүүхдүүд
- Сурагчдын хичээл зүтгэл дээр түшиглэн амжилт гаргах бүрд нь хэдийгээр энэ нь өчүүхэн байсан ч магтах, шагнах
- Гэр бүлүүд, сурагчид болон хамт олны удирдагчдыг сургалтын хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсэгт оруулан судлах болон хэрвээ энэ нь сурагчдын амьдралтай холбоотой болнэмэлт өөрчлөлт хийх ба энэ тэдний бодит амьдралтай уялдаа холбоотой байх
- Дуу, жүжиг, тоглоом болон зургуудыг сургалтыг батжуулахын тулд ашиглах
- Ойлгомжтой хэл яриа хэрэглэх ба төрөлх хэлээ хэрэглэхийг дэмжих
- Багш нарыг зоригжуулах, тэдний царай нь гэрэлтэж байх болон тэд ярьж байхдаа самбартай биш хүүхдүүдтэй харьцах ёстой.

Шалгалт болон үнэлгээ өгөхөд уян хатан байдлыг дэмжих

- Энэ нь хамрах сургалтыг дэмжиж явуулахад хамгийн шүүмжлэлтэй хандах асуудлын нэг юм. Сургуулиуд сурах бэрхшээлтэй хүүхдээс шалгалт авахыг хүсдэггүй байж магадгүй, яагаад гэвэл энэ нь сургуулийн дундаж үзүүлэлтийг бууруулж магадгүй. Шалгалт болон үнэлгээ өгөх систем нь байнга хатуу чанга, ёайн гарахын аргагүй байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд болон сурах бэрхшээлтэй хүүхдүүд шалгалт, үнэлгээ өгөхөд амжилттай өгсөн олон жишээнүүд олон байна. Зарим хандлагууд:
- “сараачсан бичиг” хуурцаг болон бусад дуу бичлэгийн тоног төхөөрөмж ашиглах
- Илүү хугацаа өгөх
- Чадавхид нь үнэлэлт өгөх
- Мэдээлэл, харилцааны технологи ашиглах
- Дохионы хэлний орчуулагч, Брайл эсвэл том үсэг ашиглах

Маш ухаантай ч хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд үнэлэлт, шалгалтаас хасагдах нь олон байдаг. ХОТСЗ хөтөлбөр боловсролын системийн янз бүрийн түвшний багш нар, ажиллагсдад нөлөөлөх хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эрхийг онцгойлон үзэж ялгаварлан гадуурхахгүйгээр оролцуулах өмгөөллийн бүлэг байгуулахад туслаж чадна. Үндсэн зорилго нь шалгалт үнэлгээ өгөх арга замыг

хүртээмжтэй, зохистой, уян хатан болгох юм. Энэ нь , дахиад, бүх хүүхдүүдэд туслах юм.

Дэмжлэг болон хамтын ажиллагааг дэмжих

ХОТСЗ хөтөлбөр үе тэнгийнхэний хамтын ажиллагаа болон хамрах сургалтыг хэрэгжүүлж эсвэл хөгжүүлж байгаа багш нар, сургуулийн холбоосыг дэмжиж лавшруулж байдаг. Бусад санал болгож байгаа үйл ажиллагаанууд:

- Хамрах дунд боловсролыг хөнгөвчлөх, уян хатан сургалтын хөтөлбөр, заах арга ба сургалтын тусламж үзүүлэх тэтгэвэрт гарсан багш эсвэл төрөл садан гэх мэт сайн дурынханыг ажилд авахыг дэмжих
- Ахлах багш нар эсвэл багш нарын холбоонууд хамрах сургалтыг дэмжих, туршлагаасаа хуваалцахыг дэмжих
- Үе тэнгийнхэнийг сургалтын хөтөлбөрөөс илүү үйл ажиллагаанууд болон клубээр хангах хөгжлийн бэрхшээлийн талаарх ухамсрыг нь дээшлүүлэх,, хөгжүүлэх үйл ажиллагаа, дэмжлэгийг лавшруулах
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагаас үлгэр дуурайл болохоор хүн ирж сургуулийн хүүхдүүдтэй ажиллах

Байгаа нөөц бололцоог ашиглах, дэмжлэгийг хөгжүүлэх

Үүнд 1) орон нутгийн нөөц бололцоог ашиглан бүх хүүхдүүдийн сурах үр бүтээлтэй орчныг бий болгох 2) зарим хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг сурах, оролцоог хангахад хэрэгтэй мэргэжилтнүүдийн нөөцийг баталгаажуулах зэрэг орно.

Орон нутгийн нөөц бололцоо болон дэмжлэгийг авах

- Хүүхдүүд, багш нар, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, гэр бүлүүд, хамт олны гишүүдийн мэдлэг, ур чадвар, туршлагыг ашиглах, олж авах
- Дээр өгүүлсэнчлэн гарын доорх материалаар сургалтын хэрэгсэл хийх, заах арга зүйн тусламж үзүүлэхийг дэмжих
- Аяллын хөтөлбөртэй багш нар, тэтгэвэрт гарсан багш гэх мэтийн сайн дурынхан эсвэл ХОТСЗ хөтөлбөрөөс эсвэл боловсролын яамнаас санхүүждэг багш нарт ажил олгох: тэд нар багаар ажиллахыг дэмждэг, заах аргын чанарыг сайжруулдаг гэх мэт тодорхой хүчин зүйлүүд дээр голлон анхаардаг, хамт олон гэр бүл, сургуулийн хоорондын холбоог дэмжихэд голлох хэрэгцээт үүрэг гүйцэтгэх ба хөгжлийн бэрхшээлтэй нэг хүүхдийг биш бүх хүүхдийг сургахад тусладаг.
- Орон нутгийн жүжигчид, хөгжимчид болон үлгэр түүх ярьдаг хүмүүсийг хамруулах нь сургуулийн орчныг хүүхдүүдэд илүү сонирхолтой амьд болгодгийг зөвлөмөөр байна.

Мэргэжилтний нөөц, дэмжлэг

ХОТСЗ хөтөлбөр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд нь мэргэжлийн нөөц бололцоонууд болон дэмжлэгийг хэрэгцээтэй үед нь авхуулах хэрэгтэй. Магадгүй зарим хүүхдүүдэд доорхи зүйлс нь хэрэгтэй байж болно:

- Суудлыг тохируулах нь хэрэглэхэд хялбар байрлалтай болж хичээлийн үйл ажиллагааг тогтвортой явуулахад нь туслана
- Томруулсан үсэгнүүд, томруулдаг шил, уян хатан



суудлын тохиргоо болон сайн гэрэлтүүлэг нь хэрвээ тэд харааны согогтой бол хэрэгтэй.

- Харилцааны тусламж, зурагнууд, самбар, тэмдэглэгээнүүд гэх мэт
- Хөдөлгөөнтэй тоног төхөөрөмж, тэргэнцэр, чиг, цагаан саваа гэх мэт
- Эмчилгээ, бариа засал, үг ярианы засал гэх мэт
- ХОТСЗ хөтөлбөр дараах зүйлсээр тусалж чадна:
- Нөөцийг байршуулах – энэ нь орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллага, тусгай сургуулийн ажиллагсад, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй хамтран ажилласанаар амархан мэдэж авч болох зүйлс
- Гэр сургуулийн хооронд холбоо тогтоож туслах төхөөрөмж ашиглан хүүхдүүдийг дэмжих болон тэдний төхөөрөмж нь сайн засварлагдсан, шинэчлэгдсэн, хэрэглэхэд тохиромжтой эсэхийг мэдэж байх
- Гэр, сургууль ба хамт олны хэрэглэж байгаа харилцааны арга зам нь нэг хэвийн байх ёстой. Хэрвээ дохионы хэл ба Брайл хэрэглэж байгаа бол эцэг эхчүүд, ах дүү нар, сургуулийн бусад хүүхдүүд, багш нар болон хөршүүд нь үндсэн дохио зангаа болон үндсэн Брайл хэрэглэж сурах гэх мэт
- Үе тэнгийнхэний бүлгийн бүрдэл хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд ур чадвараа хуваалцахыг дэмжих, сонсголын бэрхшээлтэй хүүхэд өөр сонсголын бэрхшээлтэй хүүхэд болон том хүнтэй уулзаж дохионы хэлнийхээ ур чадварыг хөгжүүлэх гэх мэт

Жижиг нэгжүүдийг хамгийн сайнаар хэрэглэж буйг дэмжих нь

Жижиг нэгжүүд (мөн нөөц өрөө ч гэж нэрлэдэг) нь ихэнхидээ дунд сургуулийн зонхилох хэсэг болох өрөөнүүд байдаг ба зорилготойгоор байгуулагдсан эсвэл хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг дэмжихээр хуваарилагдсан байдаг. Харамсалтай нь, тэр нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг эсвэл сурах бэрхшээлтэй хүүхдийг зонхилох анги танхимаас байнга тусгаарладаг.

Жижиг нэгжүүд нь зөв замаар хэрэглэвэл үнэтэй нөөц бололцоо юм. Тэдгээр нь хүүхдэд анхаарсан заах материал болон тоног төхөөрөмжийг байлгаж, дэмжлэг хэрэгтэй байгаа жижиг бүлэг болон хувь хүнд түр зуурын дэмжлэг өгөх, сургалтын хөтөлбөрийг яаж дөхөмтэй болгох талаар сургаж, эцэг эхчүүдийн дэмжлэгт болон хамрах сургалтыг дэмжих өөр бусад үйл ажиллагаанд хэрэглэгддэг. Гэвч тэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд болон сурах бэрхшээлтэй хүүхдүүдэд байнгын болон тусгаарласан анги танхим болон хэрэглэгдэх ёсгүй. Ялгаварлахын өөр нэгэн хэлбэр юм.

Жишээ 31 Замбиа

Бүх хүүхдүүдэд болон багш нарт зориулсан нөөц бололцоо

Замбиагийн жижиг хэсгүүд энэ хэсэгт ажилладаг багш нарыг “тэнэгүүдийн багш нар” гэж нэрлэдэг тусгаарласан орчинг бий болгосон. Сургууль бодитойгоор эхлэх үед сургуулиас гарсан, давтан түвшиний, хүүхдийн эрх, хамрах сургалт ба анги доторхи ардчилал рүү чиглэгдэж жижиг хэсэг нь бүх хүүхдүүд болон багш нарт нөөц бололцоо олгох өрөө болон хувирсан байна (26).

Тэгш хамруулах замаар тусгай сургуулиудад туслах

ХОТСЗ хөтөлбөр одоо байгаа тусгай сургуулиудыг тэгш хамрах сургалтын нөөц болгон ашиглахыг дэмжиж байна. Жишээлбэл: тусгай сургуулийн ажилтнууд жирийн сургуульд сургалтын хөтөлбөрөө илүү уян хатан болгож хийхэд нь тусалж болно. Тусгай сургуулиуд магадгүй хүүхдүүдийн өргөн цар хүрээтэй бүлэгт үр ашигтай мэдлэг, ур чадвар, тусламж, тоног төхөөрөмжтэй байж болно. Хэрвээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд тусгай сургуульд элссэн бол ХОТСЗ хөтөлбөрийн үүрэг нь гэр бүл болон хамт олонтой холбоос нь тогтвортой эсэхийг мэдэх, хүүхдийн эрхийг хүндэтгэж байгаа эсэх, орон нутгийн сургуулийг хамрах сургалттай болгохоо үргэлжлүүлэн хийхэд туслана. Аяллын хөтөлбөртэй багш нар болон хамт олны сайн дурынхан ердийн болон тусгай сургууль, гэр бүл болон хамт олны хоорондын зайлшгүй холбоосыг хангаж байх болно. Хөгжлийн бэрхшээлгүй хүүхдүүд ч гэсэн тусгай сургуульд хамрагдаж болно.

Ядууралд хандаж хэлэх үг

Нэн ядуу гэр бүлээс гаралтай хүүхдүүд голчлон бага боловсролын гадна үлддэг ба хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд ихэнхдээ ийм гэр бүлийн хүүхдүүд байдаг. Хэдийгээр, ядуурал нь бага боловсрол эзэмшихэд нилээд том саад боловч сөрөг хандлага нь ядуурлаас ч илүү саад болдгийг туршлага харуулж байна. Заримдаа хамрах сургалт нь ядуу хамт олонд амжилттай явагддаг, яагаад гэвэл ийм хүмүүс хамтран ажиллаж нэг нэгийгээ харж хандаж хүнд хэцүүг ялж сурсан байдаг.

ХОТСЗ хөтөлбөр ядуурлын асуудлуудад дараах замаар тусалж чадна.

- Гэр бүлүүд хүүхдүүдээ тэжээж чадаж байна уу эсвэл сургууль эсвэл хамт олон сургуулийн хүүхдүүдийг өдрийн хоолоор хангаж чадаж байна уу
- Орон нутгийн төр захиргааны байгууллагууд, буяны байгууллагууд, бизнесийн болон төрийн бус байгууллагуудтай холбоо тогтоож сургалтын материал, дүрэмт хувцас хоолны өглөг хандивыг нэмэгдүүлэх
- Гэр бүлүүдтэй ойрхон ажиллаж тэдний сэтгэл зовж байгаа зүйл нь юу болохыг мэдэж хамт олныг дэмжлэг, хандив өгөхийг уриалах
- Гэр бүлийн орлогоолох үйл ажиллагааны оролцоог дэмжих, тэгвэл хүүхдүүд гэр бүлийн амьдралын хэрэгцээнд туслахын оронд сурах боломж нь чөлөөтэй болно (Амьжиргаа бүрэлдэхүүн хэсэг)
- Хэдий нөөц бололцоо нь хязгаарлагдмал байсан ч хамрах сургалт чухал гэдгийг онцгойлж үзэх – хэдийгээр сургуулийн барилга байхгүй байсан ч сурагчид нэг зорилготой байж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд ч үүнд нэгдэж болно.
- Эцэг эхчүүд нь хамт явах завгүй, өөрсдөө сургууль руугаа ганцаараа явах боломжгүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн тээврийн асуудлыг шийдвэрлэх – бусад сурагчид (үе тэнгийнхэний дэмжлэг), өвөө, эмээ нь, хөршүүд нь эсвэл хамт олны гишүүд гэр сургууль рүү нь явуулж өгч туслах, орон нутгийн бизнесийн болон төрийн бус байгууллагуудыг боломжтой бол тээврийн хэрэгслээр хангаж өгөхийг санал болгох



Жишээ 32 ЭНЭТХЭГ

Нийгмийн асуудлуудыг ойлгох нь

Энэтхэгийн ХОТСЗ-ын ажилтан сонголын согогтой найман настай хүүхдийн ээжээс “ та яагаад хүүхдээ дунд сургуулийн өөртөө туслах төв рүү явуулаагүй юм бэ? Энэ нь танай гэртэй ойролцоо байдаг ” гэж асуужээ. Ээж хариуд нь “ Миний хүүд хийх юм их байгаа. Тэр надад ямаануудыг бэлчээхэд хэрэгтэй. Түүнийг гэрт хийх ажилгүй болсон хойно л би түүнийг сургуульд явуулж болох юм ” гэжээ. (27)

Сүлжээ, өмгөөлөл ба мэдээллээ хуваалцах

Хамрах сургалтыг сурталчлахдаа, боловсролын салбар хамт олон, муж, үндэсний хэмжээний болон хувирах хэрэгтэй. Татан оролцуулах нь дэмжих бодлого, төсөв, бүтэц, менежергүйгээр тогтвортой оршиж чадахгүй. ХОТСЗ хөтөлбөр эвсэл холбоо байгуулах, ахлах багш гарын холбоотой түншлэх, нөлөөлөх бүлгийгбий болгох, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллага болон эцэг эхчүүдийн байгууллага, бусад орхигдсон бүлэглэлүүдийг төлөөлөх бүлэг (эмэгтэйчүүдийн бүлэг, цөөнх угсаатны бүлэг), тусгай боловсролын ажиллагсад, шашны бүлгүүд, орон нутгийн бизнес эрхлэгчид, хэвлэл, эрүүл мэндийн ажилтнууд, эмч нар, орон нутгийн болон олон улсын төрийн бус байгууллагуудтай сүлжээгээр дамжуулан туслаж чадна.

Боловсрол нь хандивлагчид, төрийн байгууллагууд болон хөгжлийн агентлагийн гол сэдэв учраас янз бүрийн зорилготой нөлөөлөх бүлгүүд олон байдаг. Хамгааллын зорилго тавигчдад Дэлхийн Банк, Европын Холбоо гэх мэт хандивлагч агентлагийн үндэсний албан газар, Боловсролтой хамааралтай олон улсын төрийн бус байгууллагууд, муж болон үндэсний төрийн байгууллагууд, боловсролын яам зэрэг багтдаг.

Мэдээллийн ач холбогдлыг хэтэрхий онцгойлон авч үзэх хэрэггүй. ХОТСЗ хөтөлбөр хамрах сургалтын нөөц бололцоо болон мэдээллийг түгээх гол үүргийг гүйцэтгэнэ.

Жишээ 33 Замбиа

Жирийн ангид сайн

Замбиад нэг багш EENET сонин уншаад тусгай ангид хүүхдүүдийг байлгах нь буруу гэдгийг ойлгожээ. “Би тэднийг энгийн ангид оруулсан ба тэд маш сайн байсан. . . сонин миний оюун ухааныг нээж өгсөн. Бид эдгээр сурагчдыг юу ч хийж чадахгүй хүүхдүүд шиг л үнэлсэн байсан”. Тэр багш хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд сурч чадахгүй гэж хэлдэг бусад багш нарыг ятгахдаа сонин сэтгүүлийг ашиглажээ. (28)

Дунд болон дээд боловсрол

Танилцуулга

Ихэнх ядуу оронд зөвхөн цөөхөн тооны хүүхдүүд л дунд болон дээд боловсрол эзэмших боломжтой, боловсрол нь заавал хүрэх түвшний цаана байдаг ба хөгжлийн бэрхшээлтэй оюутнууд тэдний чадварыг сорьсон тэмцэлд бүхэлдээ гадуурхагддаг

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцид (A24, р 2а,2б ба 5) хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудад дунд болон түүнээс дээш боловсрол олох эрх нь нээлттэй гэж заасан.

Дунд болон дээд боловсрол нь онолын хөтөлбөр болон техникийн /мэргэжлийн/ боловсролыг багтаадаг. Хүнд байдал болон мухар сүсэгийг үл харгалзан хөгжлийн бэрхшээлтэй оюутнууд жишээ нь оюун ухааны бэрхшээлтэй хүмүүс өөрсдийн сонирхол болон чадлынхаа хирээр өндөр боловсролтой байдаг.

Бэрхшээлтэй хүмүүс нь нийгэмд бүрэн хамрагдах, ажил хөдөлмөр эрхлэхэд суурь түвшнээс цааших боловсрол эзэмшсэн байх хэрэгтэй. Учир нь ихэнх нь нийгмээс тусгаарлагдаж анхаарлаас гадуур үлддэг ч хамрагдалт хөдөлмөр эрхлэлт, амьдралын ижил түвшний нийгмийн давхаргад хүрэхэд бусдаас илүү мэдлэг чадвар, мэргэшилтэйгээ нотлох хэрэгтэй болдог. Хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудад дунд болон дээд боловсрол нь хангалттай бүтээлч амьдралд хүрэх хамгийн чухал гарц болж ч болно.

Зарим оронд энэ нь хууль ёсны шаардлага бөгөөд байгууллагуудад хүртээмж бий болгох, “боломжит хэрэглэгдэхүүн” хийх, суралцахад нь дэмжлэг үзүүлэх, хөтөлбөртөө дасан зохицох нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс дунд болон ба боловсрол эзэмшихийг баталгаажуулна.



Жишээ 34 Рванда

Дээд боловсролтой болох эрхийн талаар сурталчлах

1990 онд Rwanda-д сая гаруй хүнийг хоiorголон устгасан. Энэ нь олон хүнийг өнчрүүлж, нийгэм, эдийн засгийн томоохон асуудал үүсгэсэн. 1997 онд Рвандагийн Хараагүйчүүдийн холбоо, Эварист Карангва (Гахинигийн дунд сургуулийн захирал)-ийн хооронд эрчимтэй хэлэлцээр болж, эхлээд харааны бэрхшээлтэй оюутнуудыг Рвандагийн дунд сургуульд элсэн оруулснаар Боловсролын Яам үр дүнд хүрсэн. Дараагийн 5 жилийн дотор нийтдээ 33 хараагүй оюутнуудыг шинээр элсүүлсэн. Эдгээр сурагчдын боловсролд дэмжлэг үзүүлэхээр тэтгэмж цуглуулагч эцэг эхчүүдийн хороог байгуулсан аж. Энэ хороо нь парламентын гишүүд, шашны тэргүүн, орон нутгийн удирдагчид, эцэг эхчүүд, багш оюутнуудыг удирдан чиглүүлж өглөг өгүүлэх, тоглолт хийх, бүжиглэх, аж ахуй эрхлэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх зэргээр орлого олж эхэлсэн. Эцсийн дүнд нөөцийн өрөөтэй, сайн дурын ажилчдын байртай, амрах өрөөтэй болох боломжтой болсон.

Хэдэн жилийн дараа оюутнууд их сургуульд орцгоож эхэлсэн. Эварист Карангва сургуулийн захирлаас эдгээр оюутнуудыг тэгш хамруулан сургахыг дэмжихээр 12 мэргэжилтнээс бүрдсэн багийг удирдахыг хүсэж, тэрээр Боловсролын хүрээлэнд ажиллаж байсан. Орон нутгийн сонингууд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг их, дээд сургуульд суралцах эрхтэй талаар бичигцгээж байлаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүсүүгийн Үндэсний Холбоо нь их, дээд сургуульд орж чадаагүй, суралцах чадвартай 250 гаруй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн жагсаалтыг гаргасан байна.

Төлөвлөгөө боловсруулж, дараах жилүүдэд нь харааны, сонсголын, хөдөлгөөний бэрхшээлтэй хүмүүс их, дээд сургуульд хууль, эрх зүй, сэтгээул зүй, боловсрол, анагаахын чиглэлээр орсон байна. Үнэ төлбөргүй мэдээлэл, мэдлэг ойлголт өгөх ажлудыг төлөвлөн явуулжээ. Семинарыг брайль үсгээр явуулжээ. Хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудын холбоо “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боловсрол эзэмших эрхийг няцааж байгаа байдал, нийгэмд үзүүлэх нөлөө” жүжгийг тавьжээ. Тэгш хамран сургах талаар ярьдаг байсан Боловсролын урьдын сайд нь оролцсон байна. Хуульч, нарийн бичиг, компьютерийн операторууд болон бусад янз бүрийн мэргэжлээр ажиллаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эсэргүүцэл нийт үзэгчдийг мэл гайхашруулжээ. Рвандагийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс дээд боловсрол эзэмших эрхтэйгээ баталсаар байна.



Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй оюутнууд нь бусадтай адил суралцах бололцоотой бөгөөд, амьжиргаа, чадавхжуулалт, тэгш хамрагдахад дэмжлэг авч туршлага, мэргэжил, ур чадвар эзэмшинэ.

ХОТСЗ-ын үүрэг

Дунд болон дээд боловсролд ХОТСЗ хөтөлбөрийн үүрэг нь хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудын ололт амжилт, оролцоо, үр дүн, боломжийг нэмэгдүүлснээр тэдний ороцлоог хялбарчлах ба эрх бүхий сургуулийн орчныг хүртээмжтэй, сургалтын хөтөлбөрийг уян хатан байлгахар ажиллана.

Хүсч буй үр дүн

- Хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудын дунд болон дээд боловсрол дүүргэсэн, элссэн хэмжээ өссөн байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй оюутнууд засгийн газрын тэтгэлэг, тэтгэмж болон санхүүгийн бусад эх үүсвэрээс хүртэх, эцэг эх, хамт олон нь энэ дэмжлэгийг хэрхэн хүртэх талаар мэдлэг, чадвартай байх
- Боловсрол тэгш хүртэхэд хамт олон лобби бүлэг, компанит ажлыг дэмжих
- Дунд болон дээд боловсрол эзэмших явдалд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хамруулахыг эцэг эх, хамт олон нь дэмждэг болно.
- Дунд болон дээд боловсролын хөтөлбөр нь хүртээмжтэй, сургалтын орчин, заах арга, сургалтын хөтөлбөр, сургалтын нэмэлт хөтөлбөрийн үйл ажиллагаа (спорт, амралт, чөлөөт цаг, хөгжим зэрэг) үнэлгээ болон шалгалтанд хамруулна.
- Дунд сургуулиуд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тэгш хамруулах, тэдний олон талт байдлаас суралцаж, нийгэмд тэгш хамруулахад шаардагдах ур чадварыг хөгжүүлнэ.
- Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг тэгш хамруулах явдлыг нэмэгдүүлэхэд мэргэжилтний нөөц, дэмжлэгийг зүй зохистой ашиглана.
- Дунд/дээд боловсролын хөтөлбөр, насанд хүрэгчдийн амьдарлд шилжих шилжилтийг сайтар дэмжиж, мэргэжил сонгох зааварчилгаа нь хүртээмжтэй, тэгш хамруулсан байна.

Гол ойлголтууд

Системийг өөрчлөх

Боловсролын бусад элементүүдийн адилаар системийг суралцагчдад тохируулан өөрчлөх нь маш чухал. Хэдийгээр, дунд болон дээд боловсролын систем нь үндэсний, төрийн түвшинд маш хатуу хяналттай байж болох ч хамт олон ба ХОТСЗ-н уриалга, нөлөөг тусгах хэрэгтэй. Удаан хугацааны том өөрчлөлтөнд ХОТСЗ-ынхан дангаараа хүрэхгүй бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй

хүүхэд нэг бүрд үр ашигтай сүлжээ болон нөлөөлөх үйл ажиллагаанд оролцох, эвсэн нэгдэж бүтээн байгуулах хэрэгтэй. Дунд болон дээд боловсрол нь хувьчлагдаж, ингэснээр ХОТСЗ хөтөлбөр, тэр боловсролыг хөгжлийн бэрхшээлтэй ядуу хүүхдүүдэд хүрч чадаж байгаа эсэхэд анхаарах зэрэг нэмэгдэл хүч шаардсан ажлыг бий болгож байна.

Учрах саад бэрхшээл

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн цаашдын боловсролд нь саад тотгор тавих нь тэдний хүсэл сонирхол, ур чадвар болон зорилгод нь хамааралтай бусад хүмүүсийн итгэл, найдварыг нь хязгаарлаж бууруулах явдал юм. Жишээлбэл, ХОТСЗ-ийн байгууллагын үйл ажиллагаа нь ихэнхдээ хамт олны ур чадвартай эсвэл хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст чиглэгдсэн ажилчдын үйл ажиллагаа байдаг. Энэ нь ямар нэгэн зүйлээр ХОТСЗ-ийн 3 “Б” салбар буюу-самнууд, шүүрнүүд, сагснууд –хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь зөвхөн эдгээрийг хийх чадвартай байдаг гэсэн ойлголттой холбогдсоор ирсэн юм. Тиймээс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаархи ойлголтууд бодлуудыг өөрчлөх шаардлагатай. Өнөөдөр дэлхийн эргэн тойронд байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэд маш өргөн хүрээний мэргэжилийн түвшинд хүрч хамгийн өндөр шалгууруудыг улам ихэсгэсээр байна.

Жишээ 35 Монгол

Билэгсайханы амьдрал

Билэгсайхан ээж, аав, эгч, ах, дүүгийн хамт Улаанбаатар хотод амьдардаг. Одоо тэрээр 18 настай. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцаж байна. Тэрээр ихрийн өрөөсөн ба төрөх үеийн тархины гэмтэлтэй буюу тархины саатай төржээ. 1999 онд АИФО байгууллагын шугамаар Мобилити Индиа ТББ-аас мэргэжилтэн ирж, хүүхдийг бие даахад чухал туслах хэрэгслүүдийг зааж өгснөөр Билэгсайхан анхныхаа туслах хэрэгслүүдийг авсан билээ. Билэгсайхан 8 настайдаа ерөнхий боловсролын 16-р сургуульд элсэн орж, бүрэн бус боловсрол эзэмшсэн. Хэдийгээр Билэгсайхан гараараа бичиж чадахгүй ч түүнд сайн аав, ээж, багш, найд нөхөд нь тусалсан. Даалгавараа компьютерийн програм ашиглаж хийдэг. Тэрээр өөрийгөө хэзээ ч хөгжлийн бэрхшээлтэй гэж бодож, айж ичиж байгаагүй.

Ололт амжилт ба үнэлгээ

Сурагч бүрд олох амжилт гэдэг нь тэдний боломж болон чадавхиас хамааран өөр өөр утгатай байдаг. Жишээлбэл, оюун ухааны хомсдолтой сурагчдын хувьд амжилт гэдэг бол бие даан амьдрах, хүмүүстэй харьцах, дөрвөн аргын тоо бодож сурах, бичиг үсэг тайлагдах зэрэг ур чадваруудаг амжилттай хөгжүүлэх гэсэн утгатай бол бусад сурагчдын хувьд хичээл сургуультай холбоотой гаргасан амжилт байж болох юм. Техникийн, техник мэргэжлийн, урлагийн болон зохион бүтээх ур чадвар зэрэг нь сонгодог аргын чадвартай адил үнэ цэнэтэй юм. Шалгалтыг хатуу хөшүүн болон нарийн явуулах болон үнэлгээий систем нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дунд болон дээд боловсролд

хамрагдахад нь нилээд саад тотгор болдог. Үнэлгээний жинхэнэ үнэ цэнэ гэдэг бол оюутнуудыг тэдний өөрсдийн чадавхийг өөрсдийнхөө дэвшилтээр хэмжиж мэдэж авахад нь тус болдог байх явдал юм. Бүтээлч болон уян хатан хандлага нь тэднийг өдөөж өгдөг бөгөөд нөөц чадамжаа хамгийн дээд зэрэгт хүргэх авьяас болон ур чадвараа хөгжүүлэхэд нь туслана. ХОТСЗ-н ажилтнууд хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудын сонирхолболон жинхэнэ чадавхид анхаарал хандуулж туслаж чадна.

Янз бүрийн насанд суралцах

Дунд боловсрол нь өсвөр насны хүүхдүүдийн биеийн болон сэтгэл хөдлөлийн ихээхэн онцлог шинжтэй үе шаттай тохирсон байх шаардлагатай. Өсвөр насныхны туршлагаас харахад соёл болон хам хүрээний хооронд янз бүрийн ялгаатай байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын хувьд шилжилтийн насанд нь сургалтанд нь том нөлөө үзүүлэх нэмэлт болон янз бүрийн чадал сорьсон ажлууд байж болно. ХОТСЗ ажилтнууд эдгээр чадал сорьсон ажлуудад мэдрэмжтэй хандаж, мэдэж байх хэрэгтэй бөгөөд сурагчдыг үлгэр дуурайл болсон хүмүүс, үе тэнгийнхэн мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй холбоо тогтоолгож байх хэрэгтэй. Дээд боловсрол бол нас биед хүрэх үе шат руу шилжихтэй адил төстэй. Хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудад энэ үе шатанд дэмжлэг хэрэгтэй байж магадгүй ч гэсэн тэднийг залуухан насанд хүрэгчид гэж хүлээн зөвшөөрөх нь чухал бөгөөд тэдний өөрсдийнх нь сургалтын талаар шийдвэр гаргахад нь зохиржуулж өгөх хэрэгтэй.

Санал болгож буй үйл ажиллагаанууд

Олон нийтийг оролцуулах

Энэ нь том сорил байж магадгүй, яагаад гэвэл дунд болон дээд боловсролын явц нь олон нийтээс хол зайтай байдаг. ХОТСЗ хөтөлбөр дараах зүйлээдээр гар бие оролцож чадна:

- Хамт олны болон сургуулийн захиргаанд тээврийн хэрэгслэлийн асуудлыг зохион байгуулахад нь дэмжлэг үзүүлэх – энэ нь зээлийн бүлгүүдээс эдийн засгийн тусламж хүсэх (Амьжиргааны бүрэлдэхүүн хэсгийг үз) ба өөртөө туслах/ өөрсдийгөө өмгөөлөх бүлгүүдээс бодит дэмжлэг шаардлагатай байж магадгүй.
- Хамт олныг төлбөр, дүрэмт хувцас, туслах тоног төхөөрөмж ба нэмэлт дэмжлэг зэрэгт санхүүгээ нэмэгдүүлэхэд нь дайчлах, тэднийг хамт олны нөөц бололцоотой адил хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудыг танин олохыг дэмжих
- Төрөөс тэтгэлэг, зээл тусламж авах, хандивлагч агентлагуудаас хөрөнгө мөнгө авахыг нэмэгдүүлэх – ухамсрын дутагдлаас болоод төрийн нөөц бололцоо ашиглагдахгүй үлдэх нь олонтаа бөгөөд түүнийг ашиглах боломжийг нэмэгдүүлэх
- Дэм болохоор нөлөөлөх болон өмгөөлөх бүлгүүдийн хэлбэр нь орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоотой хамтдаа дунд болон дээд боловсролын хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудын эрхийг сурталчлах



Жишээ 36 Непал

Тэгш хамрах боловсролыг санхүүжүүлэх

Непалд хамрах сургалтыг үүсгэн байгуулахад санхүү нь анги, нөөц материал худалдаж авах, тавилга болон байр хөлслөх, хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудын хоол хүнсийг хангах, тусгай сургалтанд дадлагажсан нэг багшаар хангах, өөр хочр багшийг туслахаар авах зэрэгт зарцуулагддаг. Тусгай Боловсролын Төлөөгчийн Газар нэг салбарт таван ажилтныг санхүүжүүлдэг. Хувийн санхүүгийн бүлгүүд болон төрийн бус байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудыг санхүүжүүлдэг.

Гэр бүлүүдийг дэмжих

Зарим гэр бүлүүд дунд болон дээд боловсрол эзэмших гэж байгаа хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудыг хэт хамгаалах ёстой гэж үздэг эсвэл тэдний боломж чадварт итгэдэггүй, эгдүүцсэн ах дүү байх, эмэгтэйчүүдийн хувьд тэдний боловсролыг үнэлэхгүй байх зэрэг бага зэрэг эсэргүүцсэн бодолтой байдаг. Тэдгээр бүлүүдийн олон эргэлзээ, хүндрэлүүд болон дасан зохицох зэргийг шийдвэрлэх хэрэгтэй. ХОТСЗ ажилтнууд гэр бүлүүдийг сургаж, дэмжиснээр тэд хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудыг тэдний сургалтын болон шилжилтийн үеийн туршид дэмжиж байх болно.



Жишээ 37 Украин

Эцэг эхчүүдийг оролцуулах

Украинд эцэг эхчүүд хамрах дунд сургуулийн 1000 сурагчидтай нягт холбоотой байдаг. Тэдний үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын эцэг эхчүүдийг багтаасан үе тэнгийнхний дэмжлэгийг эцэг эхчүүдэд өгөх ба боловсролын ашиг тус болон хэрэгцээний тухай товхимлоор хангадаг клуб, сар бүр жүжгийн хөтөлбөртэй эцэг эхчүүдийн өдрийг тэмдэглэх, хамрах сургалтын танхимд эцэг эхчүүдийн уулзалт хийх, сэргээн засах мэргэжилтнүүдтэй эцэг эхчүүд уулзах багийн уулзалт, оюутнуудын хөгжил дэвшлийн талаар багш нар болон сургуулийн удирдлагууд хэлэлцэх зэрэг багтдаг.

Тэгш хамрах сургалтын орчныг бий болгоход туслах

Бага боловсролын элементэд жагсаагдсан ихэнх үйл ажиллагаанууд дунд болон дээд боловсролд мөн адил нийтлэг байдаг. Дунд болон дээд боловсролд мөн харгалзаж үзэх зарим нарийн ширийн зүйлүүд байдаг.

Орчин болон байршил

Дунд болон дээд боловсролын байгууллагыг байгуулах нь бага боловсролын байгууллагыг байгуулахаас ихэнхдээ том бөгөөд их талбайг эзэлсэн байдаг. Анги танхимуудын хооронд явах, лаборатори эсвэл компьютерийн өрөө зэрэг анги дотуур явахад амар байх зэрэг нь асуудал болж болно. Тиймээс доор зарим нэг үйл ажиллагааг санал болгоё:

- Сургуулийн захиргаатай анги танхимуудын байршлыг өөрчлөхөөр доод давхар руу шилжүүлэх гэх мэтээр тохиролцох
- Хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудад хялбар дөхөм байх асуудлыг шийдвэрлэх санхүүг бий болгохыг дэмжих
- Охидууд болон залуу эмэгтэйчүүдэд зориулсан тусдаа, эрүүл ахуйн ус ариутгалын тоног төхөөрөмжтэй байх

Сургалтын хөтөлбөр ба заах арга зүй

Багш нарт тэдний амжилт болон хөглийн бэрхшээлтэй оюутнуудыг сургах талаар хэлэлцэх орчин, дадлага, дэмжлэг хэрэгтэй. ХОТСЗ хөтөлбөр багш нар болон боловсролын салбарт ажилладаг бусад хүмүүстэй зөвлөгөө болон боломжтой нөөц бололцооны материалаар хангахад хамт ажиллах хэрэгтэй. Доор зарим санал болгож байгаа үйл ажиллагаануудыг авч үзье:

- Тэдэнд тохируулан хялбар дөхөм, хамааралтай сургалтын хөтөлбөрийг шинэчлэн хийх
- Суудал, гэрэлтүүлэг, оюутны байрлал зэргийг багтаасан анги танхимын зохион байгуулалт дээр зөвлөгөө өгөх ба бүлгийн ажил болон багаар заахыг дэмжих
- Харилцааны систем ба хялбар дөхөм байдлыг бий болгох, томоор бичих, Брайлл, тэмдэглэгээтэй самбар, дохионы орчуулга, хуурцагууд, аудио тоног төхөөрөмжүүд, гар бичмэл болон орчуулга зэргийг боломжтой болгоход туслах(Эрүүл мэндийн бүрэлдэхүүн хэсэг: Туслах тоног төхөөрөмж)
- Үйл ажиллагаагаа бүрэн гүйцэтгэхэд илүү цаг өгөх зэргээр уян хатан цагийн хуваарийг дэмжих, янз бүрийн цагт сурах боломжоор хангах, модуль дээр суралцах, ингэснээр сургалтын хөтөлбөр илүү урт хугацаанд төгс төгөлдөр болно.
- Хөгжлийн бэрхшээлтэй оюутнууд тэдний сургалтын талаарх хэлэлцүүлэгт оролцох, тэд хэрхэн суралцаж байгаа, юу сурч байгаа талаар өөрсдийн санал бодлоо хэлэх, оюутан тус бүрийн хамгийн дээд боломж, чадамжийг багтаасан сэтгэл зүйн болон сургуулийн чиг баримжааны заалтын дагуу зөвлөгөө өгөх

Шалгалт ба үнэлгээ

Шалгалт ба үнэлгээ өгөх тогтолцоо нь бүх оюутнуудын хэрэгцээнд тохирсон уян хатан хийгдэх ёстой.

Жишээ 38 Непал

Шалгалтын уян хатан системийг хангах

Харааны бэрхшээлтэй сурагчдыг багтаасан дунд сургууль Непалд байдаг. Эдгээр сурагчид шалгалтаа бусад сурагчидтай хамт өгдөг. Шалгалтын хуудсууд нь Брайль, гар бичмэл өгөгдсөн, тэднийг шалгалтаа бүрэн хийж гүйцэтгэхэд хагас цаг илүү хугацаа өгдөг.

Мэдээлэл, харилцааны технологи

Дээд боловсролын түвшинд ялангуяа компьютер технологи хичээлийн хөтөлбөрийг ашиглах, сурахад үр дүнтэй, бүтээлч болгодог. ХОТСЗ хөтөлбөр тэтгэлэгийн боломжуудыг судлаж үзэх эсвэл орон нутгийн нийгэмлэгүүд, бизнес, засгийн газрын болон олон улсын агентлагуудаас санхүүжиж хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудыг интернет холболттой компьютераар хангаж чадна.



Үе тэнгийнхэний дэмжлэг болон үлгэр дуурайл болсон хүн

Олон оюутнууд хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудтай хамт өмнө нь сурч үзээгүй байх. Хандлага болон хариу үйлдэл олон янзын үр дүнтэй байж болно – ангийнхан нь буурь суурьтай ба тусладаг, эсвэл тэд хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудыг гадуурхах маягийн зан авир гаргаж болно. ХОТСЗ хөтөлбөр:

- Сургуулиуд оюутнууддаа ухааруулж ойлгуулахыг дэмжих, хөгжлийн бэрхшээлтэй том хүнээр ахлагч болгохыг илүүд үзэх
- Ялгаварлан гадуурхах, багш нар болон ангийнхан нь дээрэлхэх, дооглохоос урьдчилан сэргийлэх бодлого болон журам горимын хөгжлийг дэмжих
- Үе тэнгийнхэний дэмжлэг болон “анд” системийг дэмжих
- Сургууль/коллеж хөгжлийн бэрхшээлтэй багш нар болон ажилтнуудад ажил олгохыг дэмжих – эерэг үлгэр дуурайл болсон хүн хөгжлийн бэрхшээлтэй залуучуудад маш чухал юм.

Жишээ 39 Өмнөд Африк

Оюутнуудад үлгэр дуурайл болох нь

Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй Cape Town-ы дээд сургуулийн хөгжлийн бэрхшээлийг дэмжих хэсэгт ажилладаг. Тэр өөрөө хөгжлийн бэрхшээлтэй болохоор хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээг амархан ойлгодог маш чухал өмгөөлөл хамгаалалын хүн байж байгаад үлгэр дуурайлал болсон.

Мэргэжилтний нөөц болон дэмжлэг тусалцааг сайн ашиглаж байгааг дэмжих

ХОТСЗ хөтөлбөр сургууль болон коллежуудын мэргэжилтнүүдийн нөөц бололцоог зөв ашиглах, хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудыг ялгаварлан тусгаарлахаас илүү тэдний оролцоог нэмэгдүүлэхийг дэмжиж чадна.

- Хөтөч, уншигч, зохиолч, орчуулагч гэх мэт хувийн туслахууд
- Сургууль руу ирж зөвлөгөө, дэмжлэг өгөх аяллын хөтөлбөртэй багш нар
- Компьютерын ур чадвар эсвэл техник мэргэжлийн ур чадвартай болох, эсвэл эрүүл мэндийн болон сэргээн засах дэмжлэг үзүүлэх гэх мэтээр сургуулиас гадуур нэмэлт дэмжлэг үзүүлнэ.

Жишээ 40 Непал

Оюутнуудыг ердийн ангид бэлтгэх нь

Хөгжлийн бэрхшээлтэй сурагчид Nepalese дунд сургуульд суралцаж эхлэхдээ эхлээд нөөц ангид ордог. Энд тэд нар хөдөлгөөнд оролцох, энгийн ангиудад шаардлагатай нийгмийн болон боловсролын ур чадварын дадлага хийдэг. Тэд энэ ангид 1 жил байх ба сурч байгаа хурдаасаа хамаарч энгийн ангид үе тэнгийнхэнтэйгээ нэгдэж ердийн багш нараар заалгадаг байна. Тусгай мэргэшсэн багш нар хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудад үргэлжлүүлэн Брайлле руу орчуулсан гэх мэт зөв номоо олж авахад нь тусалж, хэрвээ шаардлагатай бол бэлтгэн зохион байгуулж, тэднийг албан ёсны боловсролд дасгалжуулж тусладаг. Эдгээр багш нар энгийн ангийн багш нартай хамтран ажиллаж хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд тулгарсан элдэв асуудлыг шийдвэрлэдэг.

Тусгай сургуулиуд

Харааны бэрхшээлтэй эсвэл сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан гэх мэтийн тусгай сургуулиуд оюутнууд болон тэдний гэр бүлийнхний талаар маш болгоомжтой сайтар судлах хэрэгтэй. Эдгээр сургуулийн өгч байгаа боловсрол илүү нийцтэй эсвэл сайн чанартай байх шаардлагагүй. Тусгай сургуулиуд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хэрхэн насанд хүрэгчдийн амьдралд бэлтгэх, олон нийттэй, ажил олгогчтой харилцаанд орох зэргийг бодолцох хэрэгтэй. Тусгай сургуулиуд нөөц бололцооны дээд түвшинийг, дадлагажуулах, дэд бүтэц сайтай байх гэхчлэн шаарддаг ба энэ нь ядуу буурай орнуудад үргэлж дутагдаж байдаг. Байгаа газруудад оюутнуудын бодол санааг үргэлж харгалзан үзэх ёстой. ХОТСЗ хөтөлбөр эдгээр сургуулиудыг орон нутгийн сургуулиуд хөгжлийн бэрхшээлтэй сурагчдад чанартай сургалтыг санал болготол түр зуурын юм уу бэлтгэл шат болгон ашиглахыг хийж чадна: Хожим амжилт гаргах хүнийг эртхэн хамруулах нь сайн бөгөөд амархан байдгийг санаж байх нь маш чухал юм.

Шилжилтийн үед туслах

Энэ нь үргэлж анзаарагдалгүй өнгөрч байдаг гол асуудал юм. Боловсролын шилжилтийн үе нь багаас дунд, дундаас дээд, дээдээс тогтвортой амьжиргааг багтаадаг. Хөгжлийн бэрхшээлтэй оюутнууд өөрсдийн хамт олноос дээд боловсрол дүүргэхээр явах хэрэгтэй. Энэ шилжилтийн үеийг хийхэд илүү хэцүү бөгөөд олон хүн өөрсдийн гэр бүл, хамт олны дэмжлэггүйгээр маш иххүч сорьсон ажил гэдгийг мэдсэн байдаг.

Жишээ 41

Сургууль завсардахаас сэргийлж шилжилтийн үеийг хялбарчлах

Муу шилжилтийн уршгаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд үе тэнгийнхнээсээ хоёр дахин багаар коллежид шилжин суралцдаг байна. (30).

ХОТСЗ хөтөлбөр окуутнууд, гэр бүлүүд, хамт олний гишүүд ба боловсролын байгууллагуудтай хамтран ажиллаж шилжилтийн үеийг тогтвортой байлгах, дэмжлэг үзүүлэхүйц холбоосуудыг бий болгож чадна. Рвандашийн судалгаа эхэндээ хэрхэн хамтран ажиллах ба нөлөө үзүүлж чадах, шилжилтийг амжилттай гүйцэтгэхэд туслах, энэ элементийн дүр зураг байсан.

Жишээ 42 Филиппин

Черригийн хүндэтгэл хүлээсэн шийдвэр

Черри Филиппиний маш ядуу тариаланчийн гэрт эрэмдэг майга хөлтэй төржээ. Нутгийн буянтай баян хүн болон ХОТСЗ хөтөлбөрийн тусламжтайгаар тэрээр мэс засал хийлгэж, тохирсон оймс гуталтай болжээ. Түүнийг дунд сургуульд явах үед тэр дооглуулж, бусад хүүхдүүдийн оролцож байгаа үйл ажиллагаанаас гадуурхагддаг байжээ. Тэр өөрийн шийдвэр төгс байдал, гэр бүлийнхэн болон ХОТСЗ хөтөлбөрийн тусламжтайгаар ялгаварлан гадуурхагдаж байсан ч сурахаа үргэлжлүүлжээ.

Ахлах сургуульд байхад нь түүнд хандах хандлага сайжирч, нутгийн төрийн бус байгууллага болох Кирене Симон түүнд дээд боловсрол эзэмших төлбөрийг, түүнчлэн тээврийн зардал, сургуулийн хэрэгслэл, эрүүл мэндийн үйлчилгээний зардлыг төлжээ. Ахлах сургуульд байхдаа тэрээр компьютерын хэрэглээний нарийвчилсан 2 жилийн коллежийг дүүргэжээ. Өөрийн үе тэнгийнхэнтэйгээ адил Черри одоо нээлттэй хөдөлмөрийн зах зээлд ажиллаж байна.

Черри хэлэхдээ: “Одоо би хөдөлмөрийнхөө үр жимсийг хурааж авч байгаадаа маш их бахархаж байна. Би гэр бүлдээ санхүүгийн тусламж үзүүлж, өөрийнхөө хэрэгцээг хангаж чадаж байна. Манай хамт олны дунд байдаг намайг гайхаж харж, доог тохуу хийж байсан хүмүүсийн миний талаарх ойлголт нь өөрчлөгдсөн. Хэдийгээр хөгжлийн бэрхшээлтэй ч одоо байгаа зэргээ (статус) олж авч чадсан болохоор би одоо тэдний нүднээс бахархал бишрэл олж хардаг болсон. Миний өөрийгөө үнэлэх үнэлэмж, өөртөө итгэх итгэл маань батжиж, ирж магадгүй хэцүү сорилуудтай нүүр тулах хүч чадлыг надад өгч байгаа.”



Албан бус боловсрол

Танилцуулга

Албан бус боловсрол нь албан боловсролын системээс гадуур байх боловсролыг чиглүүлдэг. Албан бус боловсрол нь тогтмол тохирсон нөхцлийг орлуулсан байдаг. Тухайлбал: харилцааны боловсрол, насанд хүрэгчдийн боловсрол, бүхий л амьдралын турш дахь боловсрол, хоёрдох боломжийг олгох боловсрол юм. Засгийн газрын зорилго болон нийгмийн бодлого нь гэрээр боловсрол олгохоор зохицуулна. Энэ нь маш бага санхүүжилтээр тодорхой бүс нутагт үйл ажиллагаагаа явуулдаг олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагуудаар итгэмжлэгдсэн дамжаануудыг багтаана.

Албан бус боловсрол нь янз бүрийн байдаг. Энэ элемент нь нийгэмд байгаа талуудыг өөртөө агуулна. Ялангуяа амьдралын турш дахь эрдэм мэдлэг. Эдгээр удирдлага болгосон заавруудын зорилгод зориулж энэ элемент нь албан ёсны боловсролын системээс гадуур орших залуу хүмүүс болон хүүхдүүдэд зориулсан албан бус боловсролд анхаардаг. Хэдийгээр ХОТСЗХ-ийн хувь хүн нь ухамсартай байх хэрэгтэй. Тиймээс хэрвээ боломжтой бол чадвар алдалттай хүүхдүүдэд зөвхөн боловсролыг санал болгох хэрэггүй. Ердийн /ерөнхий боловсролын/ сургуульд хүүхдийн эрхийг эн тэргүүнд тавих хэрэгтэй.

Албан бус сургалт бол албан сургалтын хоёрдох сонголт юм. Албан сургуульд өндөр чанартай боловсролтой байх ёстой гэж үздэг. Албан бус сургалт нь нэмэлтээр бэлтгэгдсэн байдаг.



Жишээ 43 Бангладеш

Суралцах орчин уян хатан тоглоомын хэлбэрээр дэмжих

Бангладеш тосгоны хороо (BRAC) нь Бангладешийн сургуулийн өмнөх насны болон бага сургуулийн 50000 сургуульд явдаг 1,5 сая хүүхдүүдэд боловсролын үйлчилгээ үзүүлдэг. Эдгээр сургуулиуд нь ихэвчлэн оюутнуудынхаа гэрээс 1 км-ийн радиуст байрладаг хулсны навчаар хийсэн 1 өрөө байшин байдаг. Тэд ойролцоо байгаагаараа хамтдаа явдаг ба зарим сургууль 6 цагт эхлэж 2 ээлжээр хичээллэдэг.

2003 оноос Бангладеш тосгоны хорооны сургуулиуд нь дараахи зарчмаар явж ирсэн: ядуу, эмэгтэй, хөдөлгөөний чадвар алдсан хүүхдүүд болон уугуул нутгийн хүүхдүүд, тусгай анхаарал хэрэгтэй суралцагч нарыг нэг ангид хамруулдаг. Бангладеш тосгоны хорооны сургууль нь тосгоны амьдралтай зохицуулж уян хуваартай байдаг. Ангийг барихад ажиллах ажилчин болон материал, сургуулийн байршлыг сонгох болон цагийн хуваарийг орон нутаг болон нийгмээс сонгогдсон багш нар нь хийдэг. Багшийн арга зүй нь суралцагч төвтэй болон бүлгийн (хөгжим сонсох, бүжиг урлаг, тоглоом, түүх ярих) байдаг. Зарим сургуулиуд нь албан ёсны сургуульд хэзээ ч явж байгаагүй хүүхдүүдийг хамруулдаг. Бусад сургууль нь сургуулиа орхисон хүүхдүүдийг хамруулдаг.

Бангладеш тосгоны хорооны сургуулиа төгссөн хүүхдүүд нь албан ёсны сургуульд эргэж ордог. Засгийн газрын болон засгийн газрын бус байгууллагууд Бангладеш тосгоны хороонд чадвар хүмүүсийн саад бэрхшээлийг арилгахад тусалдаг. Жишээ нь: сургуульд нь нэмэлтээр налуу зам, өргөн хаалга, том цонх болон багш нар, бусад ажилчдыг сургах, хямд өртөгөөр тоног төхөөрөмж нийлүүлэх(сонсголын аппарат, нүдний шил, тэргэнцэр), суралцагч төвтэй заах материал, ханын самбарын арга зүй, мэдлэг, ойлголтыг сайжруулах түүхэн ном.



Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн мэдлэг ур чадварыг дээшлүүлэх болон тэдний амьдралын чанарыг сайжруулах

ХОТСЗ-ын үүрэг

Хамт олонд түшиглэн сэргээн засах хөтөлбөрийн үүрэг нь албан бус сургалтын программтай ажиллах, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүсэл сонирхол болон тэдгээрт хэрэгцээтэй боловсролоор хангах

Хүсч буй үр дүн

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн албан сургалтын программд оролцох болон эдгээр хүмүүсийг бичиг үсэг сурах, тоолж сурах, өөрсдийн амьдралын нөхцөлөө сайжруулах ур чадварт суралцах бусад чадварыг сурах
- Албан бус сургалтын программд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулах ба тэдний хэрэгцээг энэ программын төлөвлөгөөнд тусгах
- Албан бус сургалтын программыг хийхэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, гэр бүлийн гишүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага, эцэг эхийн холбоо нь бүгд нийлж шийдвэр гаргана.
- Гэрийн сургалт нь албан сургалт дээр нэмэлт эсвэл албан ёсны сургалтанд бэлтгэх албан сургалтаас өөр байна.
- Нийгмийн холбоо нь хөгжлийн бэрхшээлтэй болон бэрхшээлгүй бүх оюутнууд нийлж найз нөхдийн холбоо үүсгэнэ.

Гол ойлголтууд

Албан бус сургалтын гол зарчим нь бүх сургалтын зүрх нь байх ёстой гэж үздэг.

Уялдаа холбоотой байх нь суралцагчдын ахуй амьдралтай холбоотой байж нийгмийн хэрэгцээ мөн ирээдүйд бий болох зүйл. Хүүхэд, эцэг эх, олон нийтийг татан оролцуулах механизм нь олон нийтийн хэрэгцээ, шаардлагатай холбоотой албан бус боловсрол байхыг баталж багш нар албан бус боловсролоор юу заах болон агуулгыг тодорхойлно.

Тохиромжтой Суралцагчийн хөгжих түвшинд тохирсон, шинэ агуулга, дадлага туршлагаар суралцагчийг бэлэн болгох. Заах арга нь суралцагч төвтэй, суралцагч руу чиглэсэн байна.

Уян хатан байх нь юуг заах, хэрхэн заах, өөр өөр суралцагчдын хэрэгцээнд тохируулан уян хатан байх, Жишээ нь: насанд хүрэгчид болон хүүхдүүдийн хэн нь ажиллаж, хэн нь гудамжинд амьдарч, хэн нь шоронд, хэн нь өвдсөн байна, хэн нь чадвар алдалттай байна, зөрчилтэй болон тусламж хэрэгтэйг. Мөн уламжлалт болон орон нутгийн суралцах хэв маягийг уян хатан байлгана.

Оролцоо- Суралцагч нар нь өөрийн сурах үйл явцдаа идэвхтэй оролцох, тэд

нар болон тэдний гэр бүл, нийгэм нь хэрэгжиж буй албан бус сургалтын хөтөлбөрт хамрагдана.

Хамгаалах- Хүүхдүүдийг хор хөнөөлөөс болон тэдний эрхийг хамгаалах, албан бус боловсролын байр нь эрүүл аюулгүй, чанартай хүнсээр хангагдсан, эрүүл ахуй сайтай, хор хөнөөлөөс хамгаалагдсан байх ёстой.

Хамруулах- Чадвар алдалттай бол ар гэрийн анхаарал халамжгүй бүх хүүхдүүд хамаарна. Заах болон суралцах аргын хоорондын ялгааг хамгаалах, ашиглах. Жишээлбэл: нүүдэлчний нийгэм, охидууд, чадвар алдалттай оюутнууд болон дээрх бүлгүүдэд зориулагдсан албан бус сургалт бол маш тустай. Тэдгээрийн хэрэгцээнд тохирсон байдаг.

Чанар- Албан бус сургалтын хөтөлбөр нь маш өндөр чанартай байх хэрэгтэй. Учир нь энэ боловсролын хөтөлбөр нь нийгэмд байгаа тусгай бүлгүүд болон хувь хүмүүсийн хэрэгцээнд маш хялбараар нөлөөлж чаддаг.



Санал болгож буй үйл ажиллагаанууд

Албан бус сургалтын хөтөлбөрт хамруулахад туслах

Албан бус сургалтын хөтөлбөр нь нийгэмд аль хэдийн өргөн байр суурь эзэлсэн. Эдгээр хөтөлбөрүүд нь бичиг үсэг тайлагдсан болон суурь боловсрол, эрүүл мэндийг дэмжих (нөхөн үржихүйн эрүүл мэнд, дох, бэлгийн замын өвчин), хүрээлэн буй орчны асуудал, газар тариалан, загасчлах, тухайн тосгоны хөгжил болон нийгмийн хөгжилд чиглэгдсэн байх хэрэгтэй. Албан бус сургалтын хөтөлбөр нь чадвар алдалттай хүмүүсийг тэгш бус байдлаас салгах боломжийг өгдөг.

ХОТСЗ хөтөлбөрүүд нь албан бус сургалтын хөтөлбөрүүдийг тодорхойлох болон тэднийг дэмждэг ижил төстэй хөтөлбөрүүдээс илүү чадвар алдалттай хүмүүсийг хамрахыг дэмждэг. Албан бус сургалтын хамрах хүрээ нь чадвар алдалттай хүмүүсийн бүх төрлийн хөтөлбөрүүдийг хамруулдаг ба тэдгээрийг хэрэгжих боломжтой газарт зохион байгуулж, мөн заах хэлбэр нь хялбар байх ёстой.

Засгийн газрын хөтөлбөрүүд

Засгийн газрын яамдууд тухайлбал нийгэм хамгааллын яам, боловсролын яам нь албан бус сургалтын хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хариуцдаг. Эдгээр хөтөлбөрүүд нь ихэвчлэн бичиг үсэг сурах, насанд хүрэгчдийн суралцах үйл явцад болон мэргэжлийн дадлагад чиглэгддэг. ХОТСЗ хөтөлбөр нь албан бус сургалтын бодлогыг олж мэдэх хэрэгтэй. Хэн эдгээр бодлогын хэрэгжилтэнд үүрэг хүлээх болон албан бус сургалтын одоогийн байдалд хэн үүрэг хүлээх, чадвар алдалттай хүмүүсүүдэд тусламж болон зээл олгох боломж бүрдсэн байх эсэх. Албан бус сургалтын хөтөлбөрт хамрагдаж байгаа чадвар алдалттай хүмүүсийг амьдрах арга барилд хэвшүүлэхэд нь ХОТСЗ хөтөлбөр туслах болно.

Жишээ 44 Непал

Бодлогын үйл ажиллагааны хүртээмж

Непал улсын албан бус боловсролын бодлого /31/: Албан бус боловсролын төв нь үндэс угсаа, хэл, хүйсийн хамаарал, биеийн чадвар алдалтууд болон албан бус сургалтын хамрах хүрээнд байгаа асуудалтай хүмүүсийг онцгой анхаарахад чиглэдэг

Бодлого 8: Тэгш хамрах боловсролын бодлогыг хүртээмж, чанар, оршин тогтнолыг дэмждэг.

Дараах бодлогын үйл ажиллагаанууд тухайн бодлогын хэрэгжилтийг дэмжинэ:

- Тусгай боловсрол болон сурган хүмүүжүүлэх арга нь нийгмийн бүлэг, үндэс угсаа, хүйс, хэл чадвар алдалттай хүмүүсийг арьс өнгөөр ялгахыг зогсооход чиглэсэн.
- Тусгай зохицуулалт нь янз бүрийн чадвар алдалттай хүүхдүүд, зөрчилдөөнтэй байгаа хүүхдүүд болон насанд хүрэгчид, ажил эрхэлж байгаа хүүхдүүдийн албан бус сургалтын чанарыг дээшлүүлнэ.



Хамт олонд суурилсан албан бус сургалт

Засгийн газрын бус байгуулагууд нь янз бүрийн хөгжингүй, ойлголт бүхий үйл ажиллагаа явуулдаг. Жишээлбэл: итгэмжлэгдсэн сургуулиуд, өдөр өнжүүлэх төв, охидын сургууль, чадвар алдалттай сургууль завсардсан хүүхдүүдийн сургууль, албаны сургуулиа орхисон ба ажил эрхэлж буй хүүхүүд. ХОТСЗ хөтөлбөр нь нийгэмд суурилсан албан бус сургалтын өөр өөр хэлбэрийг тодорхойлно.

ХОТСЗ хувь хүмүүс албан бус сургалтын тусламжтайгаар хамт ажиллахад хэрэгтэй заах материал нь хялбар байх (Braille, кассет, бичлэг), хүрээлэн буй орчин нь хялбар нээлттэй байх ба суралцагч нар нь суралцахыг дэмжсэн байх хэрэгтэй.

Хөтөлбөр уялдаа холбоотой, бодитой байхыг батлах нь

Сургууль хатуу чанга шаардлага тавих нь дутагдалтай, албан бус сургалтын хөтөлбөр нь тогтмол уян хатан, хувь хүмүүсийн хэрэгцээнд таарсан, дасан зохицоход хялбар байдаг. ХОТСЗ хөтөлбөр нь албан бус сургалтанд дараах байдлаар туслана.

- Хамгийн гол зүйл нь бичиг үсэг сурах ба тоо тоолж сурах;
- Дадлагажих ур чадвар, амьдрах ур чадвар, хувь хүний хөгжлийг нэмэгдүүлэх
- Шийдвэр гаргах ур чадварт сургахад үр дүнтэй;
- Мэргэжлийн ур чадвар, үйл ажиллагаанаасаа ашиг олох ажил эрхлэлтэнд чиглэх;

- Эрх мэдэл бүхий оюутнуудад аажмаар итгэл төрүүлэх, хөтөлбөр болон төслийн ач холбогдлыг ойлгуулах ХОТСЗ хөтөлбөр нь чадвар алдалттай хүмүүсийн эрх мэдлийг дэмжих баталгаа болдог;
- Хөгжлийн бэрхшээлтэй оюутнууд, тэдний гэр бүл, үе тэнгийхэн, хамт олны хоорондын харилцааг дэмжих, тухайлбал, суурь дохионы хэл, брайль үсэг, цэвэр тодорхой ярих гэх мэт байдлаар дэмжинэ.

Жишээ 45 Бангладеш

Боловсролын хоёрдох боломж

Бангладешд байх нэгэн албан бус сургалтын хөтөлбөр нь зөвхөн том хотын нийгмийн харилцаанд үйлчилдэг. Тухайлбал: Dhaka, Chittagong, Rajshahi. Энэ хөтөлбөр ялангуяа хэвийн бус салбарт ажилладаг хүүхдүүд(аюултай ажил) эсвэл гудамжинд амьдарч ажилладаг хүүхдүүд мөн өөр өөр гэмтэлтэй хүүхдүүдэд чиглэн ажилладаг. Энэ хөтөлбөр нь албан ёсны сургалтын системийн хэвийн цагаар заагдах хураангуйлсан ерөнхий боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Тус хөтөлбөрт хамрагдах үед тухайн хүүхдүүдийн нас нь аль хэдийн өнгөрсөн байдаг. Тиймээс ихэнхи хүүхдүүдийн хувьд тус хөтөлбөр нь боловсролтой болох хоёрдох боломж юм. 10 болон түүнээс дээш настай охид хөвгүүд нь энэ хөтөлбөрт хамрагдаж болно. Анги жижиг болохоор гурван ээлжээр хичээллэх ба хүүхдүүдэд ажлаа үргэлжлүүлэн хийхийг зөвшөөрдөг, тэдний гэр бүлийн орлогыг дэмждэг. Тус ерөнхий боловсролын хөтөлбөрийн дараа хүүхдүүд тус хөтөлбөрийн “paratrade” төвд мэргэжлийн ур чадвар эзэмшихээр орж болно. Үүнд: 6 сар хагас цагаар хичээллэдэг. Эсвэл 1-2 жил мэргэжлийн дадлага хийж болно. Албан бус сургалтын хөтөлбөр нь чадвар алдалттай болон алдалтгүй оюутнуудад туслах тусгай албан тушаалтан байдаг. Энэ хөтөлбөр нь төгссөний дараа ажил эрхлэлтэнд тусалдаг.

Гэрээр суралцахад туслах

Гэрээр суралцах нь нэмэлт болон бэлтгэсэн янз бүрийн албан ёсны сургалтууд байдаг. Энэ нь ерөнхий харилцаа, үйл ажиллагаа, өдөр тутмын амьдралын ур чадварт суралцах оюутнуудад ихээхэн хамаатай. Эдгээр ур чадварыг тухайн орчинд маш сайн эзэмшдэг ба хиймэл (зохиомол) орчинд ч ашиглаж болно. ХОТСЗ хөтөлбөр нь гэр бүлийн гишүүд, багш нар болон суралцагчидтай маш ойрхон харилцан уялдаатай ажилладаг ба гэрт нь очиж байнга тухайн гэр бүлд ажиллах нь гэрээр суралцах үйл ажиллагааг амжилттай болдог. Гэрээр суралцах нь олон төрлийн арга барилын нэг хэсэг бөгөөд маш их үр нөлөөтэй. Улмаар чадвар алдалтай хүүхдүүдийг тусгаарлан хасах нь гэрээр суралцахад нөлөөлдөг.

Хүнд болон хавсарсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг гэрээр суралцахад хамруулсан жишээ:	Хүнд болон хавсарсан хөгжлийн бэрхшээлтэй гэрт байдаг хүүхдүүдийг нийгмээс тусгаарласан жишээ:
<ul style="list-style-type: none"> • ХОТСЗ хөтөлбөр нь хүүхдийг төрснөөс нь эхлэн гэр бүлд дэмжлэг үзүүлдэг. • Сайн дурын ажилтан болон бусад хүүхдүүд эдгээр хүүхдүүдийн гэрт нь очиж өдөр тутмын амьдралын үйл ажиллагаанд тусалдаг • Хүүхдүүд нь олон нийтийн үйл ажиллагаа, шашин болон нийгмийн арга хэмжээнд хамрагддаг • Багш нар нь гэрт зочилж хэрхэн суралцах зорилгыг хамтдаа дэшүүлнэ • Насанд нь тохируулж тоглоомын бүлэгийг байгуулна • Дүүргийн боловсролын баг нь төлөвлөгөөний дагуу хүүхдүүдийг хамруулдаг. • Эцэг эх нь орон нутгийн гэмтэлтэй хүмүүсийн группын идэвхитэй гишүүн нь байдаг. Мөн эцэг эх нь хүүхдийн ирээдүйн төлөвлөгөөг хийнэ. 	<ul style="list-style-type: none"> • Гэр бүл нь хүүхэд төрөх үеэс л гутамшиг гэж үздэг • Том эгч нар нь дүү нараа асрах гэж сургуулиас гардаг. • Хөршүүд болон бусад хүүхдүүд зочлохоос зугтаж, тэднээс айдаг. • Хүүхдүүдийг гадагш гаргахгүй гэртээ хэвтүүлж, хүнээс хараат, сул дорой тамир тэнхээгүй болдог. Гэр бүл нь ажиллахгүй боловч хүүхдүүдийнхээ төлөө мөнгөө үрдэг. • Аав нь ичиж, ээж нь орхин явсан байдаг • Ээж нь ажилгүй байх тохиолдол ихэсч, хүүхдүүддээ хэрхэн туслахаа мэддэггүй • Эх нь хүүхдээ хайхрахгүй зөнд нь хаядаг • Ах дүү нар нь ичгүүртэй гээдгэрлэхгүй, эсвэл ажилгүй байдаг

Онцгой сургалттай бүлгийг дэмжих

Заримдаа тусгай хэрэгслийг суралцахдаа ашигладаг.(жишээ нь: Брайлл болон дохионы хэл). Тэд нар суралцахдаа группээрээ хамтдаа ирж суралцдаг. ХОТСЗ хөтөлбөр нь эдгээр бүлгүүдийн хөгжлийг дэмжиж, оюутнууд болон чадвар алдалттай байгууллагуудын суралцах үйл ажиллагааг хөнгөвчлөхөд тусална. Дохионы хэл ашиглаж сурах нь хэвийн суралцаж байгаа хэлнээс хүнд. Чадвар алдалттай хүмүүсийн дотор дүлий хүмүүс олон байдаг. Орлого багатай улсуудад олон улсын засгийн газрын бус байгууллагууд дүлий суралцагч нарыг илрүүлдэг. Тэд нарын төрөлх хэлээр нь дохионы хэл ховор заадаг. Гэвч гадаад хэлийг үргэлж заадаг. Албан бус сургалтын хөтөлбөрт дохионы хэлийг заадаг. Энэ нь дүлий хүмүүст болон тэдний гэр бүлд маш чухал хэрэгтэй. Зарим нэг насанд хүрсэн дүлий хүмүүст багш шаардлагатай байдаг.

ХОТСЗ хөтөлбөр нь дараах зүйлийг хангах

- Сонсголгүй суралцагчдын эрх, үзэл бодлыг хүндэтгэх
- Гэр бүл нийгмээс нь тусгаарлах болон нийгмээс хасах онцгой нөхцлийг нэмэгдүүлэхгүй байх, хүүхдүүдийг гэр бүл нийгэмд нь оролцуулах

Жишээ 46 | Вьетнам

Дангийн ур чадвар бусдаас илүү

Данг бол Вьетнамын Хо Чин Мин хотын гаднах нэгэн тосгоны сэргэлэн ухаалаг залуу. Тэрээр сонсголгүй, багаасаа дохионы хэл сурснаас гадна англи хэлээр хэрхэн уншиж, бичихийг сурсан. 25 настайдаа тэрээр бүтэн цагаар ажиллаж сайхан амьдралтай болсон нэгэн. Хо Чин Мин хотын сонсголгүй хүмүүсийн клубийн гишүүд болон ХОТСЗ хөтөлбөрийн удирдагч нараас утга зохиолыг ойлгуулахыг тулд Вьетнам хэл, англи хэлийг заана уу гэж Дангаас хүсчээ. ХОТСЗ хөтөлбөр, орон нутгийн удирдлага болон буяны байгууллагууд долоо хоногт 2 удаа хичээллэхээр оройн ангид сонсголгүй 30 залууг элсүүлсэн байна. Данг хоёр дахь хэл болсон англи хэлний сургалтын хөтөлбөр, хэрэглэгдэхүүнийг хэрэглэж байлаа. Сургалтанд хамрагдаж байгаа 20 суралцагч тус бүр Дангд ойролцоогоор нэг хичээлд 1\$ төлдөг. Тэд 2 жил гаруй хугацаанд англи хэлийг эзэмшээд төрөлх дохионы хэлээ сайжруулахаар ажиллаж эхэлсэн.

Хамт олонд түшиглэсэн өдөр өнжүүлэх төвүүд тохиромжтой гэдгийг батлах

Өдөр өнжүүлэх бүлэг нь 24 цагийн турш чадвар алдалттай хүүхдүүдийг эцэг эхээс түр хол байлгана. Эдгээр төвүүд нь эцэг эхчүүдэд сайн туслах, маш ядуу хүүхдүүдийг сургах болон идэвхитэй үйл ажиллагааг сайжруулах. ХОТСЗ хөтөлбөр нь тэр бүлгүүдийн хүүхдүүдийн насаар нь тохируулан тоглох болон идэвхитэй сурах, хүүхдийн сонирхолыг хөгжүүлэх, эрхийг хамгаалах зэрэгт туслана. Энэ бүлэг нь орон нутгийн чадвар алдалттай хүүхдүүдийг татан хамруулсан.

Ердийн сургуулийн холбоог дэмжих

Олон улс орнуудын үндэсний боловсролын системд албан бус сургалт гэж байхгүй албан сургалттай ижил үнэ цэнэтэй гэж үздэг. Албан бус сургалтын хөтөлбөр нь заах арга сургалтын хөтөлбөр нь өөр уян хатан, сурацагчийн тэтгэмж хангалттай байдаг. Албан болон албан бус сургалтын систем нь ялгаатай, албан бус сургалт нь чадвар алдалттай хүмүүсийн арьс өнгөөр ялгагдаггүй.

Жишээ 47 ЭНЭТХЭГ

Засгийн газрын төлөвлөгөөг өргөжүүлэх

Чадвар алдалттай хүүхдүүдийн гэрийн сургалтыг Энэтхэгийн засгийн газар хүлээн зөвшөөрсөн. Үүнд хэн сургалтын системийг ямар шалтгаанаар орхисон, хэн сургуульд хандах нь хэцүү байгааг сургалтанд хамруулах. Засгийн газрийн хөтөлбөрт эцэг эхийн дэмжлэг ба тэдгээрийн хүүхдүүдийг сургуульд илгээхэд чухал анхаарал хандуулан шинэ мэдээллээр хангах.

Боловсролын байгууллага нь орон нутгаас хариуцлагатай сайн дурын ажилтанг тодорхойлох түүнд туслах ба орон нутгийн засгийн газрын бус байгууллагуудыг зохицуулна. Сайн дурын ажилтан бүр 3 хүүхэдтэй ажилладаг. Сургуулийн удирдлага тэдэнд мөнгө төлдөг. Гэрээр сургалтанд нэг удаа хамруулаад хүүхдийг ойролцоох сургуульд оруулна. Сургуулийн захиргаа нь түүнийг хариуцна. Энэ төлөвлөгөөний дагуу засгийн газар нь хэн сургуульд хамрагдаж чадахгүй байна тэр хүмүүст хүрч ажиллах бөгөөд амьдралын ур чадвараа аль хэдийн хангасан одоог болтол гэртээ байгаа хүүхдүүдтэй ажилладаг. Засгийн газрын санаачлага нь албан болон албан бус сургалтын хөтөлбөрийн хоорондын нөлөөг үүсгэж, суралцах шинэ боломжоор хангана.

Хэдийгээр албан ба албан бус сургалтын салбар нь тусдаа байдаг ч үзэл суртлын хувьд зарим нэг нь ялгаатай. Тэд олон арга замаар идэвхитэйгээр бие биедээ дэмжлэг үзүүлдэг. ХОТСЗ хөтөлбөр нь дараах зүйлийг хөнгөвчлөхөд туслаж чадна.

- Албан ба албан бус сургалтын салбарын удирдлагуудыг урьж ХОТСЗ хөтөлбөрийг дээшлүүлэх стратегийг боловсруулна.
- Сургуульд хамрагдаж байгаа багш эцэг эхчүүдийг дадлагажуулах, гэрийн сургуулийг дэмжих.
- Албан бус сургалтаас албан сургалтанд шилжихийг дэмжих
- Албан сургалтанд амжилттай байгаа хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудад туслах албан бус сургалтын хөтөлбөрийг сайжруулах
- Албан бус салбарын санал болгож буй сургалт, амьдрах аргыг, цаашдын боловсрол эзэмшихэд нь хөнгөвчлөх
- Барилга байгууламж ашиглахыг дэмжих, Жишээлбэл: албан бус сургалтын хөтөлбөрт сургуулийн байгууламжийг цагийн хязгааргүй ашиглах.
- Албан бус сургалтын болон албан сургалтын хөтөлбөрийн ажилтнууд нь өөрсдийн үйлчилгээ дадлага туршлагаа хуваалцахыг дэмжих

Жишээ 48 Гондурас

Хичээлийн дараа багшаар хангах

Гондурасын Эл Порвенирт ХОТСЗ хөтөлбөр нь нэгдүгээр ангийнхаа шалгатыг давж чадахгүй хөгжлийн бэрхшээлтэй, бэрхшээлгүй хүүхдүүдэд зориулж хичээлийн дараах давтлагын багшаар ажиллуулжээ. Хичээлийн жилийн төгсгөлд хүүхдүүд шалгалтаа өгсөн. Сургуулийн нэг жилд давтлага өгөх түвшин нь 75%-аар буурсан гэж дүүргээс тайлагнасан байна. Энэ байдал нь бага сургуульд байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хамруулан дүүргээс идэвхтэйгээр ХОТСЗ хөтөлбөр давтлага өгч ажилласан байна.



Насан туршийн боловсрол

Танилцуулга

Насан туршид суралцах эрхийн тухай Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенцийн 24 зүйлд заасан байна.(4) Насан туршид суралцах нь хүмүүсийн мэдлэг, ур чадвар, чадамжийг сайжруулах зорилготойгоор тэдний өдөр тутмын амьдралын үйл ажиллагаанд түшиглэсэн сургалтыг зохион байгуулах явдал юм. Насан туршид суралцахгүй бол нийгэм эдийн засаг, технологи дэвшил, хүрээлэн буй орчин, улс төрийн өөрчлөлтүүдэд дасан зохицоход хувь хүний мэдлэг ур чадварыг сайжрах, нийгэм хамт олон дунд төлөвших нь буурдаг/32/.

Насан турш суралцах нь олон салбаруудад албан ба албан бус хэлбэрээр явагддаг бөгөөд бусад сургалтын хөтөлбөр дээр нэмэлтээр орж сургалтын бүхий л таатай орчныг бүрдүүлэн тасралтгүй явагдана. Насан туршид суралцах хөтөлбөр нь дэлгэрэнгүй, олон талын асуудал, түгээмэл элементүүдийг багтаасан албан бус сургалт юм. Насан туршид суралцах сургалтын хөтөлбөр болон удирдамжууд, ерөнхий эрдмийн сургалтын бүтэц нь хөгжлийн бэрхшээлтэй залуучууд/хүүхэд/ болон насанд хүрэгчдэд зориулагдсан байна.

Жишээ 49

Суралцах гэдэг бол тасралтгүй үргэлжлэх үйл ажиллагаа юм

Ширлеу хэдийгээр тархины саажилтаас болоод сургуулиасаа завсардсан ч гэсэн маш авъяаслаг, ухаантай, олон зүйл дээр бусдын адил амжилт гаргаж чадсан залуухан бүсгүй юм. Тэр их сургуульд эчнээгээр суралцан бизнесийн удирдлагын магистр зэргийг хамгаалж, одоо мэргэжлийн менежер болсон. Мөн бусдад туслахын тулд компьютерийн мэдлэг, ур чадвараа дээшлүүлж, өөр бусад ур чадвар олж авахын тулд үргэлжлүүлэн суралцаж байна. Ширлеу тасралтгүй суралцсаар байхыг чармайж байна. Хүний орчлонд ялгаварлан гадуурхагдаж, үл зөвшөөрөгдөхгүйн тулд тэрээр амьдралын туршид суралцах боломжийг олж авснаар тасралтгүй суралцаж, нийгэмд эзлэх байр сууриа өсгөх, мэргэжлийн зэрэг дэвээ дээшлүүлэх бололцоог олж авчээ.

Жишээ 50

Өөртөө итгэлтэй, биеэ даасан байхад нь насанд хүрэгчдэд дэмжлэг үзүүлэх

Боломж олгох гэдэг нь Өмнөд Африкийн Дурбан хотын ойролцоо байдаг тосгонд төрийн бус байгууллага болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага хамтран явуулдаг хөтөлбөр юм. Fundelwa өөрөө хөгжлийн бэрхшээлтэй хүн бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бичиг үсэг болон тооны ухаан заадаг багш бөгөөд түүний хичээлийн анги нь тосгоны залуучуудын сэргээн босгож, засвар хийсэн агуулах юм. \ENABLE\ Уг хөтөлбөрийн гол зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрэгчдийг бие даасан, өөртөө итгэлтэй болоход дэмжлэг үзүүлэхэд оршино. “Боломж” сургалт нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эдлэх эрхийн талаар зааж, мөнгөн орлогыг олж авах, тэтгэлэгт яаж хамрагдах талаар зөвлөгөө, мэдээлэл өгдөг. Үүнд оёдлын төсөл орох ба суралцагч хүмүүс материалын үнэ, хэрэглэгдэх тоо хэмжээ, хийсэн зүйлээ хэрхэн зарж борлуулах талаар суралцдаг байна. Суралцагч насанд хүрэгчид дараах шалтгаануудаар тус сургалтанд ирдэг: төсөл бичихэд туслалцаа авах, худалдан авах жагсаалт гаргах, эмийн нэр нэршил, заавар, эмчид үзүүлэхээр очиход чөлөөтэй харилцах гэж Англи хэл суралцах. Fundelwa өөрөө хөгжлийн бэрхшээлтэй хүн тул түүний ангид суралцахаар ирсэн хүмүүст өөрийн биеэр үлгэр дууриал үзүүлэхийг хичээдэг байна. Боломж төсөл нь олон улсын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан хөдөлгөөний “Бидэнгүйгээр бидний тухай юу ч байхгүй” уриан дор, үндсэн оролцогчдод чиглэсэн удаан хугацаагаар үргэлжилдэг. Тус төсөл хөтөлбөр нь шийдвэр гаргах, үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх бүхий л шатанд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг татан оролцуулдаг.



Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон насанд хүрэгсдийг амьдралын турш суралцах боломжийг сайжруулах арга замыг бий болгож, төрөл бүрийн сургалтын туршлага хуримтлуулах.

ХОТСЗ-ын үүрэг

Хамт олонд суурилсан сэргээн засах хөтөлбөрийн үүрэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ажилгүйдэл, тэдний эрх хязгаарлагдах, нийгмээс тусгаарлагдахаас урьдчилан сэргийлж амьдралын турш суралцах боломжийг бий болгож өгөх явдал юм.

Хүсч буй үр дүн

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуучуудад зориулсан албан ёсны сургууль нь үе тэнгийнхний зөвлөгөө өгөх үйлчилгээ, мэргэжил, зэргийн удирдамжийг боловсруулж, ажлын болон ур чадварын сургалтыг дэлхий нийтэд дамжуулан тэдгээрийг дэмжинэ.
- Хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрэгчид амьдралын туршид суралцах боломжтой, сургалтын хөтөлбөр уян хатан, тэдэнд тохирсон байна. Жбэл: дээд боловсролыг их сургуульд эчнээгээр сурах, зайны сургалтанд хамрагдах байдлаар олж авах.
- Тасралтгүй суралцах боломжийг хувь хүн, хамт олны хэрэгцээнд тулгуурлан зохион байгуулж, хүүхэд, насанд хүрэгчид гэр бүлийн гишүүд болон асран хамгаалагчдад хэрэгцээтэй ач холбогдол бүхий сургалт байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон насанд хүрэгчид ДОХ болон бэлгийн замын халдварт өвчин, нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаархи мэдээлэл, амьдралын хэрэгцээ, амьдрах ур чадвартай хамааралтай сургалтуудыг тасралтгүй явагдана.
- Сургалтын төвийн, улсын болон хувийн сургуулийн олон нийтийн сургагч багш нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг амьдралын турш суралцах боломжийг нэмэгдүүлэн, нийгмийн үйл ажиллагаанд оролцох оролцоог нэмэгдүүлэх зэрэгт дэмжлэг үзүүлнэ.

Гол ойлголтууд

Насан туршид, тасралтгүй суралцах гэдэг нь бид өдөр тутмын амьдралаас шинийг сурах гэсэн түгээмэл ойлголтонд тулгуурладаг: Энэ нь өнөөдөр дэлхий дээр маш хурдан өөрчлөгдөж, эрэлт хэрэгцээ нь нэмэгдэж байгаа чухал асуудал болоод байна. Гэсэн хэдий ч, суралцах боломж нь сургалтын төвд очиж сурах биеийн болон санхүүгийн чадамжтай хүмүүс, байгууллага, тодорхой насны бүлэг хүмүүсээр хязгаарлагдаж байгаа бөгөөд сургалтын орчин хэтэрхий албархуу байснаас сургалтын чанар алдагдаж, хөгжлийн бэрхшээлтэй насан хүрэгчид бүрэн хамрагдахгүй таслах явдал гардаг байна. Амьдралын турш суралцах нь албан бус сургалтын хэлбэрүүдэд байдаг зарим зарчмуудыг сургалтын хөтөлбөртөө нэгтгэдэг.

Насанд хүрэгсдийн сургалт

Насанд хүрэгчдэд зориулсан амьдралын сургалт нь олон төрлийн сэдвийг хамарч, ялангуяа ажил эрхлэх боломж, нийгмийн оролцоо, хувь хүний хөгжил, иргэнд чиглэсэн үйл ажиллагааны талаар багтдаг.

Насанд хүрэгсдийн сургалт нь тэдний хэрэгцээнд тохирсон, хүүхдийн сургалтаас сургалтын материал, арга аргачлал, загвар, заах арга зүй нь ялгаатай. Амьдралын турш суралцах нь хувь хүний өөртөө анхаарал тавих байдал, өнгөрсөн амьдралын туршлага, хүн бүрийн зорилготой уялдсан суралцагч төвтэй сургалт байна.

Насанд хүрэгчид тэдэнд ямар нэмэлт дэмжлэг хэрэгтэй байгаа, хэзээ хэрхэн суралцахаа урьдчилан мэдэж, тэд ямар сургалтанд хамрагдах хүсэлтэй байгаагаа илэрхийлж, өөрсдөө санаачлагатай, шийдвэр гаргаж, суралцахаар сэтгэл шулуудсан байх ёстой. Тэд сургалтын төлөвлөгөөнд бүхий л үзэл бодлоо тусгах, суралцах тухайд дэмжлэг авах хэрэгтэй бөгөөд сургалтын орчин нөхцөл сайн байх ёстой.

Насанд хүрэгчдийн сургалтын хэлбэр нь өөр өөр цаг хугацаанд, төрөл бүрийн байршилд хамгийн тохиромжтой арга барилаар зохион байгуулагдаж, хүмүүсийн эрэлт хэрэгцээнд нийцсэн уян хатан, бүтээлч байна.

Насан турш суралцах сургалтын хэлбэрүүд

Тасралтгүй сургалтын түгээмэл хэлбэрүүд нь:

- Насанд хүрэгчдийн сургалт- ажилд зориулсан албан ёсны мэргэжил, ур чадвар олгох мэргэшүүлэх сургалт
- Тасралтгүй сургалт- ихэвчлэн хувь хүнийг хөгжүүлэхэд чиглэсэн, сургалтын байгууллагаар албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн багц цагийн ба багц цагийн бус сургалт
- Мэргэжлийн хөгжил- ажил олгогч нь ажлын байранд дээр нь сургалт явуулж чадваржуулах, дадлагажуулах сургалт
- Өөрийгөө чиглүүлэх сургалт- хувь хүн өөрийгөө дайчлан интернэт, номын сан зэрэг мэдээллийн эх сурвалжаас шинэлэг мэдээлэл авч ажилдаа хэрэгжүүлэх

Амьдралын турш суралцах сургалтанд бичиг үсэг тайлагдсан насанд хүрэгчид хамрагдах ба харилцааны ур чадвар, эрүүл амьдрах ур чадвар/эмнэлгийн тусламж үзүүлэх ур чадвар/, хувь хүний амьдралын чанарыг сайжруулах тухай, эчнээ сургуулиар үндсэн ур чадварыг сайжруулах зэрэг сургалтууд явагдахын зэрэгцээ тусгай мэргэжлийн сургалт, боловсрол эзэмшүүлэх, мэргэшүүлэх сургалтууд бас явагддаг. Үүнд өөртөө туслах бүлэг сургалт, эцэг эхчүүдийн байгууллага, эрүүл амьдралын хэв маягт суралцах жижиг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бүлэг, хөдөлмөрийн чадваргүй иргэдэд орлого бий болгох тухай сэдэв, бүлгүүд багтдаг.

Эчнээ сургалт

Эчнээ сургалт нь ихэвчлэн “Нээлттэй сургадаг сургууль”-ийг түшиглэн явагддаг ба ерөнхий эрдмийн боловсрол эзэмшээгүй, тухайн сургалтанд өмнө нь хамрагдаж байгаагүй, ахмад суралцагч нарт зориулан явагдах ба сургалтын хөтөлбөр нь суралцагчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн, хэзээ, хаана, ямар

төрлийн сургалт болох тухай мэдээллийг тодорхой өгнө. Заах арга нь уламжлалт бус, шинэлэг мэдээлэл, харилцааны арга аргачлал, хэрэглээг багтаасан байдаг. Суралцагч нь тэдний ажил амьдралд таарч тохирсон, өөрсдөд нь зориулсан, ажил болон гэртээ ашиглаж болохуйц сургалтын материал, хөтөлбөрийн дагуу суралцах болно. Хүүхэд болон насанд хүрэгчид ихэвчлэн өөрсдөө бие даан хөдөлмөр эрхэлдэг тул тэдэнд мэдлэг, ур чадварыг давхар эзэмшүүлэх боломжийг олгодог.

Жишээ 51 ЭНЭТХЭГ

Эчнээ сургалтын дэмжлэг

Энэтхэг улсын Үндэсний Их сургуулийн боловсруулсан Эчнээ сургалтын хөтөлбөрийг “Суралцагчдад өөрсдийн хэрэгцээ, зорилгодоо тохируулан чөлөөтэй сонгох эрхтэй” байдаг. Суралцагчид өөрсдийгөө хөгжүүлэх сургалтын тусгай хөтөлбөрөөс өөртөө тохируулан авч суралцдаг. Сургалтын төв дээр амралтын өдрүүд, хагас бүтэн сайнд ганцаарчилсан сургалт нь ярилцлага, лекц, аудио- видео хэлбэрээр хичээллэдэг. Энэ нь суралцагчдад өөрт нь зориулж бэлдсэн материалаар шалгалтаа чөлөөтэй өгөх боломжийг олгож байгаа бөгөөд кредит цуглуулахад дэмжлэг болдог. Суралцагчдын бүртгэл нь 5 жилийн турш хүчин төгөлдөр байдаг.

Амьдрах ба урт наслах чадвар

Амьдрах ба урт наслах чадварт нийгэм, хамт олон, гэр бүлийн дунд зохион байгуулагдаж байгаа аливаа ажилд оролцож, өөртөө болон өрөөл бусдад хэрэгцээтэй зүйлийг хийж бүтээх мэдлэг, ур чадвартай байх хамааралтай. Яагаад гэвэл хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ялгаварлан гадуурхагдахгүй, бусдын адил амьдрахын тулд амьдралынхаа бүхий л хөгжлийн шатанд тасралтгүй суралцан биеэ даан амьдрах ур чадвар, хөгжих ухаанд суралцах хэрэгтэй болно. Сэтгэцийн асуудалтай хүмүүс нь авъяас, мэдрэмжээ тодорхой хэмжээгээр алдсан байдаг тул амьдрах ба урт наслах чадварт суралцахад нь илүү их дэмжлэг үзүүлэх хэрэгтэй байдаг.

Санал болгож буй үйл ажиллагаанууд

Шилжилтэд дэмжлэг үзүүлэх

ХОТСЗ мэргэжилтнүүд нь биеэ даасан бүлэглэлүүд, сургагч багш нар, ажил олгогчид, гэр бүлийн гишүүд, болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дунд холбоо тогтоох зорилгоор тодорхой ажлуудыг хийдэг. Хэрэв ямар нэгэн дэмжлэг авах нөхцөл байхгүй бол сургуулиас гэрт нь хүргэж өгөх, ур чадвар олгох сургалтанд хамруулах, биеэ даах чадварыг нэмэгдүүлэх зэрэгт тус дэм болох



хэрэгтэй. Хамт олонд тулгуурласан сэргээн засах хөтөлбөрийн мэргэжилтнүүд бүхий л хүмүүсийн түвшинд тохирсон энгийн зөвлөмжүүдийг тэдэнд ойлгомжтой хэлбэрээр, үр дүнтэй зөвлөж чаддаг байх ёстой. Мөн өөрийнхөө сургалтанд татан оролцуулж, сонголтоо өөрсдөө хийх ур чадварт сургахын зэрэгцээ залуучуудыг амьдралд итгэх итгэл найдварыг нь дэмжин зоригжуулж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зөвлөгөө өгөх байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэн ажиллана.

Насанд хүрэгчдийн бичиг үсэг тайлагдалт, боловсрол олгох боломжуудыг тодорхойлох

Зарим хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрэгчид хичээлийн цагаар ажилтай байх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг дэмждэг байгууллага, нийгэмлэгүүдэд хандах дургүй, төлбөрөө төлөх боломжгүй, орон гэргүй, мэргэжилтнүүдэд өөрийгөө танилцуулах боломжгүй зэрэг бусад олон шалтгаануудаас болж албан ёсны тасралтгүй сургалтанд хамрагдаж чадахгүй, сургуульд явахгүй үлддэг байна. Хамт олонд тулгуурласан сэргээн засах хөтөлбөр нь олон хүнийг хамруулсан эчнээ сургалтаар насанд хүрэгчдэд мэдлэг боловсрол, бичиг үсэг сургах боломжуудыг тодорхойлдог байна.

Хамт олонд тулгуурласан сэргээн засах хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрэгчдэд зориулсан бичиг үсэгт суралцах эчнээ сургалтын хөтөлбөрийг боловсруулж, сургалтын материал, сургалтанд ашиглах харилцаа холбооны техник хэрэгслүүдээр бүрэн хангаж өгдөг.

Жишээ 52

Маяагийн амжилттай аялал

Маяа 3-р ангиа анх удаа амжилттай төгслөө, яагаад гэвэл тэнд бичгийн шалгалт өгдөггүй байна. Түүнийг 10 настай байхад нь сургуулийн захирал сургуулиас хүчээр гаргасан байна. Учир нь тэр хөгжлийн бэрхшээлтэй (хараагүй, оюун ухааны болоод биеийн хөгжил дутуу), ингээд тэр хараагүй хүмүүст зөвлөгөө өгдөг нийгэмлэгт очжээ. Тухайн нийгэмлэг Маяаг эчнээ сургуульд суралцахыг зөвлөсөн байна. Маяа 13 насандаа дунд сургуулийн ахлах ангийг төгссөн байна. Дараа мэргэжлийн сургалтанд хамрагдаж, компьютерийн курст орж, нийгмийн ур чадвар заадаг ангид суралцлаа. Өнөөдөр Маяа цэцгийн урлагийн ангид орж, цэцгийн төрлөөр мэргэшиж байна. Тэрээр өөрийнхөө сонирхлын дагуу эчнээ сургуульдаа улам олон зүйлд суралцсаар байна.

Тасралтгүй боловсрол эзэмших боломжууд


Тасралтгүй боловсрол эзэмших боломжуудыг интернэтэд суурилсан боловсролын хөтөлбөр, зайны сургалт, орон нутгийн боловсролын байгууллагуудаар дамжуулан нэмэгдүүлдэг. Зайны сургалтанд ихэвчлэн дээд боловсрол эзэмшсэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хамрагдах боломжтой бөгөөд хүрээлэн буй амьдрах орчин нь тохиромжтой бус, тээврийн хэрэгслээр явах боломжгүй зэрэг бэрхшээлтэй үед зайнаас мэдээлэл өгнө.

Хамт олонд тулгуурласан сэргээн засах хөтөлбөрийн\ХОТСЗХ\ мэргэжилтнүүд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хөгжүүлэх, тэдэнтэй ижил тэгш харьцан, ашигтай хувилбаруудыг санал болгох үүрэгтэй. ХОТСЗХ нь хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудыг байгууллагуудад ажил хийхэд нь туслах, зайны сургалтанд хамруулах, тасралтгүй боловсрол эзэмших боломжийг олгож өгдөг. ХОТСЗХ нь хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрэгчдэд өөрт хэрэгцээтэй дэмжлэгүүдийг олж авах, тухайлбал: интернэт, компьютерийн орчин, холболтууд\, зайны сургалтанд хамрагдах боломжуудыг олж авах ур чадварт сургах, өөртөө итгэх итгэлийг нь улам нэмэгдүүлэхэд тусалдаг.

Жишээ 53 Энэтхэг

Нэмэлт\бодит\ боловсрол

Ёосип бол 27 настай, Малайзын Жоржтаунд амьдардаг ба 14 жилийн өмнөөс саажилттай болжээ. Тэрээр их сургуулийн зайны сургалтын хөтөлбөрт хамрагдан, утга зохиолын ангид сурдаг. Ёосип хэлэхдээ үргэлж мэргэжлийн цол зэрэг ахихыг хүсч байдаг бөгөөд долоон ах дүүгийнхээ үлгэр дуурайлал болж байна. Тэр онлайнаар өөрт хэрэгтэй сургалтын модуль, видеог олж авч суралцдаг.



Хувь хүн болон бүлгийн тухайлсан хэрэгцээт сургалтыг дэмжих нь

ХОТСЗХ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүссэн ур чадварыг нь эзэмшүүлэх, дэмжлэг авахыг хүсч буй хувь хүн болон бүлэг хүмүүст суралцах боломжийг бүрдүүлж өгч тусалдаг.

ХОТСЗХ нь зайны сургалтанд хамруулах, дадлагажуулах, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг сургуульд оруулах зэрэг боломжтой зүйлүүдэд бүрэн дэмжлэг үзүүлж байдаг. Тэд хэл соёлын чиг хандлагыг дэмжихын тулд үндэсний цөөнх болсон зарим хүмүүст дэмжиж тусалдаг.

Урт наслах, эрүүл амьдрахад суралцах боломжууд

ХОТСЗХ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүссэн ур чадварыг нь эзэмшүүлэх, дэмжлэг авахыг хүсч буй хувь хүн болон бүлэг хүмүүст суралцах боломжийг бүрдүүлж өгч тусалдаг.

ХОТСЗХ нь зайны сургалтанд хамруулах, дадлагажуулах, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг сургуульд оруулах зэрэг боломжтой зүйлүүдэд бүрэн дэмжлэг үзүүлж байдаг. Тэд хэл соёлын чиг хандлагыг дэмжихын тулд үндэсний цөөнх болсон зарим хүмүүст дэмжиж тусалдаг.

Нийгмийн оролцоог дэмжихэд багш нартай ажиллах

Нийгэмд хүлээн зөвшөөрөгдөхгүй байх нь хувь хүний хүчин зүйлээс илүүтэйгээр гадаад хүчин зүйл илүү их нөлөөлдөг.

Хамт олны сургагч багш нь Худалдааны сургууль, хувийн боловсролын байгууллагууд, олон нийтийн сургууль, улсын болон хувийн байгууллагуудын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрэлт хэрэгцээг илрүүлэн амьдралын турш суралцах үйл ажиллагаанд тэднийг татан оролцуулдаг.

ХОТСЗХ нь олон нийтийн байгууллагуудтай хамтран ажилладаг бөгөөд ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага, эцэг эхийн нийгэмлэгтэй ажлын туршлагаа солилцох, хөгжлийн бэрхшээлийн тухай мэдээлэлээ сайжруулах, амьдралын турш суралцах боломжинд бүх талаар дэмжлэг үзүүлэх зэрэг ажлуудыг давхар хийж гүйцэтгэдэг. Хамт олны сургагч багш нь боловсролын байгууллагууд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хооронд нь хамтран ажиллах нөхцлийг бүрэлдүүлж өгөх, олон нийтийн байгууллагын гишүүдтэй танилцахад нь туслах, хамт олонтойгоо мэдлэг, ур чадвараа хуваалцахад нь бүхий л талын дэмжлэг үзүүлэн нийгмээс ялгаварлан гадуурхагдахаас хамгаалахын төлөө ажилладаг билээ.

Ашигласан материалууд

1. Dakar Framework for Action: Education for All. Paris, UNESCO, 2000 (<http://unesdoc.unesco.org/images/0012/001211/121147E.pdf>, accessed 5 May 2010).
2. Universal Declaration of Human Rights. New York, United Nations, 1948 (www.un.org/en/documents/udhr/, accessed 5 May 2010).
3. Convention on the Rights of the Child. New York, United Nations, 1989 (www.un.org/documents/ga/res/44/a44r025.htm, accessed 5 May 2010).
4. Convention on the Rights of Persons with Disabilities. New York, United Nations, 2006 (www.un.org/disabilities/, accessed 30 March 2010).
5. Education for all by 2015. Will we make it? Education for All global monitoring report 2008. Paris, UNESCO, 2007 (<http://unesdoc.unesco.org/images/0015/001548/154820e.pdf>, accessed 5 May 2010).
6. Children with disabilities. Paris, UNESCO (undated) www.unesco.org/en/inclusive-education/children-with-disabilities, accessed 5 May 2010).
7. Millennium development goals. New York, United Nations (undated) (www.un.org/millenniumgoals/, accessed 5 May 2010).
8. Jonsson T, Wiman R. Education, poverty and disability in developing countries. In: Poverty reduction sourcebook. Washington, DC, World Bank, 2001.
9. Guidelines for inclusion: ensuring access to Education for All. Paris, UNESCO, 2005 (<http://unesdoc.unesco.org/images/0014/001402/140224e.pdf>, accessed 5 May 2010).
10. Paez E. Child soldiers in Colombia. Enabling Education Newsletter, No. 7, 2003 (www.eenet.org.uk/resources/eenet_newsletter/news7/index.php, accessed 5 May 2010).
11. The Convention in brief, Article 24. New York, United Nations Enable (undated) (www.un.org/disabilities/default.asp?id=162, accessed 5 May 2010).

12. Education for All by 2015. Paris, UNESCO (undated) (http://portal.unesco.org/education/en/ev.php-URL_ID=42579&URL_DO=DO_TOPIC&URL_SECTION=201.html, accessed 5 May 2010).
13. Education for All global monitoring report. Strong foundations: early childhood care and education. Paris, UNESCO, 2007 (<http://unesdoc.unesco.org/images/0014/001477/147794e.pdf>, accessed 5 May 2010).
14. Arnold C et al. 2000. Bringing up children in a changing world: Who's right? Whose rights? Kathmandu, UNICEF/Save the Children, 2000.
15. Watanabe K et al. Early childhood development interventions and cognitive development of young children in rural Vietnam. *Journal of Nutrition*, 2005, 135(8):1918–25.
16. Werner D. Disabled village children: a guide for community health workers, rehabilitation workers, and families, 2nd ed. Berkeley, CA, Hesperian Foundation, 1988 (www.hesperian.org/publications_download_DVC.php, accessed 5 May 2010).
17. Training in the community for people with disabilities. Geneva, World Health Organization, 1989 (www.who.int/disabilities/publications/cbr/training/en/index.html, accessed 5 May 2010).
18. Let's communicate, a handbook for people working with children with communication difficulties. Geneva, World Health Organization, 1997 (www.who.int/disabilities/publications/care/en/index.html, accessed 5 May 2010).
19. National Portage Association (www.portage.org.uk/, accessed 5 May 2010).
20. Achieve universal primary education. New York, World Bank (undated) (<http://ddp-ext.worldbank.org/ext/GMIS/gdmis.do?siteId=2&goalId=6&menuId=LNAV01GOAL2>, accessed 5 May 2010).
21. Steinfeld E. Education for all: the cost of accessibility. In: Education notes. Washington, DC, World Bank Education Advisory Service, 2005 (http://siteresources.worldbank.org/EDUCATION/Resources/Education-Notes/EdNotes_CostOfAccess_2.pdf, accessed 5 May 2010).
22. Miles S. Overcoming resource barriers (Paper presented at the International Special Education Congress (ISEC), Manchester, 24–28 July 2000) (www.isec2000.org.uk/abstracts/papers_m/miles_1.htm, accessed 5 May 2010).
23. Enabling Education Network. Newsletter No. 9, 2005 (www.eenet.org.uk/resources/docs/EENET%20newsletter%209%20FINAL.pdf, accessed 5 May 2010).
24. Enabling Education Network. Newsletter No. 10, 2006 (www.eenet.org.uk/resources/eenet_newsletter/news10/index.php, accessed 5 May 2010).
25. Stubbs S. Lessons from the South: pioneers of the future (Paper presented at the International Special Education Congress, Birmingham, 1995).
26. Miles S. Overcoming resource barriers: the challenge of implementing inclusive education in rural areas. Enabling Education Network, 2006 (www.eenet.org.uk/resources/docs/bonn_1.php, accessed 5 May 2010).
27. Stubbs S. Inclusive education: where there are few resources. Oslo, Norway, Atlas Alliance, 2002.
28. Enabling Education Network. Newsletter No. 7, 2003 (www.eenet.org.uk/resources/eenet_newsletter/news7/index.php, accessed 5 May 2010).
29. Magrab P. Towards inclusive practices in secondary education. Paris, UNESCO, 2003 (<http://unesdoc.unesco.org/images/0013/001322/132278e.pdf>, accessed 5 May 2010).

30. Lederman D. College and the disabled student. Inside Higher Ed, 2005 (www.insidehighered.com/news/2005/07/29/disabled, accessed 5 May 2010).
31. Government of Nepal. Non-formal education policy. Kathmandu, Ministry of Education and Sports Non-formal Education Center (NFEC), 2007 (www.doe.gov.np/download/download_722241686.pdf, accessed 5 May 2010).
32. Lifelong learning in the twenty-first century: the changing roles of education personnel. Geneva, International Labour Office, 2000 (www.ilo.org/public/english/dialogue/sector/techmeet/jmep2000/jmepr1.htm, accessed 5 May 2010).
33. National Institute of Open Schooling, India. Frequently asked questions (www.nios.ac.in/FAQ.htm, accessed 5 May 2010)

Цаашид уншихыг зөвлөж буй материал

- Access for all: how to make participatory processes accessible to everyone. London, Save the Children UK, 2000 (http://www.savethechildren.org.uk/en/54_5093.htm, accessed 10 May 2010).
- Arab Resource Collective (www.mawared.org, accessed 10 May 2010).
- Australian Government, Department of Education, Employment and Workplace Relations (www.dest.gov.au/sectors/higher_education/publications_resources/eip/disability_service_provision/default.htm, accessed 10 May 2010).
- Bernard Van Leer Foundation (www.bernardvanleer.org/, accessed 10 May 2010).
- Booth T. A perspective on inclusion from England. Cambridge Journal of Education, 1996, 26(1):87–99.
- Changing teaching practices: using curriculum differentiation to respond to student diversity. Paris, UNESCO, 2004 (<http://unesdoc.unesco.org/images/0013/001365/136583e.pdf>, accessed 10 May 2010).
- Child to Child (www.child-to-child.org/, accessed 10 May 2010).
- Community Networks for Developing Countries (http://diac.cpsr.org/cgi-bin/diac02/pattern.cgi/public?mode=public&pattern_id=12, accessed 10 May 2010).

ХОТСЗ ХАНДЛАГЫН МАТРИЦ

